

ЕСБХБ
БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН НИЙГМИЙН
БОДЛОГО

Захирлуудын Зөвлөл 2008 оны 5-р сарын 12-нд батлав

Байгаль орчны болон нийгмийн бодлого

| | | |
|-------------|---|----|
| A. | Энэ Бодлогын зорилго | 3 |
| B. | ЕСБХБ-ны үүрэг эрмэлзэл | 3 |
| C. | Байгаль орчны ба нийгмийн асуудлуудыг төслийн циклтай уялдуулах: ЕСБХБ-ны үүрэг хариуцлага | 7 |
| D. | ЕСБХБ олон нийгэд тайлагнах ба хариуцлага хүлээх | 12 |
| E. | Байгаль орчин ба нийгмийн өндөр ач тустай хөрөнгө оруулалтыг дэмжих, үүний дотор бусадтай хамтран ажиллах | 12 |
| F. | Улс орон болон салбарын стратеги | 12 |
| G. | Институцын ба Хэрэгжүүлэлтийн хэлцлүүд | 13 |
| Хавсралт 1: | А зэрэглэлийн төслүүд | 14 |
| Хавсралт 2: | ЕСБХБ -ны байгаль орчны ба нийгмийн Хасах жагсаалт | 17 |

Гүйцэтгэлийн шаардлага

| | | |
|-------|---|----|
| PR1: | Байгаль орчин болон нийгмийн үнэлгээ ба менежмент | 18 |
| PR2: | Хөдөлмөр ба ажиллах нөхцөл | 25 |
| PR3: | Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба бууруулах | 30 |
| PR4: | Нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба хамгаалалт | 35 |
| PR5: | Газар эзэмшил, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн шилжилт хөдөлгөөн | 40 |
| PR6: | Биологийн олон төрхт байдлыг хадгалах ба байгалийн амьд баялгийн тогтвортой менежмент | 50 |
| PR7: | Нутгийн уугуул хүмүүс | 57 |
| PR8: | Соёлын өв уламжлал | 66 |
| PR9: | Санхүүгийн зуучлагчид | 71 |
| PR10: | Мэдээллийг ил тод болгох ба хувь эзэмшигчдийн оролцоо | 78 |

ЕСБХБ -ны Байгаль орчин болон Нийгмийн бодлого

А. Энэ Бодлогын зорилго

1. ЕСБХБ нь “байгаль орчинд халгүй тогтвортой хөгжлийг” өөрийн хөрөнгө оруулалтын болон техникийн хамтын ажиллагааны нэгж бүрт хөхүүлэн дэмжих явдлыг өөрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон ЕСБХБ-ийг байгуулах тухай гэрээний дагуу хэрэгжүүлэх чин эрмэлзэлтэй болно¹. Банк² нь тогтвортой хөгжил бол сайн бизнес менежментийн суурь үзүүлэлт гэдэгт итгэдэг. Иймээс ЕСБХБ-ны зах зээлд үндэслэсэн эдийн засагт шилжих, хувийн бизнесийг хөхүүлэн дэмжих зорилт, мөн түүний тогтвортой хөгжлийн төлөөх үүрэг эрмэлзэл нь маш нягт уялдаа холбоотой. ЕСБХБ-ны санхүүжүүлж байгаа бүх төсөл нь тус нэмэр болох, шилжилтийн нөлөө болон сайн банкны системтэй байх талаархи Банкны ажиллагааны гол зарчмуудыг хангасан байх ёстой. Үүнээс гадна, Тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх явдал ЕСБХБ -ны нэн тэргүүний зорилтуудын дунд байх ёстой гэж Банк үзэж байна.
2. Энэ бодлого тогтвортой хөгжлийн байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг багтааж байна. Энэ бодлогын зорилтын үүднээс нийгмийн асуудал нь дараахийг хөндөж байна: (i) мэргэжлийн эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааг оролцуулсан хөдөлмөрийн стандарт ба ажлын нөхцөл болон (ii) нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал, хүйс хоорондын тэнцүү байдал, нутгийн уугуул хүмүүсийн нөлөө болон соёлын өв уламжлал, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт болон үндсэн үйлчилгээний хүрэлцээ хүртээмж зэрэг нийгмийн бүлгийн нөлөө. Бодлого нь Банк байгаль орчны болон нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилтоо хэрхэн практикт хэрэгжүүлэхийг тодорхойлж байна, үүнд:
 - Өөрийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчны болон нийгмийн асуудлыг төвд нь тавих ;
 - Үйлчлүүлэгчдээ байгаль орчны болон нийгмийн ажиллагааны шаардлагуудыг тогтоож тэд нар тэдгээрийг Банкнаас хүлээн зөвшөөрсөн цаг хугацаанд биелүүлэх ёстой;
 - Бодлого болон гүйцэтгэлийн шаардлагын дагуу тогтвортой үр дүнд хүрэхэд ЕСБХБ болон түүний үйлчлүүлэгчдийн холбогдох үүрэг хариуцлагыг тодорхойлох;
 - Байгаль орчны болон нийгмийн өндөр ач холбогдолтой төслүүдийг дэмжих стратегийн зорилтыг тодорхойлох.

В. ЕСБХБ-ны үүрэг эрмэлзэл

3. ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн үнэлгээ болон мониторингийн процессоор дамжуулан түүний санхүүжүүлж буй төслүүд нь:
-

¹ ЕСБХБ-ийг байгуулах тухай хэлэлцээрийн 2-р зүйлийн 2.1 (vii)-г үзнэ үү

² Энэ бодлогод “ЕСБХБ” болон “Банк” гэсэн нэр томъёог хооронд нь сольж хэрэглэж болно.

- нийгмийн болон байгаль орчны хувьд боломжийн ;
- ажиллгааны нөлөөнд өртсөн ажилчдын ба нийгмийн бүлгүүдийн эрхийг хүндэтгэж байгаа;
- холбогдох хуулийн шаардлага болон олон улсын тэргүүний практикийн дагуу ажиллахаар төлөвлөгдсөн хийгээд ажиллаж байгаа явдлыг хангах арга замыг хайна.

3.Энэ зорилтыг амжилттайгаар бодит байдлаар хэрэгжүүлэхийн тулд Банк нь бүх зүйлийг, үүний дотор байгаль орчин болон нийгмийн нөлөө, асуудлуудын гол салбаруудыг хамарсан Гүйцэтгэлийн тодорхой шаардлагуудын багцыг /”ГШ/ баталсан бөгөөд түүнийг үйлчлүүлэгчид биелүүлэх ёстой. Банк нь гарын үсгээ зурсан Европын Холбооны байгаль орчны стандартыг, Байгаль орчны Европын Зарчмуудыг дэмжин хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд тэр нь “ГШ”³ -д тусгалаа олсон.Үйлчлүүлэгчид нь өөрсдийн төслүүдтэй холбоотой байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг үнэлж удирдаж, тэгснээр төслүүд “ГШ”-г хангана гэдэгт Банк итгэж байна. Банкны үүрэг нь дараахид оршино: (i) үйлчлүүлэгчийн үнэлгээг хянах; (ii) “ГШ”-т нийцүүлэн нийгмийн болон байгаль орчны сөрөг нөлөөнөөс зайлсхийх, хэрэв боломжгүй бол түүнийг аль болохоор багасгах, саармагжуулах, балансжуулах эсхүл нөхөн олговор олгоход чиглэсэн зохих үр дүн бүхий арга хэмжээг боловсруулахад үйлчлүүлэгчдэд туслах; (iii) байгаль орчны болон нийгмийн нэмэлт ашиг тусыг олох бололцоог тодорхойлоход нь туслах; ба (iv) Банк төслийн хувьд санхүүгийн сонирхолтой байх бүхий л хугацаанд ямар нэгэн төсөл⁴ байгаль орчны болон нийгмийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж байх.

4.Шилжилтийн системийн тогтвортой хөгжлийн цар хүрээг болон энэ салбар дахь стратегийн хандлагыг илүү тодоор тусгахын тулд Банк нь санал болгосон төслүүдийн⁵ шилжилтийн нөлөөний үнэлгээг сайжруулна.Тогтвортой хөгжлийн зорилтыг хөөсөн ЕСБХБ-наас санхүүжүүлэх аливаа төсөл Банкны шилжилтийн мандаттай бүрэн нийцсэн байх болно.

5. Банк нь төсөлд өртсөн нийгмийн бүлгүүдэд нийгэм-эдийн засгийн нэмэлт ач тус мөн боломжгүй бол төсөлд өртсөн талууд тэдгээр ач тусаас тэнцүү хүртэх зэрэг байгаль орчны болон нийгмийн нэмэлт ач тусыг хүргэх чадвартай төслүүдийг санхүүжүүлэхийг хайх болно. Цаг агаарын өөрчлөлтийг зөөлрүүлэх ба түүнд зохицон дасах, цөлжилтийг багасгах, биологийн төрхт байдлыг хадгалах, эрчим хүч болон нөөц баялгийг үр ашигтай ашиглах, ядуурлыг бууруулах, олигтой ажлаар хангахыг дэмжих, нийгмийн гадуурхлыг багасгах, үндсэн үйлчилгээгээр хангах, хүйсийн тэнцүү байдал, ил тод байдал болон зэрэг холбогдох ЕХ-ны стратегийг хэрэгжүүлэхэд дэм үзүүлэх, Бүс нутаг тулгарч байгаа байгаль орчны болон нийгмийн гол асуудлуудад чиглэсэн зүйл, заалтыг агуулсан төслүүдэд онцгой анхаарал тавина.

³ Байгаль орчны Европын Зарчмууд /EPE/-ын уг бичгийг www.eib.org/infocentre/epe/declaration/index.htm олж болно. EPE нь бол төслүүдийн санхүүжилттэй холбоотой байгаль орчны зарчим, практик ба стандартыг улам нийцүүлэх хөдөлгөөний харну саначилга юм. EPE-г ЕХ-ны Гэрээнд удирдлага болгох байгаль орчны зарчмууд хэмээн тодорхойлдог хийгээд ЕХ-ны хоёрдогч хууль тогтоомжинд оруулсан болно. EPE-ийн үүрэг эрмэлзлийг ГШ 1, 3, 4 ба 10-т тусгасан болно.

⁴ Энэ Бодлогын зорилгоор Банк нь худалдсан эсхүл санхүүжилтээс /өр эсхүл үнэт цаас/ хойшлуулсан төлбөрийн нөхцөлөөр гарсан тохиолдолд Банкныг уг төсөлд санхүүгийн сонирхолтой гэж тооцохгүй.

⁵ Төслийн шилжилтийг Банкны Ерөнхий эдийн засагчийн офис үнэлсэн бөгөөд нэмэлт мэдээллийг <http://www.ebrd.com/vountry/sector/econo/impact.htm> –с үзэж болно.

ЕСБХБ мөн санал болгож байгаа төслүүд нь хүлээн авагч улс орны хөгжилд тус нэмэр болж чадах, төсөлд өртсөн нийгмийн бүлгүүдэд эдийн засаг, нийгмийн болон байгаль орчны хувьд өргөнөөр тус дөхөм болж чадахыг харж үзнэ.ЕСБХБ үйлчлүүлэгчдэд тэдний үйл ажиллагааг үр ашигтай болгох, урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулах болон тэдний байгаль орчны болон нийгмийн менежментийн чадавхийг хүчтэй болгохын тулд тэдэнтэй хамтын нөхөрлөл тогтооно.

6. Банк нь цаг агаарын өөрчлөлтийг саармагжуулах ба түүнд зохицон дасах, мөн тэр нь Банкны бүс нутаг дахь ажиллагааны нэн тэргүүний асуудлын нэг болохын чухлыг хүлээн зөвшөөрч байна. Тэр цаг агаарын өөрчлөлтийн талаархи хандлагаа цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй бөгөөд ялангуяа хүлэмжний хийг бууруулах, дасан зохицолт, нөхөн сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх зэрэгт өөрийн ажиллагаандаа илүү их анхаарал тавих болно.

7. ЕСБХБ нь корпорацийн ил тод байхын зарчмууд ⁶, хариуцлага болон сонирхогч этгээдүүдийн оролцоог тууштай дэмждэг. Цаг тутмын үргэлжлэх үндсэн дээр тэр байгаль орчин болон нийгмийн асуудлуудархи Банкны ажил гүйцэтгэлийн тухай мэдээллийг нээж, ил тод болгох бөгөөд Банкны хувь эзэмшигчдийн бүлэгтэй үр дүнтэй харилцаанд орно. Банк ижил сайн практикийг өөрийн үйлчлүүлэгчдийн дунд дэлгэрүүлнэ. Ялангуяа, ЕСБХБ -ны үйлчлүүлэгчид сонирхогч этгээдүүдээ танин мэдэж, тэдэнтэй үргэлж харьцаж байна гэдэгт найдаж байна, мөн өртөж болохуйц нийгмийн бүлгүүдэд мэдээллийг нээлттэй болгох, харилцан зөвлөлдөх болон бодит мэдээлэлтэй оролцох замаар Банкны үзэж байгаагаар төсөлтэй холбоотой нөлөөтэй дүйцэхүйц арга хэмжээ хэмжээ болно. Сонирхогч этгээдүүдийн харилцан уялдаатай ажил Байгаль орчны асуудлаар ⁷ Мэдээлэл хүртэх, шийдвэр гаргахад олон нийт оролцох ба шүүхэд хандаж байх тухай НҮЕЭЗК-ын Конвенцийн мөн чанар, зорилго болон эрхэм зорилтуудтай болон ЕХ-ны Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээний тухай Удирдамжтай нийцэж байх ёстой бөгөөд олон улсын хил давах чадахуйц ноцтой нөлөөтэй төслүүдийн хувьд Байгаль орчинд үзүүлэх хил давсан нөлөөний үнэлгээний тухай НҮЕЭЗК –ийн Конвенцийн ⁸ заалтуудтай, батамжилсан эсэхийг үл харгалзан, нийцэж байх ёстой.

8. ЕСБХБ нь байгалийн олон төрөлхт байдал баялгийг (тухайлбал зэрлэг ан амьтан, усны болон ойн аж ахуйн бүтээгдэхүүн) хамгаалж хадгалах, менежмент явуулах ба зохих хэмжээ түвшинд хэрэглэх явдалд болгоомжтой хандахыг дэмждэг бөгөөд түүний ажиллагаа нь туйлын чухал орчинг хамгаалах, мөн боломжтой бол дэмжиж байгаа байгалийн орчин болон биологийн олон төрөлхт байдлыг бэхжүүлэх арга хэмжээг багтаасан байх явдлыг хангана.

9. ЕСБХБ нь өөрийн хөрөнгө оруулалтаараа байгаль орчин, хөдөлмөр, корпоратив хариуцлага⁹, байгаль орчны мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохтой холбоотой олон улсын хуулийн холбогдох зарчим болон журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх явдалд хувь нэмэр оруулахыг хичээх болно. Эдгээр зарчим болон журам нь Гэрээ, конвенци, олон талын, бүс нутгийн болон хоёр талын хэлэлцээр зэрэг хэрэгсэлд, мөн холбогдох биелүүлэх заавал бус хэрэгсэлд тусгагдсан байгаа болно. Мэдэж байвал ЕСБХБ нь төслийн үнэлгээний үед тодорхойлсон байгаль орчны хамгаалалт, хүний эрх болон тогтвортой хөгжилтэй хамаатай холбогдох олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн улс орны үүргийг зөрчсөн төслүүдийг хүүжүүлэхгүй.

⁶ Банк нь сайн засаглал, мөнгө угаах, хэзээ хахууль, орлогын ил тод байдал, тарифыг ил тод байлгахтай холбоотой онцгой шаардлагатай бөгөөд тэдгээрийг Банкны бусад бодлогын баримтуудад тусгасан болно.

⁷ “Эрхус конвенци”, www.unecce.org/env/pp/

⁸ “Эспу конвенци” www.unecce.org/env/eia/

⁹ Корпоратив хариуцлагатай холбоотой олон улсын хэмжээнд тохирсон хэрэгсэл нь Олон улсын үйлдвэр ба нийгмийн бодлогын хамаатай Зарчмуудын талаархи ОУХБ-ын Гурван талын тунхаглал, ба ЭЗНХБ-ын олон улсын үйлдвэрүүдэд зориулсан Удирдамж.

10. ЕСБХБ үйл ажиллагаа явуулж байгаа улс орнуудад бүс нутгийн болон салбарын түвшинд тогтвортой хөгжлийг дэмжихэд үр дүнтэй оролцоог зохицуулан уялдуулахад олон улсын бусад санхүүгийн байгууллага, Европын холбоо, хоёр талын донор, НҮБ-ын агентлагууд болон бусад байгууллалатай хамтран ажиллана. Төслүүдийг олон улсын бусад санхүүгийн байгууллагатай хамтран санхүүжүүлэх тохиолдолд төслийн үнэлгээ, төслийн шаардлага болон мониторингийн талаар нэгдсэн хандлагыг тохирохын тулд тэдэнтэй хамтран ажиллана.

11. Өөрийн техникийн хамтарсан ажиллагаагаар дамжуулан ЕСБХБ өөрийн санхүүжүүлж байгаа төслүүдийг чанаржуулахын тулд чадамжийг дээшлүүлэх хөтөлбөр болон хамтын ажиллагааны бусад хэлбэрээр хангах талаарх дэмжлэгийг бүрдүүлэхийг эрмэлзэх болно, тухайлбал тогтвортой бизнесийн практик болон корпоратив хариуцлагыг дэмжих, ажиллагаа явуулж байгаа улс орондоо байгаль орчны ба нийгмийн асуудлыг судлах болон удирдах шаардлагатай чадамжийг бий болгох эсхүл Банкнаас санхүүжүүлж байгаа төслүүдийн ашиг тусыг шударгаар хүртэх боломжийг нэмэгдүүлэх замаар.

12. ЕСБХБ бодлогын харилцан хэлэлцүүлэгт оролцон, зохимжтой тохиолдолд тогтвортой хөгжилтэй холбоотой бүтцийн болон өвөрмөц байдлын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд засгийн газрууд болон бусад түнштэй ажиллахад техник туслалцаа үзүүлнэ.

13. Өөрийнхөө дотоод ажиллагаанд ЕСБХБ байгаль орчны менежмент (үүнд эрчим хүч болон нөөц баялгийн үр дүнтэй ашиглалт, хаягдлын бууралт болон дахин ашиглалт) болон хүний нөөцийн менежмент (үүнд ижил бололцоо, ажил/амьдралын тэнцвэр, эрүүл мэнд болон аюулгүй үйл ажиллагаа)-ийн шилдэг практикийг дагаж мөрдөнө. ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн ижил өндөр стандартыг баримталдаг нийлүүлэгч болон гэрээт гүйцэтгэгчидтэй ажиллахыг хичээнэ. Дотоодоос бараа, үйлчилгээ нийлүүлэхэд Банк тогтвортой байдлын асуудлыг анхааралдаа авна.

С. Төслийн циклд байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг уялдуулж оруулах: ЕСБХБ-ны үүрэг роль ба хариуцлага

Төслийн үнэлгээний процесс

Ерөнхий хандлага

14. ЕСБХБ-наас санхүүжүүлэх бүх төсөлд байгаль орчны болон нийгмийн үнэлгээ хийх бөгөөд ингэхдээ нэгт, аливаа ажиллагааг санхүүжүлбэл зохино гэсэн шийдвэр гаргахад ЕСБХБ-д туслах, хоёрт, төлөвлөлт, санхүүжилт болон хэрэгжилтэд байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг хэрхэн авч үзэх арга замыг тодорхойлно. ЕСБХБ-ны нийгмийн болон байгаль орчны үнэлгээ ЕСБХБ-ны төслийн ерөнхий үнэлгээнд ордог бөгөөд үүнд санхүүгийн болон нэр хүндийн эрсдлийн үнэлгээ, мөн байгаль орчны болон нийгмийн боломж бололцоог илрүүлэх ажил багтдаг. Энэхүү үнэлгээ нь төслийн мөн чанар болон цар хүрээнд зохистой бөгөөд байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөнд зохимжтой юм. Үнэлгээ нь УШХБ-ны санхүүжилтээр дэмжигдэх ажиллагааг энэ Бодлогын ба Гүйцэтгэлийн шаардлага /"ГШ"/-ын дагуу хэрэгжүүлж болох эсэхийг тогтооно. Шаардлагатай зохих хичээн зүтгэнгүй судалгаа, мэдээллийн нээлттэй байдал болон сонирхогч этгээдүүдийн оролцоог ГШ 1-ээс 10 хүртлэхийн дагуу хийгдэж, ЕСБХБ-нд түүний үнэлгээний нэг хэсэг болон хянуулах явдал үйлчлүүлэгчийн хариуцлага болно. ЕСБХБ хүргүүлсэн мэдээллийг хянаж үзэх бөгөөд хэрхэн төсөл Банкны шаардлагыг хангаж чадах талаар удирдлага өгнө.

15. ЕСБХБ-ны байгаль орчны болон нийгмийн үнэлгээнд гурван түлхүүр бүрэлдэхүүн хэсгийн хэлэлцүүлгийг багтаана: (i) нь байгаль орчны болон нийгмийн нөлөө ба санал болгосон төсөлтэй холбогдсон асуудлууд, (ii) тэдгээр нөлөө болон асуудлуудыг Бодлогын дагуу авч шийдэх үйлчлүүлэгчийн чадамж ба чин эрмэлзэл, ба (iii) Уг Бодлоготой нийцэх явдлыг хангахад гуравдагч талуудын үүрэг, роль.

16. ЕСБХБ санал болгосон төслийг байгаль орчны болон нийгмийн үндэслэлээр санхүүлэхээс татгалзаж болно, тухайбал, санал болгосон төсөл нь байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг зохих ёсоор авч шийдэж чадахгүй, энэ Бодлогын холбогдох ГШ-д туссан шаардлагуудыг Банкнаас зохимжтой гэж үзсэн хугацаанд хангаж чадахгүй, эсхүл үлдэгдэл нөлөөг хүлээн зөвшөөрөх боломжгүй байх. Үүнээс гадна, ЕСБХБ санхүүжилт хийдэггүй хэд хэдэн төрлийн ажиллагаа байдаг. Тэдгээрийн жагсаалтыг 2-р хавсралтаас үзнэ үү.

17. Энэ Бодлогод “төсөл” гэсэн нэр томъёо нь ЕСБХБ-ны ажиллагааны нэр төрлөөс үл шалтгаалан ЕСБХБ-наас үйлчлүүлэгчээс санхүүжилт хүссэн бизнесийн ажиллагаанд хамаарна. ЕСБХБ-ны ажиллагаа нь (өөрөөр хэлбэл санхүүжилт өгөх үйл явдал) санал болгосон төслүүдэд зориулсан янз бүрийн нэр төрлийн санхүүжилтээс бүрдэнэ, тухайлбал төслийн санхүүжилт/хязгаарлагдмал туслалцаатай санхүүжилт, корпоратив санхүүжилт, ажлын капитал, холимог үнэт цаас, үнэт цаас эсхүл буцалтгүй тусламж.

18. ЕСБХБ хэд хэдэн Тусгай сан болон хамтын ажиллагааны санг захирдаг. Бүхэлдээ эсхүл хэсэгчлэн Тусгай сангаас санхүүжигдсэн төсөл эсхүл ажиллагаа нь энэ Бодлоготой нийцэж байх ёстой. Хамтын ажиллагааны сангийн тухайд гэвэл энэ Бодлого мөн хамаарна; гэхдээ байгаль орчны болон нийгмийн асуудалтай холбогдолтой донорын нэмэлт шаардлага тавигдаж болно, гэхдээ тэд энэ Бодлоготой нийцэж байх ёстой.

Зэрэглэл

19. ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн санал болгосон төслүүдийг А/В/С/FI гэж зэрэглэдэг: (i) санал болгосон төсөлтэй холбогдсон байгаль орчны болон нийгмийн боломжит нөлөө болон асуудлуудын түвшинг харуулах ба (ii) байгаль орчны болон нийгмийн нөлөө, асуудлуудыг анхааралдаа авч төслийн мөн чанар, байршил, мэдрэмж болон цар хүрээ, төсөл бүрт шаардагдах байгаль орчны болон нийгмийн судалгаа, мэдээллийн нээлтэй байдал болон хувь эзэмшигчдийн оролцооны мөн чанар, түвшинг тодорхойлох.

Шууд хөрөнгө оруулалтын ажиллагаа¹⁰

20. Санал болгосон төсөл нь зэрэглэл тогтоох үед илрүүлэх, тогтоох амаргүй байхад ирээдүйн байгаль орчин болон нийгмийн нөлөө болон асуудалд ноцтой бөгөөд олон төрлийн сөрөг нөлөөлөл үзүүлэх ноцтой сөрөг олон хэлбэрийн дагавартай, мөн албан ёсны оролцогчдын үнэлгээний процессыг бие даасан гуравдагч талын мэргэжилтнүүд ГШ-ын дагуу хийхийг шаардах тохиолдолд А зэрэглэлтэй гэж ангилдаг. А зэрэглэлийн төслүүдийн оролцоо жагсаалтыг энэ Бодлогын 1-р хавсралтад заасан болно.

21. Санал болгосон төсөл нь үүсч болох сөрөг байгаль орчны ба/эсхүл нийгмийн үзэгдэл нь тухайн газар орчинд түгээмэл бөгөөд түүнийг сэргийлэх арга хэмжээгээр түргэн илрүүлж засч болох бол түүнийг Б зэрэглэлийнх гэж ангилна. Тэр нөлөө нь хуучин үеэс, өнөөгийн үеэс эсхүл ирээдүйн ажиллагаанаас үүсэлтэй байж болно. Зохих ажиллагааны шаардлага нь тухайн төслөөс шалтгаалан янз бүр байж болох бөгөөд түүнийг ЕСБХБ-тай төсөл төслөөр ГШ 1-ийн дагуу зохицуулбал зохино.

22. С зэрэглэл гэж ангилсан санал болгосон төсөл нь байгаль орчин болон нийгэмд бага эсхүл сөрөг нөлөө үзүүлэхгүй байх бөгөөд тиймээс зэрэглэлээс хэтэрсэн нэмэлт байгаль орчны эсхүл нийгмийн үнэлгээг шаардахгүй болно.

23. Байгаль орчны болон нийгмийн анхны судалгаа (БОНАС)-г ЕСБХБ-ны байгаль орчны болон нийгмийн судалгаачид зэрэглэл тогтоох болон зохих анхааралтай ажиллагаа явуулах мэдээлэл зэрэглэл тогтоох үед шаардагдах мэдээлэл байхгүй үед явуулна.

Санхүүгийн зуучлалын ажиллагаа

24. Хэрэв ЕСБХБ санхүүгийн зуучлагчид /СЗ/ санхүүгийн тусламж үзүүлэх нөхцөлд санал болгосон төслийг FI гэж ангилна. СЗ-тай ажиллах нь ЕСБХБ-ны хувьд тогтвортой санхүүгийн зах зээлийг дэмжих, мөн ЕСБХБ-ны санхүүжилтийг бичил, жижиг ба дунд хэмжээний үйлдвэрүүдэд дамжуулах арга хэлбэрийн түлхүүр болох юм. Тэд бусдын хамт хувийн хувьцаат сан, банк, түрээслэгч компани, даатгалын компани болон тэтгэврийн сангуудыг багтаана. СЗ-тай холбоо тогтоохын өмнө ЕСБХБ нь СЗ, түүний багцаанд судалгаа хийж, (i) СЗ-ийн байгаль орчин болон нийгмийн бодлого, горим журамд Банкны ГШ 9-ны дагуу судалгаа хийж тэднийг биелүүлэх чадамжинд үнэлгээ өгнө, мөн (ii) СЗ-ийн байгаль орчны болон нийгмийн асуудлуудтай холбоотой одоо байгаа багц ирээдүйд бий болж магадгүй багцанд зохистой ажиллагаа явуулна.

Сонирхогч этгээдүүдийн оролцоо

25. ГШ 10 нь хэрэгжүүлэх төслүүдэд өртөж болзошгүй сонирхогч этгээдүүдийг тогтоож, төслүүдээс үүсэх асуудал болон нөлөөний талаар хангалттай мэдээлллийг ил тод болгож, сонирхогч этгээдтэй ойлгомжтой, соёлтой харьцахыг шаарддаг. Зарим тохиолдолд Банк нь А зэрэглэлийн төслийн талаар түүнийг санхүүжүүлэхэд Банкны үүрэг ролийн талаар сонирхолгч этгээдийн санал бодлыг тодруулахаар өөрийн олон нийтийн хэлэлцүүлгийг явуулж болно. Зохимжтой бол Банкны техникийн хамтын ажиллагаанд сонирхогч этгээдүүдийг тодруулах, оролцуулах ажиллагаа орж болно.

26. Ажиллагааг зөвшөөрөх тухай ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөлд хүргэх баримт бичгүүд дараахийг багтаана: үйлчлүүлэгчийн сонирхогч этгээдүүдийн оролцооны хөтөлбөрийн тухай тойм, үйлчлүүлэгчийн ажлын тухай, мөн төслийн нөлөөний талаар сонирхогч этгээдүүдээс гаргасан санал бодол, түүнээс гадна тэдгээр асуудлыг үйлчлүүлэгч ГШ 10 дагуу шийдэх арга зам, санал бодол. Захирлуудын зөвлөл Банкны ажиллагааны нийт ашиг тус ба эрсдлийг үнэлэх явдлын нэг хэсэг болгон өөрийн шийдвэр гаргах процесст сонирхогч этгээдүүдийн санал бодлыг анхааралдаа авна.

Гүйцэтгэлийн шаардлага (ГШ)

27. Банкнаас санхүүжүүлэх төслүүд тогтвортой хөгжилтэй хамаатай олон улсын сайн практикийг хангах ёстой. Үүнийг хүрэхийн тулд үйлчлүүлэгчдэд болон эсхүл төслүүдэд туслахын тулд Банк тусгай ГШ-дыг байгаль орчин болон нийгмийн асуудал, нөлөөний талаар дор дурьдсанаар боловсруулсан болно:

- ГШ 1 – Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ ба менежмент
- ГШ 2 – Хөдөлмөрийн болон ажлын нөхцөл
- ГШ 3 – Бохирдлоос сэргийлэх ба багасгах
- ГШ 4 – Нийгмийн бүлгүүдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал
- ГШ 5 - Газрыг өөрийнх болгох, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн шилжилт хөдөлгөөн
- ГШ 6 – Биологийн олон төрөлхт байдлыг хамгаалах ба Тогтвортой байгалийн баялаг, нөөцийн менежмент
- ГШ 7 – Уугуул хүмүүс
- ГШ 8 – Соёлын өв
- ГШ 9 – Санхүүгийн зуучлагчид
- ГШ 10 – Мэдээллийг ил тод болгох ба Сонирхогч этгээдүүдийн оролцоо

ГШ 8- 10 нь шууд хөрөнгө оруулалтын ажиллагааны талаархи шаардлагыг багтаана, ГШ 2- 9 нь санхүүгийн зуучлалын ажиллагаанд хамаатай. ГШ тус бүр зорилгодоо хүсч буй үр дүнг тодорхойлох бөгөөд түүний араас тэрхүү үр дүнд хүрэхэд үйлчлүүлэгчдэд туслах тусгай шаардлагууд хөвөрнө. Бүх ГШ-ын салшгүй хэсэг бол тухайн улс орны холбогдох хуулиудыг даган мөрдөх явдал юм. .

28. ЕСБХБ бүх үйлчлүүлэгдэсээ төслөө зохиохдоо холбогдох бүх ГШ-ыг хангасан байхыг шаардана. Энэ бүхний гол зүйл бол ажилчид, орон нутаг болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, эсхүл боломжтой бол тэрхүү нөлөөг боломжийн хирээр багасгах яюдал юм. ГШ нь мөн үйлчлүүлэгчдэд өөрийн бизнесийн ажиллагаагааны тогтворжилтыг сайжруулах найдвартай үндсийг бэхжүүлэх боломж олгох учиртай.

29. ЕСБХБ-наас санхүүжүүлэх сонирхолтой байгаа шинэ санаачилгэ эсхүл бизнесийн ажиллагаа ГШ-ын шаардлагыг эхнээс нь биелүүлэх хэрэгтэй. Хэрэв ЕСБХБ-аас санхүүжүүлэхийг хүссэн бизнесийн ажиллагаа Зөвлөлийн хурлын үед ГШ-ыг хангахгүй байгаа үйл ажиллагаатай холбоотой бол үйлчлүүлэгч ЕСБХБ-ны хүлээн зөвшөөрөх хугацаанд ЕСБХБ-нд нийцэх, техникийн болон санхүүгийн хувьд биелэгдэх боломжтой хийгээд зардал багатай Байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө/БОНАХТ/-г боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Хэрэв Банкны ажиллагаа корпоратив ерөнхий санхүүжилт, ажлын капитал эсхүл хувьцааны санхүүжилтийг олон талбайт компанид өгөх бол үйлчлүүлэгч БОНАХТ-г компанийн түвшинд боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай /талбай өвөрмөц түвшний эсрэгээр/.

30. Хэрэв тухайн төслийн шинж байдлын улмаас 27-29-р зүйлд зааснаас өөр арга зам шаардлагатай бол тийм арга замыг Зөвлөл тухай бүр авч хэлэлцэнэ. Зөвлөл энэ Бодлогод ямар нэгэн өөрчлөлт оруулах тухай асуудлыг шийдэхдээ шинээр санал болгож байгаа арга замыг ерөнхий байгаль орчны ба/эсхүл төслийн нийгмийн өртөг ба ашиг тусын асуудалтай уялдуулан авч хэлэлцэнэ.

31. Ямар ч тохиолдолд төсөлд тавих шаардлагуудыг Төслийн нэгтгэсэн баримт бичигт нэгтгэн оруулж, Захирлуудын Зөвлөлд тайлагнана.

Гуравдахь талын гүйцэтгэл

32. Зарим үед нийгмийн болон байгаль орчны зорилгыг ГШ-д нийцүүлэн биелүүлэх үйлчлүүлэгчийн чадвар гуравдахь талын ажиллагаанаас шалтгаална. Гуравдахь тал нь заримдаа төсөл/үйлчлүүлэгч ихээхэн холбоотой байсан засгийн газрын байууллага. гэрээт гүйцэтгэгч, нийлүүлэгч эсхүл холбогдоа үйлдвэрлэлийн оператор байж болно. ЕСБХБ нь өөрийнхээ санхүүжүүлж байгаа төслүүд гуравдахь талын үйл ажиллагаанаас шалтгаалах ч гэсэн ГШ-д нийцэх үр дүнг авчрахыг эрэлжийлж байна. Гуравдахь талын эрсдэл өндөр, эсхүл гуравдахь этгээдийн ажиллагаа, бие авч явах байдалд үйлчлүүлэгч хяналт нөлөө үзүүлдэг гэсэн ч ЕСБХБ үйлчлүүлэгчээс ГШ-ын зорилгод нийцэх үр дүнд хүрэхийн тулд үйлчлүүлэгчийг гуравдахь талтай хамтран ажиллахыг шаардана. Өвөрмөц шаардлага болон авах арга хэмжээг төсөл төслийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

Хуулийн баримт бичиг

33. Төслийн талаар ЕСБХБ-наас үйлчлүүлэгчдтэй байгуулах хөрөнгө оруулалтын гэрээ нь ЕСБХБ-ны байгаль орчин, нийгэм, сонирхогч этгээдүүдийн оролцоог тусгасан өвөрмөц заалтуудыг багтаана. Үүнд бүх холбогдох ГШ ба БОНАХТ-тэй /хэрэв байгаа бол/ нийцэх шаардлага, мөн тухайлбал байгаль орчны болон нийгмийн тайлагналын тухай заалтууд, явагдаж байгаа сонирхогч этгээдүүдийн оролцоо, бие даасан мэргэжилтнүүдээс үе үе хийх аудит, “Төслийн дуусвар” гэсэн нэр томъёонд байгаль орчны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг оруулах, гарцын аудит, ба/эсхүл зохимжтой бол ЕСБХБ-ны ажилтнууд эсхүл төлөөлөгчдөөс мониторингийн үзлэг явуулах г.м. орнр. Хуулийн баримтууд нь зохимжтой бол мөн хуулийн гэрээний хугацаанд зээлдэгч эсхүл хөрөнгө оруулагч байгаль орчны болон нийгмийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд Банкны эрх болон сонирхлоо хамгаалах заалтуудыг оруулна.

Мониторинг

34. Банк нь төслүүдийн байгаль орчны болон нийгмийн үзүүлэлтүүдэд мониторинг хийж байхыг чухал гэж үздэг. Мониторинг хэд хэдэн зорилгод үйлчилнэ. Нэгдэх нь бол холбогдох стандарт болон янз бүрийн байгаль орчны болон нийгмийн зүйл ангиуд хуулийн гэрээнд орсон байх явдал, жишээлбэл БОНАХТ-г биелэлтийг үлэмж хангасан байх. Хоёрдах нь бол хөрөнгө оруулалттай холбоотой үүсч буй байгаль орчны болон нийгмийн нөлөөг ажиглан мөрдөж байх хийгээд саармагжуулах арга хэмжээнүүдийн үр ашгийн тухай мэдээлэллээр эргэн хангаж байх. Эцэст нь төслийн хэрэгжилтийн үед олсон сайжруулалтыг ажиглаж бүртгэснээр мониторингийн мэдээ нь Банкны хөрөнгө оруулалт нь төслийн ба багцын түвшинд тогтвортой хөгжилд ямар тус нэмэр болж байгаагийн үзүүлэлт болох учиртай.

35. Мониторингийг үйлчлүүлэгч болон Банк аль аль нь хэрэгжүүлнэ. Мониторингийн цар хүрээ төслийн асуудлууд, нөлөө болон дагаж мөрдөх шаардлага, мөн үйлчлүүлэгч эсхүл орон нутгийн засаг захиргаа тэдгээр асуудал болон нөлөөг хэрхэн ажиглаж, менежмент хийх чадвараас шалтгаална. Банк нь үйлчлүүлэгчтэй хамтарч төсөл бүр дээр мониторингийн хөтөлбөрийг үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд ГШ 1 эсхүл ГШ 9 –ийн дагуу боловсруулж, зохих ёсны гүйцэтгэлийн үр дүн, олон нийтийн аливаа зөвшөлцөөний үр дүнгийн суурин дээр зохих мониторингийн арга барилыг ялгаатайгаар тогтооно.

36. Тохирсон байгаль орчны болон нийгмийн үзүүлэлтүүд, БОНАХТ-г зохих ёсоор цаг хугацаанд нь биелүүлж байгааг баталгаажуулахын тулд Банк нь төсөлд санхүүгийн сонирхолтой байх хугацаанд төслүүдэд мониторинг хийж, үйлчлүүлэгчидтэйгээ мониторингийн үр дүнг хуваалцаж байна ¹¹. Мониторингийн механизм (i) БОНАХТ болон байгаль орчны болон нийгмийн бусад шаардлагын биелэлтийн талаар үйлчлүүлэгчээс ирүүлэх үе үеийн /наад зах нь жилд нэг удаа/ тайланг хянан шалгах; (ii) үйлчлүүлэгч БОНАХТ-г биелүүлэх, байгаль орчны болон нийгмийн шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг тогтоохын тулд ноцтой нийгмийн болон байгаль орчны асуудал, нөлөөтэй хөрөнгө оруулалтыг Банкны байгаль орчны болон нийгмийн мэргэжилтнүүд эсхүл зөвлөхүүдээр нарийвчлан шалгуулсан шалгалтын үр дүнд мониторингийг хийх; and (iii) гуравдахь талын үе үеийн мониторинг, тухайлбал үйлчлүүлэгч болон Банкинд хүргүүлсэн орон нутгийн бие даасан мэргэжилтнүүд эсхүл төлөөлөгчдөөр хийлгүүлэх .

37. Үнэлгээ эсхүл өмнөх мониторингийн ажиллагаанаас хойш нийгмийн ба байгаль орчны сөрөг нөлөө тулгарахаар нөхцөл байдал өөрчлөгдсөн бол ЕСБХБ тэдгээрийг даван туулах төлөвлөгөөг боловсруулахын тулд үйлчлүүлэгчтэй хамтран ажиллана. Хэрэв үйлчлүүлэгч БОНАХТ болон бусад хуулийн баримт бичигт тусгалаа олсон өөрийн нийгмийн болон байгаль орчны үүргээ гүйцэтгэж чадахгүй бол ЕСБХБ үйлчлүүлэгчээс боломжийн хэмжээгээр авах засч залруулах арга хэмжээг зөвшөөрч болно. Хэрэв үйлчлүүлэгч дагаж мөрдөх явдлыг сэргээж чадахгүй бол ЕСБХБ нь зохимжтой гэж үзсэн, хуулийн баримт бичгүүдэд орших засч залруулах арга хэмжээг авч болно. ЕСБХБ мөн төсөлтэй хамаатай үйл ажиллагааг сайжруулах аливаа бололцоог үйлчлүүлэгчтэй хянан хэлэлцэж болно.

Үнэлгээ

38. Банкны байгаль орчны болон нийгмийн ажиллагааг үнэлэх, ЕСБХБ-наас санхүүжүүлж байгаа төслүүдийн байгаль орчны болон нийгмийн асуудлуудын үнэлгээг Банкны Үнэлгээний газар /ҮГ/ хийдэг бөгөөд тэр Банкны ажиллагаанаас тусад бөгөөд Банкны Захирлуудын Зөвлөлд шууд тайлагнадаг. Ийм үнэлгээний эхлэлийн шийдвэрлэх мөч бол амлалт хийх үед үйлчилж байсан төсөл бүрт зориулсан байгаль орчны болон нийгмийн зорилтууд хийгэд холбогдох Байгаль орчны бодлого, тухайн орны хүчинтэй буй болон салбарын стратеги болно. ҮГ-ын үнэлгээний шалгуур үзүүлэлтэй хийгэд процессын нарийн зүйлүүдийг ҮГ өөрийн процессоор тогтоож, тэдгээрийг Зөвлөл баталдаг.

Ажиллагааны өөрчлөлтүүд

¹¹ ЕСБХБ хувьцаат хөрөнгө оруулалтаа зарж, гэвч наад захын сонирхлоо хадгалсан, эсхүл зарим олон нийтэд үнэлэгдсэн хийгээд зарагддаг хэрэгслийн хувьд ЕСБХБ-наас мониторинг хийх ажиллагаа хязгаарлагдаж болно. Мөн тайлбар 4-д зааснаар, ЕСБХБ хэрэгслийг өөрийн хөрөнгө оруулалт/өр эсхүл үнэт цаас/-ыг зарсан эсхүл түүнээс хойлшуулсан төлбөрийн нөхцлөөр гарсан бол Банк төсөлд санхүүгийн сонирхолгүй гэж тооцогдоно.

¹² Зээлээс Энэт цаасны жишиг руу шилжих нь ЕСБХБ урьд нь Энэлэгдэж байгаагүй, тэгээд бас Элэмж байгаль орчны Эр төлбөртэй, эсхүл Хөдөлмөрийн асуудлуудтай төсөл, талбай эсхүл байгууламжтай зууралдахад Хөргэж болох юм.

39. Банкны зөвшөөрөл ба гарын үсэг зурсаны дараа төсөл ба ЕСБХБ-ны ажиллагааны мөнхөлбөгдох байгаль орчны болон нийгмийн ноцтой үр дагавартай байж болно¹². Тийм бодит өөрчлөлтүүдийг харгалзсан тохиолдолд Банк нь энэ Бодлого болон нэмэлт зохистой ажиллагааны судалгааны дагуу санал болгосон өөрчлөлтүүдийн үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлага болон байгаль орчин, нийгмийн нөлөөг багасгах, саармагжуулах арга хэмжээ шинэчилсэн/бүтцийг нь өөрчилсөн төслийн баримт бичигт тусгагдах болно. Хэрэв ажиллагааны өөрчлөлт Банкнаас зөвшөөрснөөс өөр бодит байгаль орчны ба/эсхүл нийгмийн байдалд хүргэх бол уг өөрчлөлтийг дээд удирдлагад мэдэгдэх бөгөөд хэрэв зохимжтой бол Зөвлөлд мэдээллийн эсхүл батлуулах журмаар хүргэгдэх болно.

D. ЕСБХБ Олон нийтэд тайлагнах ба хариуцлага хүлээх

40. ЕСБХБ өөрийн ажиллагаа болон энэ Бодлогын хэрэгжилтийн талаар Жилийн тогтвортой байдлын тухай тайланг гаргах бөгөөд тэр нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хүлэмжийн нөлөөллийн тухай, ЕСБХБ-ны санхүүжүүлж байгаа төслүүдийн байгаль орчны зардлын тухай, ЕСБХБ-ны төслүүдийн багцтай холбоотой бүх мэдээллийг агуулах хийгээд ЕСБХБ-ны дотоодын байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэл дээр тайлагнана.

41. Банкны Олон нийтийн мэдээллийн бодлогын ¹³ шаардлагын дагуу ЕСБХБ-ны хөрөнгө оруулалттай холбоотой байгаль орчны ба нийгмийн асуудлуудыг ЕСБХБ-ны Төслийн үр дүнгийн баримт /ТҮДБ/-д нэгтгэнэ.

42. Банкнаас санхүүжүүлж байгаа төслүүдийн талаархи гомдлыг үнэлж, хянаж нягтлах зорилгоор ЕСБХБ Бие даасан тусламж авах механизм /БДТАМ/-ыг бий болгосон. БДТАМ нь Банкны төслийн улмаас шууд эсхүл шууд бус нөлөөнд өртсөн орон нутгийн нийгмийн бүлэгт Банкинд банкны ажиллагааны талаар гомдол, өргөдөл гаргах боломж өгөх юм. БДТАМ хоёр үүрэгтэй: Банк өөрийн бодлогуудаа, ялангуяа энэ Бодлого, мөн тодорхой төсөлтэй холбогдуулан Олон нийтийн мэдээллийн бодлогын төслийн өвөрмөц заалтууд нийцэж байгааг хянан нягтлах үүрэг; мөн асуудал шийдвэрлэх үүрэг: гомдол, өргөдөл гарах шалтаг болсон асуудлуудыг шийдвэрлэх зорилготойгоор талууд, голдуу өртсөн хэсгийн төлөөлөгчид болон төслийн спонсорын хооронд харилцаа холбоог сэргээх явдал юм. Гомдлыг үнэлэх явцад Гомдлыг хянаж нягтлах эсхүл Асуудлыг шийдвэрлэх аль эсвэл аль альных нь талаар санаачилга гарч болно, гарахгүй ч байж болно¹⁴.

E. Бусадтай хамтран ажиллах явдлыг оролцуулан байгаль орчин болон нийгмийн өндөр ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг дэмжих хөхүүлэх

¹³ /ТҮДБ -ыг ЕСБХБ-ны Хэвлэлийн алба, түүний Бизнес мэдээллийн төв/БМТ/ мөн ЕСБХБ-ны веб хуудсаас (www.ebrd.com) авч болно.

¹⁴ [HTTP5/www.ebrd.com/about/integrity/irm/about/index.htm](http://www.ebrd.com/about/integrity/irm/about/index.htm) үзнэ үү.

43. Бүх үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин болон нийгмийн асуудалд мониторинг хийхээс гадна ЕСБХБ байгаль орчин болон нийгмийн ач тус авчрах зорилгоор төлөвлөгдсөн төсөл болон санаачилгагуудад идэвхтэй ба санаачилгатай хандана. Энэ хандлага дараахийг багтаана:

- Үр дүнтэй менежментийн системийг хөгжүүлэх, янз бүрийн чанарын хөтөлбөрүүдийн дор сертификатжуулалтыг олж авах болон шилдэг практикийг таниж мэдэх ба хэрэгжүүлэхэд нь үйлчлүүлэгчдэд туслахыг оролцуулан ЕСБХБ-ны хэрэгжүүлж байгаа ба санал болгосон төслүүдийг бүрэн цогц болгохын үүднээс техникийн туслалцаа үзүүлэх;
- Бодлогын болон зохицуулалтын шинэчлэл хийх, институциональ чадварыг бий болгох, салбарын хэмжээний судалгаа болон стратегийн үнэлгээ хийхийг оролцуулан байгаль орчин болон нийгмийн асуудлуудыг ЕСБХБ-ны үйлчлүүлэгчид илүү ойлгох орчин тойрныг сайжруулах;
- Гол салбаруудад хийх бие даасан хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжих;
- Өндөр байгаль орчин болон нийгмийн ач тустай бизнесийн боломжийн шинэ шугамуудыг судалж нээхийн тулд туршилтын төслүүдийг санхүүжүүлэх.

44. Эдгээр санаачилгын тулд ЕСБХБ үйлчлүүлэгч, донорууд болон бусад олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны харилцаа тогтоохыг эрэлхийлнэ. ЕСБХБ байгаль орчин болон нийгмийн асуудлаар донор засгийн газар, олон улсын байгууллага, ажиллагаа явагдаж байгаа улс орон болон иргэний нийгэмтэй тогтмол харилцаатай байна.

45. ЕСБХБ нь зохимжтой газарт байгаль орчин болон нийгмийн үнэлгээ эсхүл аудит хийхийг оролцуулан байгаль орчин болон нийгмийн зохистой ажиллагаа, төслийн үнэлгээ хийх замаар байгаль орчин болон нийгмийн сайжруулалтад хүрэх боломжийг илрүүлэхэд чиглэсэн системийн хандлагыг боловсруулахад ажлаа чиглүүлнэ. Эдгээр боломжийг илрүүлэх нь үйлчлүүлэгчдэд төслийн байгаль орчин, нийгэм, ажиллагааны болон эдийн засгийн гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээг нэмж оруулах, мөн тэдэнд Банкны болон шилжилтийн нөлөөний өндөр шалгуурыг хангахад туслах болно

46. ЕСБХБ нь усны хангамж, цэвэршүүлэлт, хатуу хогны менежмент зэрэг хотын байгаль орчны дэд бүтцийг санхүүжүүлэх замаар байгаль орчны сайжруулалт, хөрөнгө нөөцийн үр ашигтай ашиглалт болон хуваарилалтыг дэмжинэ. ЕСБХБ тарифын өөрчлөлт нь зарим хэрэглээний хэсгийн худалдан авах чадварт хэрхэн нөлөөлснийг үнэлэх хийгээд тэдгээр хэсэг өөрийгөө хангахад нь үр дүнтэй схемуудыг идэвхтэй дэмжиж, сөрөг нийгмийн нөлөөг сааруулах явдал байраа олсон, эсхүл боловсрогдож байгааг үнэлнэ. ЕСБХБ нь ялангуяа эрчим хүчийг хэмнэх, нөхөгдөн сэргэх төслүүдийг санхүүжүүлэх, цаг уурын өөрчлөлттэй зохицох хамгийн сайн практикийг дэмжих замаар цаг уурын өөрчлөлтийг саармагжуулах болон зохицох явдлыг дэмжинэ. Голлох бусад салбар нь Байгаль орчны болон нийгмийн өндөр ач холбогдолтой төслийг дэмжих, үүнд хүйсний тэнцүү байдал орох бөгөөд тэдгээрийг энэ Бодлогын 5-р зүйлийн дагуу тогтооно.

Ғ. Улс орон болон салбарын стратеги

47. Банкны улс орны болон салбарын стратеги нэг бүр ЕСБХБ-ны тогторжуулалтын эрхийг тусгах бөгөөд тэр ЕСБХБ-ны санал болгосон ажиллагаа, үүний дотор техникийн хамтын ажиллагааны байгаль орчин, нийгмийн утга санаа болон боломжийг харуулсан Хэсгийг багтаана. Стратеги нь холбогдох улс орны байгаль орчин, хүний эрх, хүйсний тэнцүү байдал зэрэг нийгмийн бусад зарчмын асуудлуудыг нэгтгэн дүгнэх бөгөөд зохимжтой бол эдгээр асуудлыг анхааралдаа авах ЕСБХБ-ны саналыг боловсруулна. Улс орны стратеги нь улс орны байгаль орчны болон нийгмийн стратеги ба

төлөвлөгөө/тухайлбал, Үндэсний байгаль орчны арга хэмжээний төлөвлөгөө, Үндэсний тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, цаг уурын өөрчлөлттэй зохицох стратеги, ЕХ-нд элсэх стратеги, Европын нөхөрлөл болон Европын хөршийн бодлогын гэрээ, арга хэмжээний төлөвлөгөө, ОУХБ-ын зохистой ажлын улс орны хөтөлбөр, иргэний нийгэмлэгийн үйл ажиллагаа, олон улсын бусад байгууллагуудын байгаль орчин ба нийгмийн хөгжлийн талаархи ажил, ялангуяа Дэлхийн банк болон ЕХ-наас улс орны гол байгаль орчны, нийгмийн болон хүний эрхийн асуудлуудыг тодорхойлоход туслалцаа авна.

Г. Институциональ болон Хэрэгжилтийн хэлцлүүд

48. Дээр дурдсан стратегийн чиглэлүүдийг зохих анхааралд авсан байдлыг хангахын үүднээс ЕСБХБ энэ Бодлого үр дүнтэй биелэгдэх явдлыг хангахын тулд ЕСБХБ зохих хөрөнгө нөөцийг хуваарилна. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ, мониторингийн процессыг харж хянаж байх, байгаль орчны болон нийгмийн ашиг тустай төслүүдийг санаачлах, боловсруулахын тулд Банк ажилтнуудын зохих нөөцийг бэлэн байлгана.

49. Энэ Бодлого түүнийг Захирлуудын Зөвлөл баталснаас хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно. Энэ Бодлого хүчин төгөлдөр болохоос өмнө Банкны менежментаар¹⁵ зөвшөөрөгдсөн төслүүдийн хувьд Банкны 2003 оны Байгаль орчны бодлого үйлчилнэ.

50. Энэ бодлогыг хэрэгжүүлэхэд туслах үүднээс ЕСБХБ нь The Байгаль орчны болон нийгмийн горим журам, зохих удирдамжийн бичиг, хэрэгслийг боловсруулж хангана, мөн энэ Бодлогыг шаардлагуудын талаар ажилтнууд зохих сургалт авч байх явдлыг хангана.

51. ЕСБХБ өөрийн Байгаль орчны болон Нийгмийн Зөвлөх Зөвлөлийн /БОН33/ туслалцааг авсаар байх бөгөөд түүний бодол саналыг ерөнхий бодлоготой холбоотой асуудлууд болон салбарын бүх бодлогын асуудлууд эцсийн болохоос өмнө авч сонсох болно. Түүний бодол саналыг мөн ЕСБХБ-ны санхүүжилттэй холбоотой төслийн өвөрмөц асуудлуудаар авч сонсож болно.

52. ЕСБХБ нь өөрийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийг энэ Бодлогын зорилготой үргэлж тулган харьцуулж байна. Гүцэтгэлийн шаардлагыг тогтмол үндсэн дээр хянан нягталж, Захирлуудын Зөвлөлөөс баталснаар нэмэлт оруулах эсхүл шинэчилж болно. Үүнээс гадна, энэ Бодлогыг Захирлуудын Зөвлөл 5 жил бүр хянан нягталж байна.

¹⁵Энэ Бодлогыг батлах үед энэ анхны батламжийг “Үзэл баримтлалын хяналт” гэнэ.

Хавсралт 1: А зэрэглэлийн төслүүд

Энэ жагсаалт “ногоон талын” эсвэл ихээхэн өргөтгөлийн эсхүл өөрчлөлт-хувиралтын дор дурдсан зэрэглэлийн төслүүдэд хамаатай. Жагсаалт нь бүдүүвчилсэн учир түүнд багтсан төслүүд зөвхөн жишээ юм. Төсөл бүрийн зэрэглэл нь түүний зураг төсөл, ажиллагаа, байршлын онцлогоос хамаарах бөгөөд байгаль аливаа бодит эсхүл болзошгүй сөрөг нөлөөний шинж чанар, цар хүрээнээс шалтгаална .

1. Түүхий газрын тосыг боловсруулах үйлдвэрүүд /үүнд түүхий газрын тосноос тослох материал үйлдвэрлэх жижиг үйлдвэрүүд орохгүй/ болон өдөрт 500 тонн ба түүнээс их нүүрс эсхүл битумен занарыг хийжүүлэх, шингэрүүлэх байгууламжууд.
2. 300 ба түүнээс дээш мегаватт¹ халуун гаргадаг дулааны эрчим хүчний станц ба бусад шатаадаг байгууламжууд, цөмийн эрчим хүчний станцууд болон цөмийн бусад реактор, үүнд тийм эрчим хүчний станц эсхүл реакторыг задлах эсхүл ашиглалтаас хасах явдал орно (дээд чадал нь 1 киловатт үргэлжлэх дулааны ачааллаас хэтрэхгүй задрах эсхүл цөмийн түлшний түүхий эдийг үйлдвэрлэх, хувиргах шинжилгээ судалгааны байгууламжуудаас бусад).
3. Цөмийн түлшийг үйлдвэрлэх эсхүл баяжуулах, цацраг туяанд өртсөн цөмийн түлшийг дахин боловсруулах, хадгалах, зайлуулах, цацраг идэвхт хаягдлыг хадгалах, зайлуулан устгах эсхүл боловсруулах зориулалттай байгууламжууд.
4. Ширэм болон ганг анхан шатанд хайлуулах нэгтгэсэн үйлдвэрүүд, металлургийн, химийн эсхүл элетролизийн аргаар өнгөт-бус түүхий металлын хүдэр, концентрат эсхүл хоёрдогч түүхий материалаас үйлдвэрлэх байгууламжууд.
5. Асбестыг олборлох, боловсруулах, асбест болон асбестыг агуулсан бүтээгдэхүүнийг хувиргах байгууламжууд, асбест-цемент бүтээгдэхүүний хувьд жилийн үйлдвэрлэл 20.000 гаруй тон эцсийн бүтээгдэхүүн байх , үрэлдэх материалын хувьд түүний үйлдвэрлэл 50 гаруй тон эцсийн бүтээгдэхүүн байх, тэгээд бусад асбестын хэрэглээ жилд 200 гаруй тон байх ёстой.
6. Химийн хувиралтын процессыг ашиглан үйлдвэрлэлийн хэмжээнд химийн бодис үйлдвэрлэх, өөрөөр хэлбэл нэг нэгэнтэйгээ холбоотой хэд хэдэн зэргэлдээ нэгжүүдээс бүрдсэн нэгтгэсэн химийн байгууламжуудыг байгуулж химийн эсхүл биологийн процесс, тэсрэх материалыг ашиглан дараахи бүтээгдэхүүхийг боловсруулна. Үүнд: үндсэн органик химийн бодис, үндсэн органик бус химийн бодис, фосфор, азот юм уу калийн үүсэлтэй бордоо /хялбар эсвэл нийлмэл бордоо/; үндсэн ургамалын эрүүл мэндийн бүтээгдэхүүн болон биоцид хийгээд химийн болон биологийн процессыг ашиглан үндсэн Эм зүйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
7. Автозам, хурдны зам болон холыг зайтай төмөр замын шугам, 2.100 болон түүнээс урт үндсэн нисэх, буух талбайтай нисэх онгоцны буудал, 4 ба түүнээс олон шугамтай шинэ зам барих, эсхүл дөрөв ба түүнээс олон шугамтай замтай болохын тулд одоогийн

замуудыг өөрчлөх эсхүл өргөтгөх, ингэхдээ шинэ зам, өөрчөгдөх эсхүл замын өргөтгөсөн хэсэг уртаараа 10 км болон түүнээс урт байх нөхцөлд.

8. Хий, газрын тос болон химийн бодисыг их хэмжээгээр тээвэрлэхэд зориулсан дамжуулах хоолой, терминал тэдэнтэй холбоотой байгууламжууд.

¹ 140 мегаватт нийт цахилгаан гаргалттай уурын болон нэг циклийн хийн хөдөлгүүртэй эрчим хүчний станцын 140 мегаватт нийт цахилгаан гаргалттай тэнцэнэ.

9. Далайн боомт, 1,350 тон гаруй усан онгоцыг өнгөрөөдөг улс орны дотоодын усан зам болон тэдгээрийн боомт, худалдааны боомт, газартай холбостой ачих ба буулгах усны зогсоол, 1,350 тон гаруй усан онгоцыг хүлээн авч чадах гадны /гаталгаа онгоцны зогсоолоос бусад/ боомт.

10. Шатаах, химийн үйлчилгээ эсхүл Аюултай, хортой, эсхүл аюул дагалдуулсан хог хаягдлыг шатаах, химийн үйлчилгээ хийх хог хаягдлыг боловсруулж зайлуулж устгах байгууламжууд.

11. Усыг тогтоох эсхүл усыг байнга хадгалах зориулалттай том ² далан болон бусад байгууламж.

12. Татан авах эсвэл дахин нөхөх усны хэмжээ 10 сая шоо метр ба түүнээс илүү байвал гүний усыг татах ажиллагаа эсвэл гүний усыг дахин нөхөх төлөвлөгөө.

13. (a) Мод эсхүл ижил ширхэгтэй материалаас зөөлөн эдийг нь авч боловсруулах; (b) өдөрт 200-аас дээш салхинд хатсан метр- тон цаас ба банз үйлдвэрлэх хүчин чадалтай аж үйлдвэрүүд.

14. Их хэмжээний хүлэр олборлох, ил олборлолт ба ил уурхай явуулж металын хүдэр эсвэл нүүрсийг боловсруулах. .

15. Ашиг хонжооны зорилгоор газрын тос болон байгалийн хийг олборлох.

16. 200,000 ба түүнээс дээш хүчин чадалтай газрын тос, нефтийн гаралтай химийн бодис эсхүл химийн бодисыг хадгалах байгууламж.

17. Их хэмжээний мод огтлол.

18. 150,000 дээш хүн амаас давсан хүчин чадалтай хотын хаягдал-усны боловсруулалтын үйлдвэр,

19. Хотын хатуу хог боловсруулж зайлуулах хүчин чадал.

20. Өргөн хүрээтэй жуулчлал ба жижиглэн худалдааны хөгжил.

21. Өндөрт өндөр хүчдэлийн цахилгаан эрчим хүчний шугам барих.

22. Өргөн цар хүрээтэй газрын нөхөн сэргээлт.

23. Оршин сууж байгаа байгаль орчны эрчимжүүлэлт эсхүл өөрчлөлтийг дагуулсан өргөн цар хүрээний хөдөө аж ахуй эсвэл моджуулалт.

24. Өдөрт 12 тонноос илүү эцсийн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай арьс шир идээлэх үйлдвэрүүд.

25. Гахай, тахиаг эрчимтэй өсгөх 40,000 гаруй тахианы байртай, үйлдвэрлэлийн гахайны /30 гаруй кг/ 2,000 байртай эсхүл мэгжийн 750 байртай фермууд.

² Том далангийн олон улсын комисс /ТДОУК/ -оос тодорхойлсноор том даланд суурьнасаа 15 м болон түүнээс дээш далан орно. Өндрөөрөө 5-аас 15 м хоорондын далан гэвч хадгалах усны багтаамж нь 3 сая шоо метраас илүү бол мөн том даланд тооцогдоно.

26. Мэдрэмжтэй газар орчинд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд, эсхүл тэр газар орчинд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр байгаа төслүүд³ энэ жагсаалтанд ороогүй байж болно. Тийм мэдрэмжтэй газар орчин нь тухайлбал, үндэсний болон олон улсын хуулиар тогтоогдсон үндэсний парк болон бусад хамгаалалттай газар, мөн олон улсын, үндэсний, бүсийн ач холбогдолтой газар нутаг, тухайлбал биологийн олон төрөлхт амьтан ургамалтай намагшсан газар, ой мод, археологийн ба соёлын ач холбогдолтой газар нутаг, нутгийн уугуул болон бусад эмзэг бүлэг хүмүүст чухал бүс нутгийг багтааж болно.

27. Орон нутгийн нийгмийн бүлгүүд эсхүл төсөлд өртсөн талуудад нийгмийн ноцтой сөрөг нөлөө үзүүлж болох төслүүд.

28. Үлэмж сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт эсхүл эдийн засгийн шилжилт нүүдлийг дагуулж мэдэх төслүүд.

³ Ямар нэгэн хязгарлалтгүйгээр нийгэм болон байгаль орчинд чиглэсэн төслүүд /тухайлбал, нөхөн сөргөгдэх эрчим хүч/.

2-р хавсралт. ЕСБХБ-ны Байгаль орчин болон Нийгмийн Хасалтын жагсаалт

ЕСБХБ мэдэж байгаад дараахийг агуулсан төслүүдийг шууд эсхүл шууд бус санхүүжүүлэхгүй. Үүнд:

а) Хүлээн авагч орны /өөрөөр хэлбэл, үндэсний/ хууль тогтоомж, олон улсын конвенци ба гэрээ эсхүл олон улсын аажмаар багасгах ажиллагаа, хоригийг зөрчсөн аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах аливаа үйл ажиллагаа:

(i) Полифлоринатжуулсан бифенил агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эсхүл худалдах ⁴

(ii) Олон улсын аажмаар багасгах ажиллагаа, хоригийг зөрчсөн эм, пестицид/гербицид болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, худалдах ⁵

(iii) Олон улсын аажмаар багасгах ажиллагаанд хамаарах озоныг цөлмөх зүйлсийг үйлдвэрлэх, худалдах ⁶

(iv) Зэрлэг амьтны ба ургамлын аймгийн ховордсон зүйлсийн олон улсын худалдааны тухай Конвенци /ХЗОУХК/-аар зохицуулагддаг зэрлэг ан амьтныг худалдах, зэрлэг аймгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсхүл худалдах ⁷

(v) Олон улсын хуулиар хориглосон, хил давуулан хаягдал тээвэрлэх ⁸

б) Асбестын наалдаагүй зөөлөн эд эсхүл асбестос агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах ⁹

с) Нөөцийн олон төрөлхт байдлыг эсхүл соёлын өв уламжлыг хамгаалах хүлээн авагч орны хууль тогтоомж буюу олон улсын конвенциор хориглосон үйл ажиллагаа ²⁰

д) 2.5 км ба илүү урт тор ашиглан далайд тор хөвүүлэн загас барих

е) ИМО шаардлагыг ³ хангаагүй ачааны тээврийн онгоцонд /танкер/ газрын тос болон бусад аюултай бодис материалыг тээвэрлэх

ф) Шаардлагатай экспорт эсхүл импорт лицензгүй, эсхүл холбогдох орнуудын экспорт, импорт, зохимтой бол транзитын эрх бүхий зөвшөөрөлгүйгээр барааг худалдах.

⁴ ПФБ: Полифлоринатжуулсан бифенил маш хортой химийн бодисын бүлэг. ПФБ-ыг 1950-1985 оны тосоор дүүргэсэн цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжинд олж болно.

⁵ Иш баримтууд нь бол: Зарим аюултай химийн бодисын экспорт ба импортын тухай нэмэлт оруулсан ЕХ-ны журам /ЕЕС/ № 2455/92, Засгийн газруудаас хэрэглээ болон/эсхүл худалдааг нь хорисон, татан авсан, хатуу хязгаарласан эсхүл батлаагүй бүтээгдээний НҮБ нэгдсэн жагсаалт, Олон улсын худалдаанд зарим аюултай химийн бодис болон пестицидэд урьдчилсан мэдээлэлтэй зөвшөөрөл олгох горим журмын тухай Конвенци /Роттердамын Конвенци/, Тэсвэртэй органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенци, ДЭМБ-ын пестицидын аюулын ангилалал.

- ⁶ Озоныг цөлмөх бодисууд /ОЦБ/: Өргөнөөр нийтлэгдсэн “озоны нүх” бий болгохо хүргэдэг ётратосферийн озонтой урвалд орж түүнийг цөлмөдөг химийн бодисууд. Монреалийн Протокол ОЦБ-ыг , тэдний зорилтот багалгалт ба аажмаар устгах хугацааг тоочсон байдаг. Аэрозоль, хөргөх бодис, хөөс үлээгч бодис, уусгагч болон галаас хамгаалах бодисыг багтаасан Монреалийн Протоколоор зохицуулагддаг химийн бодисын жагсаалтыг гарын үсэг зурагч орнуудын нарийвчлал болон устгах зорилтот хугацааны хамт ЕСБХБ авч болно.
- ⁷ ХЗОУХК: Амьтны болон ургамлын аймгийн ховордсон зүйлсийн олон улсын худалдааны тухай Конвенци. ХЗОУХК-ар хамгаалагдсан зүйлсийн жагсаалтыг дараахаас харж болно: www.cites.org/eng/app/index.shtml.
- ⁸ Иш татсан баримтууд: Хаягдал зөөвөрлөх тухай журам /ЕС/ №1013/2006, Нөхөн сэргээлтэд зориулсан хаягдлыг хил давуулан тээвэрлэлтэд тавих хяналтын тухай эцсийн Шийдвэр С/92/39-ийн өөрчлөлттэй хамаатай ЭЗХАХБ-ын Зөвлөлийн эцсийн Шийдвэр С/2001/ 107, аюултай хаягдаыг хил давуулан тээвэрлэлт ба түүний устгалтад тавих хяналтын тухай 1989 оны 6-р сарын 14-ний Базелийн Конвенци.
- ⁹ Энэ нь наалдаастай асбест-цементен хамгаалалтын бүрхүүл /түүнд асбест <20% байх ёстой/ -ийг худалдан авах, ашиглахад хамаарахгүй.
- ¹⁰ Холбогдох олон улсын конвенциуд : Зэрлэг амьтдын нүүдлийг хамгаалах тухай Конвенци /Бонны Конвенци /, Convention; Олон улсын ач холбогдолтой намагдуу газар, ялангуяа Уотерфаулын орчны тухай Конвенци /Рамсар Конвенци/; Европын зэрлэг ан агтан ба Байгалийн орших газрыг хамгаалах тухай Конвенци /Берны Конвенци/; Дэлхийн өв удамшлын Конвенци; Биологийн олон төрөлхт байдлын тухай Конвенци ба Протоколууд орох хийгээд дээрхээр хязгаарлагдахгүй.
- ¹¹ Энэ нь: шаардагдах бүх УОБСОУК ДАААҮУК-ийн сертификат (үүнээр хязгаарлахгүйгээр, МДШМ кодоод нийцэхгүй) ачааны хөлөг онгоцууд, Европын Холбооны хар жагсаалтад орсон ачааны онгоц эсхүл Боомтын улсын хяналтын таалаархи Ойлголцлын тухай Парижийн Санамж бичиг Парижийн /ОСБ/ -ийн шийдвэрээр хориглогдсон , мөн УОБСОУК13 G журмын дагуу аажмаар хасагдах танкерууд багтаана. Бүтэн бие нь 25 жилээс илүү болсон аливаа ачааны онгоцыг ашиглах ёсгүй.

**ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1:
Байгаль орчны болон нийгмийн Үнэлгээ ба Менежмент**

Танилцуулга

1. ЕСБХБ-ны санхүүжилт авч байгаа бүх компани байгаль орчин болон нийгмийн асуудал, мөн тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөний менежментийн талаар системийн хандлагатай байхыг ЕСБХБ чухал гэж үздэг. Бизнес ажиллагааны цар хүрээ ба шинж чанарт зохистой үр дүнтэй менежментийн систем нь компанид эрсдлийн хувьд илүү сайн менежмент хийх, боломж гарахад давуу тал олж авах, байгаль орчин болон нийгмийн гүйцэтгэл болон нэр хүндээ сайжруулах боломж өгдөг бөгөөд олонхи тохиолдолд тэдний санхүүгийн ажиллагааны үр дүнг дээшлүүлдэг. Амжилттай бөгөөд үр ашигтай байгаль орчны болон нийгмийн менежментийн систем нь менежментаас санаачилж дэмждэг динамик, үргэлжлэх процесс хийгээд үйлчлүүлэгч, түүний ажилчид болон төсөлд юм уу үйлчлүүлэгчийн компанид өртсөн орон нутгийн нийгмийн бүлгүүдийн хоорондын утга учиртай харилцааг багтаадаг болно. Тэр үйл ажиллагаагаа байнга сайжруулах зорилгоор төлөвлөх, биелүүлэх, хянаж нягтлах, үр дүнд иж бүрнээр хандахыг шаарддаг юм.

Зорилт

2. Банк үйлчлүүлэгчдээсээ тэдний ажиллагаа эсхүл төслийн шинж чанартай холбоотой байгаль орчин болон нийгмийн эрсдэл болон боломжийг удирдах системийн хандлагыг ¹ боловсруулахыг шаарддаг бөгөөд тэр нь тухайн төсөлд Банк оролцох хугацаанд Банкны байгаль орчин болон нийгмийн Бодлоготой нийцэж байх боломжоор хангадан.
3. Энэ Гүйцэтгэлийн шаардлага /ГШ/ 1 ЕСБХБ-ны санхүүжилтэд санал болгосон төсөлтэй холбоотой байгаль орчин болон нийгмийн асуудлуудын үнэлгээ, менежмент, мониторингийн процесст үйлчлүүлэгчид тавих шаардлагыг тодорхойлж өгч байгаа юм.. Төслийн сонирхогч этгээдүүдтэй холбоотой байх нь энэ процессын салшгүй хэсэг болно. Сонирхогч этгээдүүдийн оролцооны талаархи Банкны шаардлагыг ГШ 10-т тусгасан болно.

ГШ 1 ба ГШ 10-ын өвөрмөц зорилтуудыг дор тусгав. Үүнд:

| Байгаль орчин болон нийгмийн үнэлгээ ба менежмент (ГШ 1) | Мэдээллийг ил тод байлгах ба Хувь эзэмшигчдийн оролцоо (ГШ 10) |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Төсөлтэй холбоотой байгаль орчин болон нийгмийн эерэг ба сөрөг нөлөө ба асуудлуудыг тодорхойлон үнэлэх . • Ажилчид, нийгмийн бүлгүүд ба байгаль орчинд учруулах сөрөг нөлөөнөөс зайлхийх, хэрэв зайлхийх боломжгүй бол багасгах, саармагжуулах, нөхвөр олгох арга хэмжээг батлах. • Байгаль орчин болон нийгмийн ажиллагааг сайжруулах боломжийг илрүүлэх, боломжтой бол батлах. • Гүйцэтгэлийн мониторинг ба үнэлгээний динамик процессын замаар сайжирсан байгаль орчин, нийгмийн ажиллагааг дэмжих. | <ul style="list-style-type: none"> • Төсөлд өргөж болох хүмүүс буюу нийгмийн бүлэг, мөн бусад сонирхсон талуудыг тогтоох. • Мэдээллийг ил тод болгох ба утга учиртай санал солилцох явцад сонирхогч этгээдүүдэд болох байгаль орчин болон нийгмийн асуудлуудад тэд зохих ёсоор оролцож байх явдлыг хангах. • Хувь эзэмшигчидтэй найрсаг харилцааг төслийн хэрэгжилтийн үед утга учиртай оролцоог ханган үргэлж хадгалах. |

¹ Заавал биш ч гэсэн Банк ISO 14001 мэт нийтээр зөвшөөрөгдсөн менежментийн системийг хүлээн авч батлахыг дэмжиж байна.

Хэрэглээний цар хүрээ

4. Энэ ГШ нь боломжит байгаль орчны эсхүл нийгмийн эрсдэл, нөлөөтэй төсөлд хамаатай бөгөөд тэдгээрийг төслийн хөгжлийн эрт шатуудад үнэлэх хэрэгтэй бөгөөд үргэлж менежмент хийгдэж байх ёстой.

Шаардлага

Байгаль орчны ба нийгмийн үнэлгээ

5. Эрсдлийн үнэлгээ, аудит эсхүл байгаль орчны ба нийгмийн нөлөөний үнэлгээ зэрэг үнэлгээний ажлаар дамжуулан үйлчлүүлэгч нэгдмэл аргаар санал болгосон төсөлтэй холбоотой байгаль орчны ба нийгмийн асуудал болон нөлөөг авч үзэх болно. Цуглуулсан мэдээлэл нь ЕСБХБ-ны үйлчлүүлэгч ба төсөлтэй хамаатай өөрийн зохистой ажиллагаанд мэдээлэх бөгөөд холбогдох ГШ-г танин мэдэх, зохих ГШ-ийн дагуу эрсдлийг зохих ёсоор удирдах, бололцоог хөгжүүлэхэд тусална. Үнэлгээний процесс нь сүүлийн үеийн мэдээлэл, үүнд үйлчлүүлэгчийн бизнес эсхүл төслийн талаархи үнэн танилцуулга ба зураглал, мөн нарийвчлалтын зохих түвшинд бэлтгэгдсэн нийгмийн ба байгаль орчны үндсэн мэдээлэл орно. Үнэлгээ нь мөн төсөл ажиллаж байгаа орны олон улсын хуулийн² дагуу хүлээн авагч орны хүлээсэн үүргийг /тухайлбал, газар ашиглалтын төлөвлөлт, хамгаалалтын бүсийн менежмент/ биелүүлэхэд хамаатай хууль тогтоомжийг илрүүлэх ёстой.
6. Байгаль орчны болон нийгмийн нөлөө ба асуудлуудыг төслийн нөлөөллийн хүрээнд үнэлнэ. Байдлаас шалтгаалан нөлөөний энэ хүрээ дараагийн 1 юм уу олныг багтаана:
 - i. Санхүүжигдэх төслийн ажиллагаанд хамаатай үйлчлүүлэгчийн шууд эзэмшиж эсхүл удирдаж байгаа активууд ба байгууламжууд /тухайлбал, үйлдвэрийн газар, эрчим хүч дамжуулах шугам, дамжуулах хоолой, суваг, боомт, туслах зам ба барилгын лагерь/.
 - ii. Туслах/эрх олгох ажиллагаа, үйлчлүүлэгчийн бизнесийг явуулах эсхүл төслийг дуусгахын төлөө гэрээгээр халсөлж авсан талуудын /гэрээт гүйцэтгэгч/ эзэмшилд эсхүл хяналтанд байгаа активууд ба байгууламжууд.
 - iii. Төслийн нэг хэсэг болгон ЕСБХБ-наас санхүүжүүлдэггүй холбоотой байгууламж эсхүл бизнес, тэд тустаа хуулийн этгээд байж болно, гэхдээ тэдгээрийн чадвар ба оршин тогтнол зөвхөн төслөөс шалтгаалахаас гагна тэдний бараа, үйлчилгээ нь төслийн амжилттай ажиллагаанд ихээхэн нөлөөлнө. .
 - iv. ЕСБХБ-д барьцаа болгосон үнэт цаасны багцын нэг хэсэг болох үйлчлүүлэгчийн эзэмшиж эсхүл удирдаж байгаа байгууламж, үйл ажиллагаа ба үйлчилгээ,
 - v. Бүс нутаг болон нийгмийн бүлгүүд дараахид өртөж болзошгүй: төслийн цаашдын төлөвлөгөөт хөгжил, эсвэл тухайн газар зүйн нутаг дэмсгэрт өөр эх үүсвэрээс ирэх ижил нөлөө, оршиж байгаа төсөл нөхцөл болон төсөлтэй холбоотой хөгжлөөс учрах нийлбэр нөлөө тэр нь зохистой ажиллагааг явуулах үед бодитойгоор тохиож мэднэ.
 - vi. Төслөөс шалтгаалсан, урьдчилан төлөвлөгөөгүй боловч урьдчилан таах боломжтой хөгжлийн, хожим өөр газар болох байсан нөлөөнд өртсөн бүс нутаг болон нийгмийн бүлгүүд. Нөлөөллийн хүрээ нь төсөл байхгүй эсхүл төслөөс тусад учирч болох нөлөөг багтаадаггүй.

Дээрхэд үндэслэн ЕСБХБ ба түүний үйлчлүүлэгч төсөл бүр дээр нөлөөллийн хүрээг тохирно.

² Тухайлбал, Эрхус, Эспу ба Биологийн олон төрөлхт байдлын тухай Конвенциуд.

7. Байгаль орчны болон нийгмийн асуудал ба нөлөөг төслийн холбогдох үе шатуудад шинжилж үзэх болно. Эдгээр нь барилгын өмнөх, барилгын үеийн, ажиллагааны үеийн, татан буулгалт, хаалт ба сэргээн босголтыг багтааж болно. Хэрэгтэй бол үнэлгээ нь мөн гуравдагч этгээд /тухайлбал, орон нутгийн ба үндэсний засгийн газар, гэрээт гүйцэтгэгч ба нийлүүлэгч/-ийн үүрэг ба чадварыг төсөлд хэрхэн нөлөөлж чадах асуудлын хүрээнд авч үзнэ, ингэхдээ үйлчлүүлэгчийн дээрх эрсдэл ба нөлөөг шийдвэрлэх чадвар нь түүний гуравдагч этгээдийн үйлдлийг хянах, түүнд нөлөөлөх чадвараас шалтгаална гэдгийг анхаарна. Нийлүүлэлтийн хэлхээний нөлөө төслийн үндсэн ажиллагаанд маш чухал тул төсөлд ашиглаж байгаа нөөц, баялаг экологийн хувьд мэдрэмжтэй эсэх, мөн нийлүүлж байгаа зүйлийн өрсөлдөх чадварт ажлын өртөг доогуур байгаа нь ноцтой хүчин зүйл болж байгааг авч үзнэ⁴. Үнэлгээ мөн хил давсан болон дэлхийн асуудлуудыг авч үзнэ, тухайлбал орж ирж байгаа салаа урсгал, дулаан ялгаруулалт, олон улсын усан замын өсч буй ачаалал, бохирдол, хүлэмжийн хийн ялгаруулалт, цаг уурын өөрчлөлтийг саармагжуулах ба зохицолт зэргийн нөлөө, мөн дээрхийн ховордсон ан амьтан, орчинд үзүүлэх нөлөөг авч үзнэ.
8. Зохистой ажиллагааны судалгааны шинж чанар нь хөндсөн асуудал, эрсдэлтэй дүйцэнэ. Тэр бол мэргэжлийн болон туршлагатай хүмүүсээс бэлтгэсэн шаардлага хангасан, нягт няхуур болон хэний ч тал засаагүй үнэлгээ ба танилцуулга байх болно. Асуудал, нөлөөний боломжит ач холбогдлоос шалтгаалан Банк зарим зохистой ажиллагааг бие даасан гуравдагч талын мэргэжилтнүүдээр хийлгэхийг шаардаж болно. Төсөл бүр дээр Банк үйлчлүүлэгчтэй шаардагдах зохистой ажиллагааны судалгааны шинж чанарыг тохирно.
9. ЕСБХБ-наас “А” зэрэглэл авсан төслүүд тусгай албархуу ба оролцоотой үнэлгээний процессыг шаарддаг. Ийм төслүүдийн бүдүүвчилсэн жагсаалтыг Бодлогын 1-р хавсралтаас үзнэ үү. Үйл ажиллагааны гол өргөтгөл болох Ногоон талын хөгжил гэгч нь Хавсралт 1-г харуулснаар, олон талын ноцтой сөрөг байгаль орчны ба нийгмийн нөлөөтэй, тиймээс уг төсөл түүнтэй холбоотой ирээдүйн бодит байгаль орчны ба нийгмийн нөлөөг тодорхойлон үнэлэх, боломжит сайжруулалтын боломжуудыг илрүүлэх, зайлсхийх аливаа арга хэмжээг санал болгох, хэрэв зайлсхийх боломжгүй бол нөлөөг саармагжуулах, багасгахын тулд иж бүрэн байгаль орчны ба нийгмийн үнэлгээ хийхийг шаарддаг. Энэ үнэлгээнд тийм нөлөөний эх үүсвэртэй өрсөлдөж чадах техникийн ба санхүүгийн хувьд үндэслэлтэй хувилбаруудыг, санал болгосон тухайн төслийг шалгаж сонгосон баримт бичгүүдийг судлах ажил орно. Байгаль орчны нөлөөний үнэлгээ /БОНУ/, Нийгмийн нөлөөний үнэлгээ /ННУ/ нь ГШ 10 болон үндэсний БОНУ хууль болон бусад холбогдох хуулийн⁴ аливаа шаардлагыг хангах ёстой. Онцгой тохиолдолд бүс нутгийн, салбарын, стратегийн үнэлгээ шаардагдаж болно. Аливаа бусад байгаль орчны, нийгмийн зохистой ажиллагааны судалгаанаас гадна сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийг багтаасан эсхүл нутгийн уугуул хүмүүс болон соёлын өвөнд нөлөө үзүүлэх төслүүдэд шаардагдаж болох бусад аливаа байгаль орчны ба нийгмийн зохистой ажиллагааны судалгаанаас гадна ГШ 5, 7 ба 8-ын дагуу үнэлгээ хийх шаардлагатай.
10. ЕСБХБ-наас “В” зэрэглэл авсан төслүүдээс төслийн шинж чанар, цар хүрээ, байршил, мөн боломжит байгаль орчны, нийгмийн нөлөө болон эрсдлийн шинж төрхөөс шалтгаалан зохистой ажиллагааны янз бүрийн судалгааг шаардаж болно. Зохистой ажиллагаа нь санал болгосон төсөлтэй холбоотой ирээдүйн аливаа боломжит нөлөөг илрүүлэн үнэлж, сайжралтын боломжит бололцоог олж илрүүлэх,

³ ГШ 2, хэсэг 20 ба ГШ 6, хэсэг 22-ыг мөн үзнэ үү.

⁴ ЕХ-ны БОНУ-ий тухай Захирамжтай нийцэх БОНУ/ННУ-ний тайлагналтын хэв загварыг ЕСБХБ-наас авч болно. ЕХ-ны гишүүн орнуудад байрлах төслүүд ЕХ-ны БОНУ-ий тухай Захирамжтай нийцэх ёстой бөгөөд хэрэв шаардлагатай бол зөвшөөрөл авна.

зайлхийх аливаа арга хэмжээг зөвлөх, хэрэв зайлхийх боломжгүй бол сөрөг нөлөөг саармагжуулах, багасгах. учиртай. Боломжит байгаль орчин ба нийгмийн эрсдлээс шалтгаалан Банк нь одоо ажиллаж байгаа байгууламж дээр түүний өнгөрсөн ба одоогийн ажиллагааны байгаль орчин ба нийгмийн нөлөөг үнэлэх үүднээс аудит хийхийг шаардаж болно. Ийм аудитын зорилго нь өнгөрсөн ба одоогийн түгшүүрийг олж мэдэх, хууль журмын мөрдөлтийн өнөөгийн байдлыг тогтоох, менежментийн систем болон гүйцэтгэл, мөн төсөвтэй холбоотой боломжит эрсдэл, хариуцлага болон бололцоог илрүүлэх явдал юм.. Аюлын шинжилгээ эсхүл эрсдлийн үнэлгээ мэт бусад төрлийн судалгааг хийх шаардлагатай байж болно. Үнэлгээ, аудит эсхүл бусад шалгалт шинжилгээний төвлөрөл нь байгаль орчин эсхүл нийгмийн / өөрөөр хэлбэл, хөдөлмөр, мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа /МЭМАА/, нийгмийн бүлэгт үзүүлэх нөлөө/эсхүл бүгдийн нэдмэл байж болно, гэхдээ энэ нь төслийн шинж чанараас шалтгаална. Одоо байгаа үйлдвэрлэлийн аливаа шалгалт шинжилгээг уг үйлдвэрлэлээс тустай, бие даасан мэргэжилтнүүд явуулах ёстой.

11. Олон талбайд ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгч ЕСБХБ-наас корпоратив ерөнхий санхүүжилт, ажлын капитал эсхүл үнэт цаасны санхүүжилтийг хүсэх тохиолдолд дээрхи 4-өөс 10 дахь заалтуудад заасан үнэлгээ зохимжтой бус байх талтай. Эдгээр тохиолдолд ЕСБХБ төсөл тус бүрээр тохиолдлуудыг нотлох бөгөөд харин үйлчлүүлэгч мэдлэгтэй, туршлагатай, гадны мэргэжилтнийг хөлсөлж, тэр одоогийн байгаль орчин ба нийгмийн менежментийн систем /БОНМС/ болон компанийн өнгөрсөн ба одоогийн ажиллагааг ЕСБХБ-ны ГШ-тай харьцуулж корпоратив аудит хийнэ. Аудит нь:

- өөрийн бизнес ажиллагааны холбогдох бүх нийгмийн ба байгаль орчны эрсдэл, нөлөөг, ялангуяа ГШ-дад /энэ ГШ-ыг оролцуулан/ заасныг шийдвэрлэх үйлчлүүлэгчийн чадварыг үнэлэх;
- байгаль орчин ба нийгмийн асуудлуудад хамаатай төсөл хэрэгжиж байгаа орны холбогдох хууль тогтоомжийг үйлчлүүлэгч даган мөрдөж байсны түүхийг үнэлэх, үүнд олон улсын хуулиар хүлээн авагч орны хүлээсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн хуулиуд мөн орно;
- компанийн гол сонирхогч этгээдүүдийн гол хэсгүүд, сонирхогч этгээдүүдийн одоогийн оролцооны идэвхийг тогтоох.

Корпоратив аудитын жинхэнэ цар хүрээг ЕСБХБ-тай жич тохирно.

12. “С” зэрэглэл авсан төслүүд хамгийн бага эсхүл ердөө сөрөг нөлөөгүй гэж тооцогддог тул тийм гэж тогтоогдохоос цааш нэмэлт байгаль орчны болон нийгмийн үнэлгээ шаардлагагүйгээс гадна доорхи 14-16 хэсэгт заасан БОНАХТ-г шаардахгүй.
13. Үнэлгээний процессын нэг хэсэг болгон үйлчлүүлэгч ГШ 10-ын дагуу сонирхогч этгээдүүдээ танин мэдэж, ажиллагаандаа татан оролцуулна.

Байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /БОНАХТ/

14. Байгаль орчин ба нийгмийн үнэлгээгээр илэрсэн зүйлс, өртсөн хувь эзэшигчидтэй хийсэн хэлэлцүүлгийн үр дүнг анхааралдаа авч үйлчлүүлэгч илрүүлсэн нийгэм, байгаль орчны асуудлууд, нөлөө болон бололцоонд хандуулсан нөлөөг саармагжуулах, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээний хөтөлбөрийг Байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /БОНАХТ/-ний хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлнэ. Саармагжуулах арга хэмжээ ба үйлдэл төслийн холбогдох бүх үе шаттай /өөрөөр хэлбэл, барилгын өмнөх, барилга, үйлдвэрийн ажиллагаа, ашиглалтаас гаргах, сэргээн босголт/ холбогдох хууль журам болон энэ Бодлогын ГШ-ын дагуу явагдаж байвал хүлээн зөвшөөрнө. БОНАХТ урт хугацаатай үелсэн хандлагыг авах ёстойгийн хажуугаар ирээдүйн хүлээгдэж буй хууль

15. БОНАХТ-ын нарийвчлал болон хэцүүгийн түвшин, тодорхойлсон арга хэмжээ, ажлын тэргүүлэх зорилго нь төслийн эрсдэл, нөлөө ба бололцоог харуулна. БОНАХТ байгаль орчин, нийгмийн гол асуудлууд, тэднийг зохистой шийдвэрлэхийн тулд хийх ажил, мөн байгаль орчин эсхүл нийгмийн ашиг тусыг аль болохоор нэмэгдүүлэх аливаа ажил, хуваарь ба хэрэгжүүлэлт болон мониторингийг хариуцах хүн/нэгж болон холбогдох зардлын тооцоог баримтжуулна. Үйлчлүүлэгч тэр зардлыг хэрхэн нөхөхийн талаар ЕСБХБ-д мэдээлнэ. Хүсч буй үр дүнг үнэлгээний үед тогтоосон суурь үзүүлэлтийн эсрэг тогтоохдоо аль болохоор хэмжиж болох үзүүлэлтээр тогтоох бөгөөд гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилт эсхүл хүлээн авалтын шалгуур мэтийн элементтай, тэгээд түүнийг тогтоосон өнгөрөх цаг хугацаанд хөөн мушгиж болно. Одоогийн ажиллагаа хууль зохицуулалтын шаардлага болон өгөгдсөн зөвшөөрлүүдийг ноцтой зөрчиж байгаа бол үл биелэлтийн салбарт санал болгож байгаа ажил, хуваарийг холбогдох эрх бүхий байгууллагатай тохиролцох ёстой. Төслийн хөгжил болон хэрэгжилтийн процессын динамик чанарыг нь хүлээн зөвшөөрч, БОНАХТ төслийн орчин тойрон дахь өөрчлөлт, урьдчилан бодолцоогүй үйл явц, мониторингийн үр дүнд хүлээцтэй хандана. А зэрэглэлийн төслийн хувьд үнэлгээний явцад Банк үйлчлүүлэгчтэй санал болгосон төсөл өөрчлөгдөх чиг замыг хэрхэн удирдах эсхүл урьдчилан тооцоогүй орчин нөхцлийг хэрхэн удирдах, тайлагнах талаар өөрчлөлтийн менежментийг процессыг хэлэлцэн тохирч болно.
16. Олон талбайд ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгч ЕСБХБ-наас корпорацийн ерөнхий санхүүжилт, ажлын капитал эсхүл үнэт цаасны санхүүжилтийг хүсэх тохиолдолд БОНАТ-г үйлчлүүлэгчийн корпорацийн байгаль орчны болон нийгмийн менежментийн системд оруулж өгөх ёстой. Энэ нь корпорацийн аудитын явцад илэрсэн аливаа асуудлыг зохих хугацаанд Банкны ГШ-тай нийцүүлж хадгалах цаг хугацааны арга хэмжээг тодорхойлох замаар шийдвэрлэх юм.

Зохион байгуулалтын чадвар болон Үүрэг эрмэлзэл

17. Үйлчлүүлэгч БОНАХТ болон холбогдох менежментийн системийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага болон эрх мэдлийг тодорхойлсон зохион байгуулалтын бүтцийг бий болгох, ашиглах болон хүчтэй болгох шаардлагатай. Хариуцлага болон эрх

18. Үйлчлүүлэгч нь төслийн эсхүл компанийн нийгэм болон байгаль орчинтой холбоотой үйл ажиллагааны төлөө шууд хариуцлага хүлээдэг ажилтнууд зохих ёсны мэдлэгтэй бөгөөд сургалттай байж, өөрсдийн ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвартай байх явдлыг хангана. Сургалт нь холбогдох ГШ болон БОНАХТ /хэрэв байвал/-ын дагуу шаардагдах тусгай арга хэмжээ, үйлдэл, мөн ажлыг чадамгай болон үр дүнтэй замаар гүйцэтгэхэд шаардагдах арга барилд зааж өгөх ёстой.

Гэрээт гүйцэтгэгчдийн менежмент

19. БОНАХТ-д заасан аливаа тусгай шаардлагыг оролцуулан ГШ нь төслийг үйлчлүүлэгч шууд хэрэгжүүлж байна уу, эсхүл гэрээт гүйцэтгэгч эсхүл давхар гүйцэтгэгч гүйцэтгэж байна уу гэдгийг үл харгалзан адилхан хамаарна. Төслийн талбайд ажиллаж байгаа гэрээт гүйцэтгэгчид эдгээр шаардлагыг биелүүлэх явдлыг хангах нь үйлчлүүлэгчийн хариуцлага мөн. Гэрээт гүйцэтгэгчдийн үр ашигтай менежмент агуулна:

- Гэрээнүүдтэй холбогдсон байгаль орчны болон нийгмийн эрсдлийг үнэлэх.
- Холбогдох ГШ/БОНАХТ-н заалтуудыг зохимжтой бол тендерийн баримт бичигт оруулах, боломжит гэрээт гүйцэтгэгчийн шаардлага хангах чадварыг нь тандах.
- Тэдгээр стандартыг дагаж мөрдөхийг гэрээт гүйцэтгэгчээс гэрээгээр шаардаж, үл гүйцэтгэлийн төлөөх хариуцлагын тухай заалтыг оруулах.
- Гэрээт гүйцэтгэгчид төслийн өөрсдийн даалгаврыг ГШ болон БОНАХТ-н шаардлагын дагуу биелүүлэх мэдлэг чадвартайг батлах.
- Гэрээт гүйцэтгэгч дээрхи шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд мониторинг хийх.
- Давхар гүйцэтгэгчийн хувьд гэрээт гүйцэтгэгчдээс ижил тохиролцоог давхар гүйцэтгэгчидтэй хийхийг шаардах.

Хөдөлмөрийн гэрээгүй ажилчдын хөдөлмөр ба ажлын нөхцөлтэй холбоотой шаардлагуудыг ГШ 2, 19-р зүйлд тусгасан болно.

Гүйцэтгэлийн мониторинг болон хяналт

20. Үйлчлүүлэгч хуулийн гэрээний байгаль орчин болон нийгмийн заалтуудыг сахин биелэлтийн мониторинг ба хэмжилтийн горим журмыг батлах бөгөөд үүнд БОНАТ болон ГШ-ын амжилттай биелэлт, мөн үнэлгээний явцад тогтоосон суурь үзүүлэлттэй харьцуулахад өнгөрсөн хугацаанд олсон амжилт сайжралт багтана. Мониторингийн цар хүрээ байгаль орчин болон өртсөн нийгмийн бүлгүүдэд оногдсон эрсдэл ба сөрөг нөлөөтэй дүйцэж байна байна. Мониторинг ер нь гүйцэтгэлийг мөшгөхийн тулд мэдээллийг бүртгэх, нийцэлт ба ахицыг нотлох холбогдох ажиллагааны хяналтыг тогтоох, мөн хяналт шалгалтын тайлан дээр холбогдох хууль хэрэгжүүлэх байгууллагатай хамтран ажиллах ба нийгмийн бүлгийн гишүүд мэт сонирхогч этгээдүүдтэй эргэж холбоо тогтоох явдал юм. Үүнээс гадна, үйлчлүүлэгч гуравдагч тал болох бие даасан эксперт, орон нутгийн нийгмийн бүлэг, ТББ-г өөрийн мониторингийн мэдээллийг баяжуулах эсхүл нотлуулах зорилгоор ашиглаж болно. А зэрэглэлийн төслийн хувьд үйлчлүүлэгчээс төсөлд Банкны оролцоо үргэлжлэх

21. Мониторингийн үр дүнг ажиллагааны гүйцэтгэлийг засч, сайжруулахад ашиглах ёстой. Үүний адил мониторингийн ажлыг гүйцэтгэлийн туршлага болон эргэх холбоог харгалзан зохицуулж болно. Төслийн хэрэгжилтийн явцад үйлчлүүлэгчийн өөрийн мониторингийн үр дүн, засгийн газрын шалгалтын тайлан, гуравдагч талын аудит/тайлан эсхүл зээлдүүлэгчдийн мониторинг нь БОНАХТ-д ямар өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг сөхөж өгч болно. Үйлчлүүлэгч мониторингийн үр дүнд үндэслэн нэмэлт орсон БОНАХТ ба нөхөн олговрын хөтөлбөрт аливаа шаардлагатай залруулга, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодруулан тусгах бөгөөд түүнийг Банкинд батлуулахаар хүргүүлнэ. Үйлчлүүлэгч тохиролцсон засч залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг биелүүлэх хийгээд тэдгээрийн үр өгөөжийг хангахын тулд тэдгээр арга хэмжээний хойноос ажиллах хэрэгтэй.
22. Үйлчлүүлэгчийн байгууллагын дээд менежмент байгаль орчны болон нийгмийн менежментийн системийн ажиллагааны тогтмол үнэлгээ, мөн системтай мэдээлэл цуглуулга ба шинжилгээнд үндэслэсэн БОНАХТ-н хэрэгжилтийн ахицыг авч байх ёстой. Ийм тайлагналтын цар хүрээ ба давтамж нь үйлчлүүлэгчийн менежментийн систем/хөтөлбөр, БОНАХТ болон төслийн холбогдох бусад шаардлагын дагуу сонгон хэрэгжүүлж байгаа ажиллагааны шинж чанар, цар хүрээнээс шалтгаална.
23. Үйлчлүүлэгчид өөрийн талбай руу Банкны байгаль орчны эсхүл нийгмийн мэргэжилтнүүд, эсхүл Банкны нэрийн өмнөөс ажиллаж байгаа зөвлөхүүдээс мониторингийн аялал, уулзалт хийхэд дэмжлэг үзүүлнэ.
24. Банкинд тогтмол тайлагнах ажлын нэг хэсэг болгон үйлчлүүлэгчид өөрсдийн БОНАХТ-н явц, ахицын талаар ЕСБХБ-д шинэчилсэн мэдээ өгч байна. БОНАХТ-н хэрэгжүүлэлтийн явц, ахицын гадны тайланг оролцуулан төслийн хэрэгжилтийн явц дахь оролцогч этгээдүүдийн оролцоог ГШ 10-ын дагуу явуулна.

ЕСБХБ Гүйцэтгэлийн Шаардлага 2: Хөдөлмөр ба Ажлын нөхцөл

Танилцуулга

1. ЕСБХБ нь аливаа бизнест ажиллах хүчин бол үнэ цэнэтэй актив, хүний нөөцийн сайн менежмент хийгээд холбоо байгуулах чөлөө, хамтын хэлэлцээ хийх эрх зэрэг ажилчдын эрхийг хүндэтгэх үндсэн дээр бий болсон ажилчин-менежментийн харилцаа нь үйлдвэрийн газрын тогтвортой байдлын гол бүрэлдүүлэх хүчин зүйл гэдэгт итгэдэг. Ажилчдад шударгаар хандсанаар, тэднийг аюулгүй ба эрүүл ажлын нөхцөлөөр хангаснаар үйлчлүүлэгчид бодит олз ашгийг бий болгож чадна, тухайлбал өөрийн ажиллагааны үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх. Эсрэгээр, зохистой ажилчин/менежмент харилцааг байгуулж, дэмжиж чадахгүй бол ажилчны үнэнч хариуцлагатай байдал, ажилд тогтох явдлыг талаар болгож, төслийг аюулд оруулж, улмаар үйлчлүүлэгчийн нэр хүндэд сэв суулгана.

Зорилтууд

2. ЕСБХБ өөрийн ажиллагаагаараа бусад байгууллага, тухайлбал ОУХБ, ЕХ-ны дорвитой ажлын хөтөлбөр дэвшүүлэх санаачлагуудыг дэмжихийг хүсч байна. Үйлчлүүлэгчийн хүний нөөцийн бодлого, горим журам болон стандарт наад зах нь дараахид чиглэглсэн байх ёстой:
 - Ажилчин-менежментийн доголдолгүй харилцааг бий болгож хадгалах;
 - Шударга хандлага, ялгаварлан гадуурхахгүй байдал болон ажилчдын тэгш бололцоог дэмжих;
 - Үйлчлүүлэгч нэг тал нь болж байгаа аливаа хамтын хэлэлцээр, үндэсний хөдөлмөрийн болон ажлын байраар хангах хууль, мөн энэ бүх харилцааны цөм болох ОУХБ-ын конвенциудад биеллээ олсон суурь зарчим болон гол зохицуулалтын стандартад нийцэж байх явдлыг хөхүүлэн дэмжих¹;
 - Ялангуяа аюулгүй бөгөөд эрүүл ажлын нөхцлийг дэмжиснээр ажилчдын эрүүл мэндийг хамгаалах.

Хэрэглээний цар хүрээ

3. Үйлчлүүлэгчийн бүхий л байгаль орчны болон нийгмийн ажлын төлөвлөгөө ба/эсхүл менежментийн системийн нэг хэсэг болгон энэ ГШ-н холбогдох шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэхийг Банк ба үйлчлүүлэгч тохиролцоно. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагыг ГШ 1 ба ГШ 10-т тусгав.
4. Энэ ГШ-ын туршид “ажилчин” нэр томъёог үйлчлүүлэгчийн ажилтнуудад хамааруулан хэрэглэсэн болно. Хөлсний бус ажилчдын хувьд ГШ-н хамаарал 19-р зүйлд туссан болно. Нийлүүлэлтийн хэлхээний асуудал 20 ба 21-р зүйлд тусгалаа олсон.

¹ ОУХБ-ын конвенци 29 ба 105 (албадан ба халамжлагат хөдөлмөр), 87 (холбоо байгуулах чөлөө), 98 (олон нийтийн хэлэлцээ хийх эрх), 100 ба 111 (гадуурхал), 138 (доод нас) 182 (хүүхдийн хөдөлмөрийн хамгийн адаг хэлбэрүүд).

Шаардлага

Ажилчдын харилцааны менежмент

Хүний нөөцийн бодлого

5. Үйлчлүүлэгч түүний хэмжээ болон ажиллах хүчинд зохистой хүний нөөцийн бодлогыг баталж мөрдөх бөгөөд тэр нь энэ ГШ-ын шаардлагатай нийцсэн ажиллах хүчний менежмент хийх хандлагыг тодорхойлно. Эдгээр бодлого нь тод томруун, ойлгомжтой бөгөөд ажилчдад хүртээмжтэй байна.

Ажлын харилцаа

6. Үйлчлүүлэгч бүх ажилчинд тэдгээрийн ажлын нөхцөл ба цалин хөлс авах эрх, ажлын цаг, илүү цагийн зохицуулалт ба илүү цагийн нөхвөр, мөн аливаа хөнгөлөлт /өвчний улмаарх чөлөө, эх/эцэг болох урамшил хөнгөлөлт, мөн баяр ёслол/ хөлсөөр ажиллах нөхцлийг баримтжуулж хүргүүлнэ.

Ажиллах нөхцөл ба Ажил эрхлэлтийн нөхцөл

Ерөнхий зүйл

7. Хамгийн багаар гэхэд төслүүд дараахтай нийцэж байх ёстой. Үүнд:
 - үндэсний хөдөлмөр, нийгмийн даатгал, мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны хуулиуд
 - ОУХБ-ын конвенцуудад² тусгалаа олсон дараахи зарчим, стандарт:
 - a) Хүүхдийн хөдөлмөрийг устгах;
 - b) Албадан хөдөлмөрийг үгүй хийх;
 - c) Ажил эрхлэлттэй холбоотой ялгаварлан гадуурхлыг устгах;
 - d) Холбоо байгуулах ба хамтын хэлэлцээ хийх чөлөө.

Хүүхдийн хөдөлмөр

8. Үйлчлүүлэгч насанд хүрээгүйчүүдыг ажилд авахтай холбоотой үндэсний хуулиудын бүх заалтыг биелүүлнэ. Ямар ч тохиолдолд үйлчлүүлэгч хүүхдийг ажилд авахдаа тэр нь эдийн засгийн мөлжлөгийн чанартай байх, эсхүл аюултай байх, эсхүл хүүхдийн боловсролд сөргөөр нөлөөлөх, эсхүл хүүхдийн эрүүл мэнд эсхүл бие махбодын, оюуны, сэтгэлийн, ёс суртахууны болон нийгмийн хөгжилд нь хохиролтой байх замаар хийж болохгүй. 18 наснаас доош настай залуу хүмүүсийг аюултай ажилд авахгүй бөгөөд 18 наснаас доош настай хүмүүсийн гүйцэтгэх бүх ажлыг зохих эрсдлийн үнэлгээнд хамааруулна.

Албадан хөдөлмөр

9. Үйлчлүүлэгч албадан хөдөлмөрийг хөлслөхгүй, тэр нь сайн дурын бусаар, хүч хэрэглэх эсхүл торгуулийн сүрдүүлэлтийн дор хийгдэх аливаа ажил, үйлчилгээнээс бүрдэнэ. Энэ нь аливаа төрлийн сайн дурын бус эсхүл заавал хөдөлмөр, тухайлбал гэрээлэгдсэн хөдөлмөр, өрийн оронд хийж байгаа хөдөлмөр, эсхүл ижил хөдөлмөрийг гэрээлэх тохиролцоонуудыг багтаана..

Үл ялгаварлан гадуурхах ба тэгш боломж

² ОУХБ-ын конвенци 29 ба 105 (албадан ба халамжлагат хөдөлмөр), 87 (холбоо байгуулах чөлөө), 98 (олон нийтийн хэлэлцээ хийх эрх), 100 ба 111 (гадуурхал), 138 (доод нас) 182 (хүүхдийн хөдөлмөрийн хамгийн адаг хэлбэрүүд).

10. Төслүүд ажил эрхлэлттэй холбоотой үл ялгаварлан гадуурхах ЕХ-ны шаардлагыг биелүүлнэ. Тухайбал, үйлчлүүлэгч:

- Ажлын зайлшгүй шаардлагад хамаагүй хүйс, арьс өнгө, яс үндэс, гарал, шашин шүтлэг, хөгжлийн хязгаардмал байдал, нас эсхүл бэлгийн чиг баримжаа зэрэг хувь хүний шинж чанараар ажилд авах эсэх шийдвэр гаргахгүй байх.
- Ажил эрхлэлтийн харилцааг тэгш боломж ба шударга хандлагын зарчим дээр үндэслүүлж, ажил эрхлэлтийн харилцааны бүх асуудлаар ялгаварлан гадуурхахгүй байх, үүнд ажилд авах, нөхөн олговор /цалин урамшууллыг оролцуулан/, ажлын нөхцөл, ажил эрхлэлтийн нөхцөл, сургалтанд хамаарах боломж, албан тушаалдаа дэвших, ажил эрхлэлтийг дуусгавар болгох эсхүл тэтгэвэрт гарах, мөн сахилга батын асуудал орно.

Өнгөрсөн үеийн ялгаварлан гадуурхлыг арилгах буюу эмчлэхэд туслах тусгай арга хэмжээ, эсхүл орон нутгийн боломж бололцоог дэмжих, эсхүл үндэсний хуулийн дагуу ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн ажилд авах сонголтыг ялгаварлан гадуурхал гэж үзэхгүй.

Ажилчдын байгууллагууд

11. Үйлчлүүлэгч ажилчдыг өөрсдийн хүссэн байгууллагыг байгуулах, эсхүл өөрсдийн сонгосон байгууллагад нэгдэх, эсхүл хамтын хэлэлцээ хийхийг хориглох, тэдгээр байгууллагад нэгдсэн, эсхүл нэгдэх хүсэлтэй, хамтын хэлэлцээнд оролцох хүсэлтэй ажилчдыг ялгаварлан гадуурхахгүй, эсхүл өшөө хонзон санахгүй байна. Үндэсний хуулийн дагуу үйлчлүүлэгч тэдгээр ажилчдын байгуулагатай ажиллаж, үр дүнтэй хэлэлцээ хийхэд шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь өгч байна. Хэрэв үндэсний хууль ажилчдын байгууллагыг байгуулах, ажиллуулах явдлыг үлэмж хязгаарлаж байвал үйлчлүүлэгч ажлын нөхцөл болон ажил эрхлэлтийн нөхцлийн талаар ажилчдыг гомдлоо илэрхийлэх, эрхээ хамгаалах боломж хэрэгслээр хангана. Тэдгээр хэрэгсэл нь үйлчлүүлэгчийн нөлөө эсхүл хяналтын дор байж болохгүй.

Цалин, урамшуулал ба ажлын нөхцөл

12. Санал болгох цалин, урамшуулал ба ажлын нөхцөл нь тухайн орон/бүс нутгийн төстэй газар нутаг эсхүл салбарт олгодоогоос ерөнхийдээ нэг их ялгаагүй байна. Үйлчлүүлэгч хамтын хэлэлцээний гэрээний нэг тал, эсхүл ямар нэгэн хэмжээгээр түүнийг сахих үүрэгтэй бол тэр гэрээг хүндэтгэх ёстой.

Мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа /МЭМАА/

13. Үйлчлүүлэгч нь өөрийн салбарын угийн эрсдэл болон үйлчлүүлэгчийн ажлын талбайн аюулын тодорхой ангилал, тухайлбал бие махбодийн, химийн, биологийн ба радиологийн аюулыг анхааралдаа авч ажилчдыг аюулгүй ба эрүүл ажлын орчин тойрноор хангана. Үйлчлүүлэгч ажлын явцад үүсэх эсхүл хамаатай аваарь осол, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах замаар авна:

- Ажилчдад учирч болох аюулын эх үүсвэрийг илрүүлэх, боломжийн хирээр багасгах;
- Шинэчлэл, орлуулалт хийх эсхүл аюултай нөхцлийг арилгах;
- Эрсдлийг багасгах төхөөрөмжөөр хангах, түүнийг ашиглахыг шаардаж ажил хэрэг болгох;
- Ажилчдын сургалт, тэд эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны горим журмыг мөрдөх, хамгаалалтын төхөөрөмжийг ашиглах зохих урамшууллын системийг тогтоох;

- Мэргэжлийн осол, өвчин, тохиолдлыг баримтжуулж тайлагнах;
 - Онцгой тохиолдлоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдал ба хариу арга хэмжээ.
14. Төслүүд холбогдох ЕХ-ны МЭМАА-ны шаардлагыг ханган биелүүлнэ, хэрэв тийм шаардлага байхгүй бол холбогдох ОУСК-ийн МЭМАА-ны удирдамжийг дагана.
 15. Дээрхи шаардлагыг хангахын тулд үйлчлүүлэгч өөрийн бизнесийн шинж чанар, хэмжээнд, мөн олон улсын сайн практикт³ тохирох МЭМАА-ны менежментийн системийг хэрэглэнэ.
 16. Хэрэв үйлчлүүлэгч ажилчдаа байраар хангах бол байр нь зохистой байршилтай, цэвэр аюулгүй ба ажилчдын суурь хэрэгцээг хангасан байх ёстой. Юуны өмнө байр нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын сайн стандартыг хангах ёстой боловч түүгээр хязгаарлагдахгүй: байрны хөлсийг нэхэмжлэх практик, ажилчин нэг бүрийг наад захын байрны талбайгаар хангах, аж ахуйн, угаалга болон хоол бэлтгэх боломжтой байх, уух ундны устай байх, ажлын байрнаас холгүй байх, эрүүл мэндийн цэгт ойрхон, галын болон бусад аюултай цэгээс хол, эмнэлгийн анхны тусламж болон бусад эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх боломжтой, дулаан ба вентилацитай байх. Үйлчлүүлэгчээс олгосон байранд ажилчид чөлөөтэй орох, гарах явдлыг үндэслэлгүйгээр хязгаарлаж болохгүй.

Ажлаас халах

17. ЕХ-ны 98/59-р захирамжийн 1-р зүйлд зааснаар хэрэв үйлчлүүлэгч хамтын ажлаас халах үйлдлийг хүлээж байгаа бол үйлчлүүлэгч ажлаас халах явдлын сөрөг нөлөөг багасгах төлөвлөлөөг үндэсний хууль болон салбарын сайн практикийн дагуу үл ялгаварлан гадуурхах болон харилцан зөвлөлдөх үндсэн дээр боловсруулна. Үндэсний хуулийн илүү хатуу заалтыг алгасч дээрх зөвлөлдөөн ажил эрхлэлтийн өөрчлөлтийн үндэслэл бүхий мэдэгдлийг ажилчдын төлөөлөгчдэд, шаардлагатай бол холбогдох эрх бүхий олон нийтийн байгууллагад хүргүүлнэ, тэгснээр ажлаас халах төлөвлөгөөнд хамрагдах ажигчдад ажлаас халагдах сөрөг нөлөөг багасгах үүднээс хамтран судлах боломжтой болно. Зөвлөлдөөний үр дүнг ажлаас халах эцсийн төлөвлөгөөнд тусгана..

Зарга гомдлын механизм

18. Ажлын байртай холбоотой үндэслэл бүхий зарга гомдол гаргах механизмыг үйлчлүүлэгч ажилчдад /мөн тэдний гишүүнчлэлийн байгууллаагад/ бий болгоно. Үйлчлүүлэгч ажилчдад зарга гомдлын механизмыг ажилд авах үед нь танилцуулж, түүнд амархан нэвтрэх боломжийг олгоно. Механизм нь зохих түвшингийн менежмент, яаралтай хандах хаягийг багтаах бөгөөд ойлгомжтой, ил тод процессыг багтаах хийгээд энд хариу өшөө хонзонгийн асуудал гарахгүй. Энэ механизм үйлчилж байгаа хууль, арбитражийн процессын дагуу бусад хууль захиргааны байгууллагад хандах боломжийг хязгаарлахгүйгаас гадна хамтын гэрээгээр тохирсон гомдлын механизмыг орлохгүй.

Ажил эрхлэлтийн гэрээгүй ажилчид

19. Хэрэв гэрээт гүйцэтгэгч эсхүл бусад дундын хүмүүсийн туслалцаатайгаар төслийн талбай эсхүл төслийн гол ажиллагаатай шууд холбоотой ажил гүйцэтгүүлэхээр үйлчлүүлэгчээс ажилчдыг хөлсөлсөн бол үйлчлүүлэгч: (i) тэрхүү гэрээт гүйцэтгэгч болон дундын этгээд нэр хүндтэй хууль ёсны этгээд байхыг тогтоох; ба (ii) тэд дээрхи 6-16-р ба 18 –р зүйлд заасан шаардлагыг биелүүлэхийг шаардах хэрэгтэй. Хэрэв

Нийлүүлэлтийн хэлхээ

20. Хэрэв ажлын бага хөлс нийлүүлсэн зүйлийн өрсөлдөөний бодит хүчин зүйл болсон байвал нийлүүлэлтийн хэлхээтэй холбоотой сөрөг нөлөөг авч үзнэ. Ийм орчинд үйлчлүүлэгч төслийн гол ажиллагаанд чухал бараа материалын нийлүүлэлтэд хүүхдийн хөдөлмөр болон албадан хөдөлмөрийг⁴ ашигласныг мэдэх талаар зохистой алхам хийвэл зохино.
21. Хэрэв үйлчлүүлэгч ОУХБ-ын стандартын сөргөөр нийлүүлэлтийн хэлхээнд хүүхдийн болон албадан хөдөлмөрийг ашигласан нь тогтоогдож, бараа материал нь ЕСБХБ-наас санхүүжүүлэх үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулахаар бол үйлчлүүлэгч дээрхийг зохицуулахын тулд дараах шаардлагын дагуу бүх үндэслэл бүхий алхмыг хийнэ.:
- (а) Хүүхдийн хөдөлмөрийн хувьд үйлчлүүлэгч зөвхөн сайн үнэлгээ авсан бараа материалыг үргэлжлэн захиалахдаа тэрхүү нийлүүлэгч олон улсын сайн практикийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг үндэслэл бүхий цаг хугацаанд аажим аажмаар шахаж гаргах хөтөлбөрийг мөрдөж байгаагаа нотлох чадвартай байх. Үйлчлүүлэгч тийм хөтөлбөрийн ахицыг ЕСБХБ-д тогтмол мэдээллэх үүрэгтэй..
- (b) албадан хөдөлмөрийн хувьд үйлчлүүлэгч нийлүүлэгчээс зохих чанартай бараа материалыг авахдаа нийлүүлэгч албадан хөдөлмөрийг үгүй болгох орчныг бий болгох чиглэлээр зохих алхам хийж байгаагийн хангалттай оролдлого хийж байгаагийн нотолгоог хүлээн авбал зохино.

⁴ ОУХБ-ын 138, 182, 29, 105-р конвенцид тодорхойлсноор.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба багасгах

Танилцуулга

1. Тогтвортой хөгжил нь сайн бизнес менежментийн суурь үзүүлэлт хийгээд эдийн засгийн өсөлт ба эрүүл байгаль орчны төлөөх хөөцөлдөөн хоорондоо маш хэцүү холбоотойг ЕСБХБ хүлээн зөвшөөрч байна. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн салшгүй хэсэг бол бохирдлоос урьдчилан сэргийлэх ба түүнийг багасгах явдал бөгөөд ЕСБХБ-наас санхүүжүүлж байгаа төслүүд үүнтэй холбоотой олон улсын сайн практикийг дагах ёстой. Бохирдлын ажиллагаатай холбоотой нөлөө, асуудлуудыг эдийн засгийн бүх үйл ажиллагаанд авч үзэх хэрэгтэй, зохистой бол үйлдвэрийн хаягдал, гаргалтаас эхлээд бүс нутаг, дэлхий дахины хэмжээнд.
2. Байгаль орчны Европын зарчмуудад гарын үсэг зурсны хувьд ЕСБХБ дараах үүрэгтэй:
 - Санхүүжүүлж байгаа ажиллагаагаар дамжуулан болгоомжтой хандах зарчим, урьдчилан сэргийлэх зарчим, байгаль орчинд учруулсан хохирлыг эх үүсвэр дээр нь зас залруулах тэргүүлэх зорилго байх бөгөөд бохирлогчид мөнгө төлөх зарчмыг дэмжинэ.
 - ЕХ-ны холбогдох стандарт, ялангуяа аж үйдвэр, ус ба хаягдын менежмент, агаар ба хөрсний бохирдол, мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа¹ болон байгалийг хамгаалах² арга хэмжээг төслийн түвшинд дэмжих /үүнээс цааш “ЕХ-ны байгаль орчны шаардлага” гэх/³.

Зорилго

3. Гүйцэтгэлийн шаардлага/ ГШ/ -ын зорилго бол:
 - Хүний эрүүл мэнд ба байгаль орчинд учруулах сөрөг нөлөөнөөс зайлсхийлэх, хэрэв боломжгүй бол төслөөс шууд шалтгаалах бохирдлыг аль болохоор багасгах;
 - Эрчим хүч, нөөцийн үр ашгийг дээшлүүлэх, хаягдлыг багасгах талаар үйлчлүүлэгчид туслах;
 - Төсөлтэй холбоотой хүлэмжийн хийг багасгахад туслах.

Хэрэглээний хүрээ

4. Үйлчлүүлэгчийн ерөнхий байгаль орчны нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /БОНАХЕТ/ болон менежментийн системийн дор энэ ГШ-ын холбогдох шаардлага хэрхэн хэрэгжигдэхийг Банк үйлчлүүлэгчтэй тохирно. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ, мөн менежментийн шаардлагыг ГШ1 болон ГШ 10-т тусгав.

¹ Мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа ГШ 2-т тусгалаа олсон.

² Биологийн олон төрөлхт байдал ГШ 6-д тусгалаа олсон.

³ Энэ Бодлого болон ГШ-ын зорилгоор ЕХ-ны байгаль орчны стандартуудыг төслийн түвшинд хэрэглэж болно, учир нь ЕХ-ны хуулийн баримтууд үйлдвэрлэл дээр хэрэглэж болох тодорхой тооны болон чанарын үзүүлэлтүүдийг агуулдаг юм /тухайбал, гадны түвшингийн эсрэгээр харьцуулбал/.

Шаардлага

Ерөнхий зүйл

5. Доорхи 6-р зүйлийн дагуу төслүүд ЕХ-ны байгаль орчны шаардлага, холбогдох үндэсний хуульд нийцэхээр төлөвлөгдөх бөгөөд тэдгээр хууль, шаардлагын дагуу ажиллана.
6. Ерөнхийдээ байгаль орчны өндөр хамгаалалтыг хангахын тулд ЕХ-ны байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний шаардлага одоо байгаа хамгийн сайн арга барил дээр суурилсан хэдий ч ямар нэгэн арга барил эсхүл тодорхой технологийг заагаагүй, гэхдээ холбогдох угсралтын техникийн үзүүлэлт, газар зүйн байршил, орон нутгийн байгаль орчны нөхцлийг анхааралдаа авсан байдагийг хүлээн зөвшөөрдөг. Тэдгээр шаардлагыг хангахын тулд БОНАХТ-ний заалтууд үндэсний хэмжээнд тохирсон ЕХ-ны хууль тогтоомжтой нийцүүлэх цаг хугацааг /ЕХ-д элсэх орнуудын хувьд/ анхааралдаа авах хэрэгтэй. ЕХ-ны гишүүн бус, гишүүн болох, гишүүн болохоор хөөцөлдөж байгаа оронд хэрэгжих төслүүдийн хувьд БОНАХТ-д ЕХ-ны байгаль орчны шаардлагыг хангах хугацаа хоёр талын хэлэлцээр эсхүл ЕХ болон холбогдох орны хооронд тохирсон арга хэмжээний төлөвлөгөөтэй нийцэж байх ёстой, гэхдээ өргөдлийн өртөг ба одоогоор давамгайлж байгаа орон нутгийн нөхцлийг анхааралдаа авах ёстой.
7. ЕХ-ны байгаль орчны шаардлага байхгүй тохиолдолд үйлчлүүлэгч Дэлхийн банкны группын БОЭМАА-ны удирдамж мэт олон улсын өөр сайн практикийг хэрэглэвэл зохино. Ийм тохиолдолд Банк үйлчлүүлэгчтэй холбогдох шаардлагыг төсөл бүрээр тохирно.
8. Хэрэв хүлээн авагч орны журам ЕХ-ны байгаль орчны шаардлагын түвшин, арга хэмжээ, мөн 7-р зүйлийн дагуу тохирсон шаардлагаас зөрж байвал төсөл дээр хамгийн хатуугийг нь хэрэгжүүлнэ.
9. Төсөл бүр дээр Банк үйлчлүүлэгчтэй холбогдох байгаль орчны шаардлага, удирдамжийг тохирно.

Бохирдлоос сэргийлэх, нөөцийг хадгалах ба эрчим хүчний үр ашиг

10. Төслийн зураг төсөл, барилга, үйл ажиллагаа болон татан буулгах /төслийн цикл/ үед үйлчлүүлэгч холбогдох угсралтын техникийн үзүүлэлт, түүний газар зүйн байршил, орон нутгийн /орчмын/байгаль орчны нөхцлийг судалж, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хамгийн сайн тохирох, сөрөг нөлөөнөөс зайлсхийх, болохгүй бол багасгах, бохирдлоос сэргийлэх болон хяналтын технологи, практикийг хэрэглэнэ.
11. Үйлчлүүлэгч бохирдуулагч бодисыг гадагшлуулахгүй байх, хэрэв боломжгүй бол тэр гаргалтын хэмжээг аль болохоор багасгаж, хяналтанд авах. Энэ нь бохирдуулагч бодисыг ердийн , ердийн бус эсхүл аваарь ослын улмаас алдаж, орон нутаг, бүс, цаашлаад улс орон давсан шинж чанартай байж болно. Үүнээс гадна үйлчлүүлэгч цэвэр үйлдвэрлэлийн зарчимд нийцэх өөрийн ажиллагаанд эрчим хүч хэмнэх, ус болон бусад баялгийг хэмнэх арга хэмжээг нэвтрүүлэх ёстой.

Хаягдал⁴

12. Үйлчлүүлэгч аль болохоор хортой ба хортой бус хаягдлын материалын гаргалтыг багасгана. Хаягдлыг зогсоох боломжгүй, гэхдээ багасгасан тохиолдолд үйлчлүүлэгч хаягдлыг дахин ашиглах, эргэлтэнд оруулах эсхүл нөхөн сэргээнэ, хэрэв түүнийг нөхөн сэргээх, дахин ашиглах боломжгүй бол эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах, үйлчлүүлэгч хаягдлыг байгаль орчинд халгүй замаар устгаж зайлуулна. Хэрэв гарсан хаягдал аюултай гэж тооцогдвол үйлчлүүлэгч хил давуулах хязгаарлалтыг бодолцон түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга замыг хайна. Хэрэв хаягдлыг гуравдагч тал зайлуулах бол үйлчлүүлэгч нэр хүндтэй, холбогдох зохицуулах байгууллагын лицензтай хууль ёсны байгууллага болох гэрээт гүйцэтгэгчийг ашиглана.

Аюултай бодис, материалын аюулгүй ашиглалт ба менежмент

13. Хүний эрүүл мэнд ба байгаль орчныг хорт нөлөөнөөс хамгаалах үүднээс үйлчлүүлэгч аюултай бодис, материалыг ашиглахаас татгалзах, багасгахыг урьдал болгож, тэдний оронд аюул багатай орлогчдыг ашиглахыг авч үзнэ. Хэрэв тэднийг ашиглахгүй байх боломжгүй бол үйлчлүүлэгч тэдний ашиглалтын аюулгүй байдлыг анхаарч, төслийн ажиллагаатай холбоотой тэдний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, зайлуулалтаас үүсч мэдэх тэдгээр бодис, материалыг агаар, ус, газарт алдах явдлыг аль болохоор багасгах холбогдох эрсдлийн менежментийн арга хэмжээг авах. Үйлчлүүлэгч аюултай бодис, бодит амьд организмд учруулах хохирол, байгальд урт хугацаагаар хадгалагдах боломж, биохуримталлын боломж, озоны давхрагыг устгах боломжтойг харгалзан тогтоосон олон улсын хорио, аажмаар салах арга хэмжээний улмаас аюултай бодис, материалын үйлдвэрлэл, худалдаа болон ашиглалтаас татгалзана.

Онцгой байдлын бэлтгэл ба хариу

14. Үйлчлүүлэгч процессын доголдол, тохиолдлын болон онцгой байдалд ажиллагааны эрсдлийн адил бэлэн байдалтай байж, тэдний сөрөг үр дагавраас сэргийлэх хэрэгтэй. Үйлчлүүлэгч ГШ 4-н 18-22 –р зүйл заасан шаардлагыг ашиглаж, хамгаалалтын өндөр түвшинг тууштай үр дүнтэй хангах замаар том ослын аюулыг илрүүлэх, том ослоос сэргийлэх, хүмүүс болон байгаль орчинд үзүүлэх үр дагаврыг хязгаарлана.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэл

15. Үйлчлүүлэгч бүх дулааны ялгаруулалт, урсгал болон хаягдлыг бүртгэж, мониторингоор гаргах процессыг тогтмол үндсэн дээр нэвтрүүлнэ. Үйлчлүүлэгчид төсөлтэй холбоотой бохирдуулагчдын гаргалтыг Европын бохирдуулагч гаргалт ба шилжүүлгийн бүртгэл (Е-ХГШБ)⁵ -д мэдээлэх шаардлагатай, энэ мэдээллийг мөн ЕСБХБ-д өгнө.

⁴ Энэ ГШ-ын зорилгоор хаягдлыг хий, шингэнба/эсхүл хатуу бодис/материалын хольц бөгөөд түүнийг байгаль орчинд аюулгүй гаргахын өмнө хангалттай физио, хими ба/эсхүл биологийн процессыг ашиглан боловсруулах шаардлагатай гэж тодорхойлсон байна.

⁵ ЕХ-ны болон ЕХ-нд гишүүнээр элсэх орнуудад байрлаж байгаа, бохирдуулагчийг агаар, ус эсхүл газарт тогтоосон онцлог нормоос хэтрүүлэн гаргадаг компаниуд гаргаж тайгаа тоо хэмжээнд мониторинг хийж Е-ХГШБ-д тайлагнах шаардлагатай. хийж Е-ХГШБ-ийг ЕХ-ны 166/2006-р тогтоолоор баталсан хийгээд Европын гаргалтын бүртгэлийг залгамжлах юм.. (<http://eper.ec.europa.eu/eper>).

Гадна талаархи бодол

16. Байгаа гадаад нөхцөл байдалд үзүүлэх төслийн сөрөг нөлөөг шийдвэрлэхийн тулд үйлчлүүлэгч: (i) байгаль орчны хүлээж авах эцсийн хүчин чадвар, өнөөгийн болон ирээдүйн газар ашиглалт, байгаа орчин тойрны нөхцөл, экологийн мэдрэмгий эсхүл хамгаалалтын бүст ойрхон зай, тодорхой бус, эргэж буцашгүй үр дагавартай нийлбэр нөлөөний боломж; мөн (ii) бохирдуулагч зүйлсийг алдахыг хаасан, эсхүл тэр боломжгүй бол алдалтыг аль болохоор багасгах стратегийг хэрэглэх, үүнд ялангуяа төсөл нь ялгаруулах дулааныг урьд нь чанараа алдсан талбайд гаргах үлэмж эх үүсвэр болох тохиолдолд анхаарах. Эдгээр стратеги нь төслийн янз бүрийн байршлын үнэлгээ болон дулааны ялгаруултын асуудлыг багтаах бөгөөд зөвхөн түүгээр хязгаарлагдахгүй.

Хүлэмжийн хийн гаргалт

17. Үйлчлүүлэгч төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн гаргалтыг орчин тойрон, төслийн ажиллагааны цар хүрээ болон нөлөөтэй зохицуулан багасгана.

18. Ихээхэн хэмжээний ХХ⁶ гаргахаар төлөвлөж байгаа эсхүл гаргаж байгаа төслийн хэрэгжүүлэлтийн явцад үйлчлүүлэгч үндсэн /хөрөнгө оруулалтын өмнөх/ ХХ гаргалт болон төслийг хэрэгжүүлсний дараахи ХХ гаргалтын хэмжээг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулж хүргүүлнэ. Мэдээллийн шаардлагын удирдамжийг Банкнаас авбал зохино. ХХГ-ын үнэлгээ нь төслийн эзэмшилд байгаа талбай доторхи байгууламжаас гарах шууд гаргалт, мөн төсөл шалтгаалах аливаа гадны ажиллагаанаас гарах хийг багтаана, үүнд талбайн гадна төсөлд ашиглах эрчим хүчний үйлдвэрлэлээс гарах гаргалт орно. Төслийн хил хязгаарын тодорхойлолтын удирдамжийг Банкнаас⁷ авна. ХХ гаргалтын⁸ тооцоог хийхэд шаардлагатай тоо материалыг цуглуулах болон үзүүлэлтүүдийн мониторингийг төслийн хэрэгжилтийн хугацаанд жил бүр хийнэ.

19. Үүнээс гадна, үйлчлүүлэгч төслийг боловсруулах ба ажиллуулах явцад нүүрсний хүч чадлаа бууруулах техникийн ба санхүүгийн үндэслэлтэй, зардал хэмнэх боломжуудыг судлах бөгөөд зохистой боломжийг мөрдөнө.

Хортонтой тэмцэх бодис /пестицид/-ын ашиглалт ба менежмент

20. Үйлчлүүлэгч нэгтгэсэн пестицидын менежмент /НПМ/-ыг боловсруулан хэрэгжүүлэхийн хамт, эсхүл пестицидын менежментийн ажиллагаанд зориулсан нэгтгэсэн вектор менежмент /НВМ/-ийн хандлагыг хэрэгжүүлнэ. Үйлчлүүлэгчийн НПМ ба НВМ-ийн хөтөлбөр нь пестицидын уялдсан ашиглалт болон байгаль орчны мэдээллийг

⁶ ХХ гаргалтанд төслөөс оруулах хувь нэмрийн хэмжээ аж үйлдвэрийн салбаруудын хооронд ялгаатай байдаг. Өөр өөр салбарт байдаг төслүүдтэй холбогдох боломжийн ХХ гаргалтын хэмжээний талаархи удирлагыг *ЕСБХБ Хүлэмжийн хий гаргалтын үнэлгээний аргачлал –ЕСБХБ-наас санхүүжүүлж байгаа төсөл дээр ажиллаж байгаа зөвлөхүүдийн удирдамж (GNO)-д олж болно.* Энэ Гүйцэтгэлийн шаардлагын дээд норм бол ерөнхийдээ жилд 100,000 тон СО2 өөрийн хэрэглээнд шууд ба шууд бус эх үүсвэрээс худалдаж авсан цахилгаантай холбоотой нийлбэр гаргалттай тэнцүү байна. Гэвч хэрэв төсөл үйлдвэрлэлийн үр ашигтай ажиллагаанд томоохон сайжруулалт хийх зорилго тавьж байгаа бол гаргалтын доогуур норм зохимжтой байж мэднэ. Ийм тохиолдолд Үйлчлүүлэгч Банктай ийм тохиолдолд ХХ-н үнэлгээнд зориулж мэдээ баримтыг цуглуулах шаардлагатай эсэхийг зөвлөлдөхийг дэмжинэ.

⁷ Мэдээ баримтын шаардлагын удирдамж болон төслийн хил хязгаарын тайлбарыг тус тус Банкны *Байгаль орчны үүдит болон үнэлгээний протоколууд* * болон *ЕСБХБ-ны Хүлэмжийн хий гаргалтын үнэлгээний аргачлалал - ЕСБХБ-наас санхүүжүүлж байгаа төсөл дээр ажиллаж байгаа зөвлөхүүдийн удирдамж (GNI)* –д байгаа.

⁸ Тухайбал, түлшний тоо хэмжээ эсхүл цахилгааны ашиглалт.

пестицидын хяналтын арга, үүний дотор пестицидын хохирлын хүлээж авамгүй түвшингээс сэргийлэх хэрэглээний соёлын практик, биологийн, генетикийн, эцэст нь химийн арга хэрэгслийг дагалдуулна. Хэрэв пестицидын менежментийн ажиллагаа пестицидын хэрэглээг багтааж байвал үйлчлүүлэгч хүний эрүүл мэнд болон байгаль орчинд учруулах пестицидын нөлөөг бууруулахыг аль болохоор хичээнэ, ерөнхийдээ пестицидыг аль болохоор бага хэрэглэж, ургацыг хамгаалах шаардлагатай нийцүүлэн пестицидтай холбоотой эрсдэл, ашиглалтыг үлэмж багасгана. Пестицидын боломжийн хэрэглээ нь дараахийг багтаана:

- Пестицидын хэрэглээг аль болохоор багасгах, боломжтой бол хэрэглэхгүй байх,
- Пестицидыг ашигласнаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд учрах аюул, эрсдлийг аль болохоор багасгах,
- Хор ихтэй идэвхтэй бодисыг аюул багатай /үүний дотор химийн бус/ бодисоор сольж аюулын түвшинг бууруулах,
- Хүний эрүүл мэндэд хор багатай, зориулагдсан төрөл зүйлд үр дүнтэй, зориулагдаагүй төрөл зүйлд бараг үйлчилдэггүй пестицидыг сонгох,
- Бага орцтой эсхүл пестицидыг хэрэглэдэггүй ургамлыг тариалах,
- Байгалийн дайсанд учруулах хохирлыг багасгах, пестицидэд эсэргүүцэл үүсэхээс сэргийлэх.

21. Үйлчлүүлэгч Хүнс ба хөдөө аж ахуйн байгууллагын Пестицидын хуваарилалт, ашиглалтын талаархи ажиллагааны олон улсын код зэрэг олон улсын сайн практикийн дагуу пестицидтай харилцаж, хадгалж, хэрэглэж устгана.

22. Хэрэв хүлээн авагч орон тэдгээр химийн бодисын хуваарилалт, ашиглалтын талаар муу хязгаарлалттай, эсхүл ажилтнууд зохих сургалтгүй, төхөөрөмжгүй, харьцах, хадгалах, хэрэглэх эсхүл устгах байгууламжгүй бол үйлчлүүлэгч Олон улсын эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн пестицидын ангиллыг аюлын Ia /маш аюултай/, Ib /өндөр аюултай/ эсхүл II /дунд зэргийн аюултай ангид орсон бүтээгдэхүүнийг ашиглахгүй.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 4:

Нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал

Танилцуулга

1. ЕСБХБ нь төслийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж болон дэд бүтэц нь ажил эрхлэлт, үйлчилгээ болон эдийн засгийн хөгжлийн бололцоо мэтийн ашиг тусыг нийгмийн бүлгүүдэд авчирдагийг хүлээн зөвшөөрдөг. Гэвч төсөл нь нийгмийн бүлгийн эрсдэл, нөлөөнд өртөх боломжийн хүрээг өргөсгөдөг, тухайлбал хүн амын түр зуурын эсхүл байнгын өөрчлөлт, түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тээвэрлэлт, барилга, үйлдвэрийн ажиллагаа, хаалт, аварь осол, бүтцийн бүтэлгүйдэл, аюултай материалын алдагдал.
2. Нийгмийн бүлгүүд мөн тэдний байгалийн нөөцөнд үзүүлэх нөлөө, өвчин ба аюулгүйн ажилтнуудын нөлөөнд өртөж болно. Төрийн байгууллагуудын олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахад оруулах хувь нэмрийг хүлээн зөвшөөрөхдөө энэ Гүйцэтгэлийн шаардлага /"ГШ"/ төслийн ажиллагаанаас үүсч болох нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөг илрүүлж, зайлсхийх эсхүл багасгах талаархи үйлчлүүлэгчийн хариуцлагыг тодорхойлно.
3. Энэ ГШ-д тусгагдсан эрсдэл, нөлөөний түвшин нь зөрчилдөөнтэй, эсхүл мөргөлдөөн болсон бүс нутаг, мөн байгалийн болон хүний зохиосон ноцтой тохиолдолтой газарт /тухайлбал газар хөдлөлт, үерт автдаг бүс газар/ өндөр байх магадлалтай.

Зорилтууд

4. Энэ ГШ-ын зорилт бол:
 - Төслийн хэрэгжилтийн хугацаанд орон нутгийн нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд өдөр тутмын болон онцгой тохиолдлоос учрах эрсдэл, нөлөөнөөс зайлхийх эсхүл багасгах;
 - Төсөлтэй холбоотой ажилтнууд болон өмч хөрөнгийг хамгаалах явдал хууль ёсны дагуу явагдаж, нийгмийн бүлгийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй, эсхүл аль болохоор бага эрсдэл учруулах маягаар явагдах байдлыг хангах.

Хэрэглээний хүрээ

5. Энэ ГШ-ын хэрэглээг Банк байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессын явцад тогтооно. Хэрэв хэрэглэж болмоор бол Банк үйлчлүүлэгчтэй энэ ГШ-ын шаардлагын биелэлт, менежментийг үйлчлүүлэгчийн бүхэл байгаль орчин, нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө/ БОНАХТ/ эсхүл менежментийн системийн хэсэг болгон хэрэгжүүлэхээр тохирно. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ ба менежментийн шаардлагыг ГШ 1 ба ГШ 10-т тусгасан болно.
6. Энэ ГШ төслийн үйл ажиллагаанаас, үүнд барилга, ажиллагааны эхлэл, ажиллагаа болон хаалт багтана, өртсөн нийгмийн бүлэгт учирч болзошгүй эрсдэл, нөлөөнд зориулагдсан болно. Учирч болзошгүй нөлөө төслийн шат шатаас өрчлөгдөж болно. Мэргэжлийн эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны стандартыг ГШ 2-оос, бохирдлын улмаас хүний эрүүл мэнд болон байгаль орчинд учрах нөлөөнөөс сэргийлэх нарийвчилсан шаардлагыг ГШ 3-аас олж болно.

Шаардлага

Нийгмийн бүлгийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны шаардлага

Ерөнхий шаардлага

7. Төслийн зураг төсөл, барилга, ажиллагаа болон хаалтын ажлын явцад өртсөн нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, нөлөөг тогтоож, үнэлэх бөгөөд тэднийг шийдвэрлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ, төлөвлөгөөг илрүүлсэн эрсдэл, нөлөөтэй дүйцэхүйц маягаар зохионо. Эдгээр арга хэмжээ нь эрсдэл, нөлөөг сэргийлэх, зайлсхийлэхийг багасгах, бууруулахаас урьтал болгоно.
8. Хэрэв төсөл эсхүл төслийн үе шат өртсөн нийгмийн бүлгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд бодит эрсдэл эсхүл болзошгүй сөрөг нөлөө үзүүлэхээр байвал үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлэг болон засгийн газрын холбогдох байгууллагуудад тэдгээр эрсдэл болон болзошгүй нөлөөг ойлгоход шаардлагатай төсөлтэй холбоотой мэдээллийг ил тод болгохын хамт үйлчлүүлэгчийн санал болгож байгаа сэргийлэх, багасгах ба онцгой байдлын хариуг зохистой бол нээж дэлгэнэ. Үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлэг болон засгийн газрын байгууллагуудтай санал болгосон арга хэмжээнүүдийн талаар зөвлөлдөж, тэднийг эцсийнх болохоос өмнө тэдгээрийн санал, санаа зовоох зүйлсийг анхааралдаа авна. Үйлчлүүлэгч арга хэмжээнүүдийг тогтмол хянаж нягтална, өртсөн нийгмийн бүлэг болон засгийн газрын байгууллагуудтай тогтмол үндсэн дээр харилцаж, тэдэнд төлөвлөгөө, үүргийн биелэлт, үр дүнгийн талаар мэдээлж, өөрчлөлт тулахын өмнө төлөвлөгөөнд оруулах шаардлагатай аливаа бодит өөрчлөлтийг хэлэлцэнэ. Нээлттэй болгосон мэдээллийг нэгтгэж /хувь эзэмшигчдэд эрсдэл, болзошгүй нөлөө болон авах арга хэмжээг бүрэн ойлгох боломж олгох нарийн шийрийн зүйлийг хадгалан/, нууц мэдээллийг арилган засварлана.
9. Үйлчлүүлэгч төслийн эрсдэл, болзошгүй нөлөө, ач холбогдол болон аливаа арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тогтмол үндсэн дээр /тухайлбал жил бүр/ ЕСБХБ-д хүргүүлэх бөгөөд ГШ 10-ын дагуу хувь эзэмшигчдэд тайлагнах ажлын нэг хэсэг болгон өртсөн нийгмийн бүлгүүдэд хүргүүлнэ.

Дэд бүтэц ба тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

10. Үйлчлүүлэгч олон улсын аж үйлдвэрийн сайн практикийн дагуу төслийн бүтцийн элемент эсхүл зүйл ангиудын зураг төслийг гаргах, барих, ажиллуулах ба хаах бөгөөд байгалын аюул, ялангуяа бүтцийн элементууд өртсөн нийгмийн бүлгийн гишүүдийн хүрэх газарт байдаг эсхүл гаргасан алдаа нийгмийн бүлэгт шууд ба шууд бус хохирол учруулах тохиолдолд маш анхааралтай байна. Бүтцийн элементуудын зураг төсөл, босголтыг мэргэжсэн ба туршлагатай мэргэжилтнүүд хийх бөгөөд эрх бүхий байгууллага эсхүл мэргэжилтнүүдийн гэрчилгээ, баталгаа авсан байх ёстой.
11. Далан, хаягдлын далан эсхүл үнсний цөөрөм мэтийн бүтцийн элемент эсхүл эд анги нь өндөр эрсдэлтэй байршилд байрлаж байгаа, тэдний алдаа болон буруу ажиллагаа нь нийгмийн бүлгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх бол үйлчлүүлэгч холбогдох, ижил төсөлд хүлээн зөвшөөрөгдсөн, туршлагатай нэг ба түүнээс олон мэргэжилтнийг зураг төсөл, барилгын ажилд зориулагдсанаас салган төслийн хөгжил, төслийн зураг төсөл, барилга, ашиглалтанд өгөх бүхий шатанд аль болохоор эртхэн хянан нягтлалыг явуулахын тулд хөлслөх хэрэгтэй. Хөдлөх тоног төхөөрөмжийг олон нийтийн замд ажиллуулдаг төслийн хувьд үйлчлүүлэгч тэдгээр тоног төхөөрөмжтэй холбоотой аварь ослоос сэргийлэх арга замыг хайна.

Аюултай материалын аюулгүй ажиллагаа

12. Үйлчлүүлэгч төслөөс гарч болох аюултай материалд нийгмийн бүлэг өртөх боломжоос сэргийлэх, эсхүл багасгах боломжийг хайна. Хэрэв нийгмийн бүлэгт /ажилчид ба тэдний гэр бүлийг оролцуулан/ сөрөг нөлөө, ялангуяа амьдралд халтай аюулд өртөх боломж үүсвэл үйлчлүүлэгч аюул учруулж байгаа аюулын нөхцлийг өөрчлөх, орлуулах эсхүл зайлуулах замаар тэр нөлөөнөөс зайлсхийх эсхүл багасгах талаар онцгой анхаарна.
13. Хэрэв аюултай материал нь байгаа төслийн бүтэц эсхүл эд ангийн хэсэг бол үйлчлүүлэгч нийгмийн бүлэгт сөргөөр нөлөөлөхгүйн тулд эхлэлийн болон хаалтын ажиллагаанд онцгой анхаарал тавина. Үйлчлүүлэгч хорт хавдар эсхүл уушигний өвчин мэт биеэр дамжигдахгүй өвчинг үүсгэдэг хэмээх материалын түвшингийн талаар мэдээлэл авахын тулд мэдэл бүхий байгууллагатай харьцаж ажиллана.
14. Үүнээс гадна үйлчлүүлэгч тээвэрлэж байгаа түүхий эдийн аюулгүй ажиллагааг хангах, хаягдлыг тээвэрлэх устгах явдлын аюулгүй байдлыг хянах болон нийгмийн бүлэг өртөхгүй байх эсхүл түүнийг багасгах арилжааны үндэслэлтэй арга хэмжээ авна. Эрсдлийн тухай, түүнд өртөгдөх хүн ам, түүнийг багасгах арга хэмжээ ба мониторингийн мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, олон нийтийн хүртээл болгоно.

Байгаль орчны ба байгалийн баялаг, нөөцийн асуудлууд

15. Үйлчлүүлэгч төслийн ажиллагааны улмаас газрын ашиглалтын өөрчлөлтөөс үүсч болох газрын гулсалт, үер зэрэг байгалийн гамшгийн нөлөөний хэтрүүлэлтээс сэргийлэх, зайлсхийх эсхүл багасгах ёстой.
16. Үйлчлүүлэгч төслийн ажиллагаанаас агаар, хөрс, ус, ургамал, амьтны ертөнц болон нийгмийн бүлэг ашиглаж байгаа бусад байгалийн нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөг арилгах эсхүл багасгах үүрэгтэй.

Өвчинд нэрвэгдэх нийгмийн бүлгийн аюул

17. Үйлчлүүлэгч төслийн эд анги болон түүний ажиллах хүч /гэрээт гүйцэтгэгчдийг оролцуулан/ -ээр дамжих өвчнийг илрүүлнэ. Зохимжтой газарт төслийн ажиллагаанаас үүсч болох өвчнөөс ажилчид болон нийгмийн бүлэг хэсгийг хүн хүнээс дамжих өвчнөөс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна. Хэрэв тодорхой өвчин төслийн бүс нутгийн нийгмийн бүлгүүдийн дунд тархсан бол үйлчлүүлэгч төслийн хугацаанд уг тархалтыг, ажиллах хүчний дунд, мөн орон нутгийн хэмжээнд багасгахад дөхөмтэй байгаль орчны нөхцлийг бий болгох боломжийг хайх хэрэгтэй.

Онцгой байдлын бэлтгэл ба хариу

18. Үйлчлүүлэгч процессын хямрал, аварь ослын болон онцгой байдалд ажиллагааны эрсдэлд зохимжтой байдлаар хариулах болон тэдгээрийн болзошгүй сөрөг нөлөөнөөс сэргийлэх бэлтгэлтэй байх ёстой.
19. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны болон аюулгүй байдлын эрсдэл, төсөлтэй холбоотой ажиллагаа /дэррхи 7-р зүйлийг үзнэ үү/-ны болзошгүй нөлөөний үнэлгээний нэг хэсэг болгон үйлчлүүлэгч том ослын аюулыг илрүүлж, том ослоос сэргийлэхэд шаардагдах, хүний эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлөх үр

- Үр дагавар, хүн, байгаль орчин болон өмч хөрөнгөнд учруулах хохирлыг багасгах, хяналтын дор байлгах,
 - Том ослын үр дагавраас хүн, байгаль орчныг хамгаалахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх,
 - Шаардагдах мэдээллийг олон нийт, онцгой байдлын байгууллага болон холбогдох бүс нутгийн эрх бүхий байгууллагуудад дамжуулах,
 - Том ослын мөрөөр байгаль орчныг сэргээх, цэвэрлэх үйлчилгээ үзүүлэх.
20. Үйлчлүүлэгч онцгой байдалд дорвитой хариулах бэлтгэл ажилд нийгмийн бүлэг болон орон нутгийн засаг захиргаадад тусалж, хамтран ажиллана, ялангуяа тийм онцгой байдалд хариулахад түүний оролцоо, хамтын ажиллагаа шаардлагатай нөхцөлд дээрх улам их ча холболдолтой. Хэрэв орон нутгийн захиргааны байгууллагууд үр дүнтэй хариу арга хэмжээ авах бага хүчин чадалтай, эсхүл тийм хүчин чадал байхгүй бол үйлчлүүлэгч төсөлтэй холбоотой онцгой байдалд бэлтгэх, хариулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэх бөгөөд урьдчилан мэдэж болох хувьд шууд болон шууд бус хариулах хүчин чадлаа үзүүлнэ /өөрөөр хэлбэл, онцгой байдалд хариу өгдөг байгууллага, гэрээлсэн гуравдагч тал болон даатгагчдын тусламжтайгаар. Үйлчлүүлэгч онцгой байдлын бэлтгэл ба хариу ажиллагаа, нөөц болон хариуцлагыг баримтжуулан холбогдох мэдээллийг өртсөн нийгмийн бүлэг болон холбогдох засгийн газрын байгууллагад БОНАХТ эсхүл бусад холбогдох баримт бичигт тусган ГШ 10-ын дагуу хүргүүлнэ. Онцгой байдлаас сэргийлэх, хариулах төлөвлөлтийн нэг хэсэг болгон үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлгийг болзошгүй аюулын тухай мэдээлж, хариу төлөвлөгөөг зохистой аргаар нэгтгэн хүргүүлнэ.
21. Үйлчлүүлэгч урьдчилан сэргийлэх ба хариу араг хэмжээний төлөвлөгөөний туршилтыг салбарт зохимжтой хуваарь болон төсөлтэй холбоотой эрсдлийг харгалзан наад зах нь жилд нэг удаа явуулна. Төлөвлөгөө өөрчлөгдөх эсхүл туршилтад орсон тухай бүр үйлчлүүлэгч орон нутгийн захиргаа болон нийгмийн бүлэгт мэдэгдэж байна.
22. Бодит онцгой байдлын хариуны нэг хэсэг болгон үйлчлүүлэгч холбогдох онцгой байдлын багууллага, эрх бүхий байгууллага, хэвлэл мэдээлэл болон орон нутгийн нийгмийн хэсэгтэй холбоо барьж, тэдгээрт бий болсон байдал, хариу арга хэмжээ болон ирээдүйн аюул ослоос сэргийлэх талаар хийж байгаа ажлын тухай мэдээлнэ.

Аюулгүй байдлыг сахих ажилтнуудад тавих шаардлага

23. Хэрэв үйлчлүүлэгч өөрийн ажилтан болон өмч хөрөнгийг хамгалуулахаар ажилтан, гэрээт гүйцэтгэгчийг шууд хөлсөлбөл тэр төслийн талбай, байгууламжийн дотор болон гадна байгаа этгээдэд түүний хамгаалалтын хэлэлцээнээс үүсэх эрсдлийг хариуцна. Тийм хэлцэл хийхдээ үйлчлүүлэгч пропорциональ байдлын зарчим, хөлслөхийн хувьд олон улсын сайн практик, сургалт, төхөөрөмжлөл, биеээ авч явах байдал, тийм ажилтнуудад¹ зохих хуулийн дагуу мониторинг хийх явдлыг

24. Хэрэв засгийн газрын аюулгүй байдлыг хангах ажилтнуудыг үйлчлүүлэгчид аюулгүйн үйлчилгээг хангах зорилгоор байрлуулсан бол үйлчлүүлэгч тэрхүү ашиглалтаас үүсэх эрсдлийг үнэлж, холбогдох төрийн байгууллагуудад аюулгүй байдлыг хангах ажилтнууд дээрх 23-р зүйлийн дагуу ажиллах зорилготой байгаагаа уламжилж, холбогдох төрийн байгууллагуудыг үйлчлүүлэгчийн байгууламжийн талаар тохирсон аюулгүйн хэлцлүүдийг олон нийтэд ил тод болгох явдлыг хөхүүлэн дэмжинэ, ингэхдээ аюулгүй байдлыг хангах үндсэн санаа зовоосон асуудлуудыг анхаарна.
25. Үйлчлүүлэгч аюулгүйн ажилтнуудын хууль бус, хүнийг дарамталсан тухай гомдлыг судлах бөгөөд арга хэмжээ /эсхүл зохих талуудаас дээрхи зүлийг давтуулахгүйн тулд арга хэмжээ авахыг хүсч, хууль бус, дарамталсан тухай баримтуудыг зохистой үед төрийн байгууллагуудад мэдээлнэ.

¹ Тухайлбал, Аюулгүй байдал ба Хүний эрхийн талаархи Сайн дурын зарчмууд, <http://www.voluntaryprinciples.org/principles>

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 5:

Газар эзэмшил, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн шилжилт хөдөлгөөн

Танилцуулга

1. Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт нь бодит нүүлгэн шилжүүлэлт /өөр газарт нүүх эсхүл байраа алдах/ болон төсөлтэй холбоотой газар авалт¹ эсхүл байгалийн нөөц баялагт хүрэхийг хязгаарласны ² улмаас учрах эдийн засгийн шилжин хөдөлгөөний /активаа алдах, улмаар орлогын эх үүсвэр болон амьдралын боломжийг алдах/ аль алинд хамаарна.
2. Хэрэв өртссөн хувь хүн эсхүл нийгмийн бүлэг нүүлгэн шилжүүлэлтэд хүргэх газар авалтыг эсэргүүцэх эрхгүй бол нүүлгэн шилжүүлэлтийг сайн дурын бус гэж үздэг. Энэ нь дараах тох иолдолд болдог : (i) төрөөс хувийн өмчийг нөхөн олговрын үндсэн дээр албадан хураан авах, газар ашиглалтад хязгаар тавих төрийн хууль ёсны үйлдэл³; ба (ii) хэрэв худагчидтай хийж байгаа хэлэлцээр бүтэлгүйдвэл худалдан авагч албадан хурааж авах, эсхүл газар ашиглалтанд хязгаарлалт тавих хэлэлцэж тохирсон үйлдлүүдийг хийх.
3. Энэ ГШ-ыг хэрэглэх нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, сахих, ялангуяа зохих байртай байх, мөн аьдралын нөхцлийг тогмол сайжруулах нийтлэг эрхтэй нийцэнэ ⁴. ЕСБХБ оролцохоос өмнө зөрчилдөөний улмаас нүүлгэн шилжүүлэлт тохиолдсон бол энэ ГШ Дотоодын нүүлгэн шилжилжилтийн Удирдах зарчмуудыг хэрэглэх явдлыг дэмжиж байна ⁵.
4. Зохих ёсоор удирдахгүй бол сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт урт хугацааны хүндрэл болон өртсөн хувь хүн ба нийгмийн бүлэгт ядуурал учруулахын хамт байгаль орчинд хохирол болон тэднийг нүүлгэн шилжүүлсэн бүс нутагт нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэх талтай. Зарим нөхцөлд муу зохион байгуулсан сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт бусад бүс нутагт үйлчлүүлэгчийн эсрэг хуулийн арга хэмжээ авахад хүргэж мэднэ. Энэ нь төсөл нь шүүх эрх хангалтгүй, нүүж шилжсэн хүмүүс хуулийн тусламж авах, горим журмын хамгаалалтг хүний эрхийн олон улсын конвенцийн дагуу хүртэх боломж муутай бүс нутагт байршиж байвал ялангуяа үнэн талтай. Эдгээр шалтгааны улмаас сайн дурын нүүлгэн шилжүүлэлтээс зайсхийх, болохгүй бол цар хүрээг нь аль болохоор багасгах хэрэгтэй. Хэрэв зайлсхийлэх боломжгүй бол нүүн шилжсэн хүмүүст болон хүлээн авах нийгмийн бүлгүүдэд⁶ учрах сөрөг нөлөөг саармагжуулахад чиглэсэн зохих арга хэмжээг анхааралтай төлөвлөж хэргжүүлэх хэрэгтэй. Өнгөрсөн туршлага нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн шууд оролцоо, зураг төслийн боломжтой бол эртний шатанд үэнлгээ хийх явдал эдгээр ажиллагааг зардал багтай, үр ашигтай болон цаг

¹ Газар эзэмшил нь өмч хөрөнгийг даруй худалдан авах болон замаар явах мэт нэвтрэх эрхийг худалдан авахын аль алиныг багтаана.

² Жишээнд улсын өмч болох газрын гадаргуу доорхи ашигт малтмалд нэвтрэх эрхийг гараар олборлогчид алдах, төслийн ажиллагааны улмаас далайн загасны нөөцөд нэвтрэх эрхгүй болох, үйлчлүүлэгч өөрийн болгоогүй улсаас тогтоосон онцгой бүсэд байршилтай нөөц баялагт нэвтрэхийн хязгаарлалт, төсөлтэй холбоотой үймээн шуугиан ба/эсхүл бохирдуулалтаас шалтгаалан хөдөө аж ахуй, мал аж ахуй, ой мод, ан агнуур болон загас барилтын үр өгөөж харваас буурсан явдал орж болно.

³ Гийм хязгаарлалт хуулиар зориулсан байгалийн хадгалалтын талбайд нэвтрэх хязгаарлалтыг багтааж болно.

⁴ Хүний эрхийн тухай нийтлэг Тунхаглал /1948/ ба Эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн Олон улсын Пакт /1966/

⁵ Хүний эрхийн Дээд Комисарын офис : Дотоодын нүүлгэн шилжүүлэлтийн удирдах Зарчмууд

⁶ Хүлээн авагч нийгмийн бүлэг нь нүүж шилсэн хүмүүсийг хүлээн авч байгаа аливаа нийгмийн бүлэг. анхааралтай төлөвлөж хэргжүүлэх хэрэгтэй. Өнгөрсөн туршлага нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн шууд оролцоо, зураг төслийн боломжтой бол эртний шатанд үнэлгээ хийх явдал эдгээр ажиллагааг зардал багтай, үр ашигтай болон цаг хугацаанд биелүүлэх боломж олгохоос гадна нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийн амьдрал, амьжиргааны стандартыг сайжруулахад шинэ хандлагыг хөгжүүлэх талтай.

5. Хэлэлцэж олсон тохиролцоонууд албадан хураалтаас зайлсхийх, хүмүүсийг засгийн газрын зүгээс хүчээр нүүлгэх шаардлагыг арилгахад тусалдаг. Тохиролцоонуудыг ерөнхийдээ шударга болон зохистой нөхөн олговор, бусад санаачилга, ашиг тусыг өртсөн хүмүүс ба нийгмийн бүлэгт санал болгох, мэдээллийн тэнцүү биш эрсдэл болон хэлцэх хүчийг зөөлрүүлэх замаар хүрч болно. Тиймээс үйлчлүүлэгчид бололцооны хирээр газрын эрхийг хэлэлцэж тохирох замаар олж авахыг зөвлөж байна, хэдийгээр тэд худалдагчийн зөвшөөрөлгүйгээр түүний газарт нэвтрэх хуулийн бололцоотой гэсэн ч.

Зорилтууд

6. Энэ ГШ-ын зорилтууд дараахид оршино:

- Төслийн альтернатив хувилбарыг эрж хайх замаар сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтээс боломжийн хирээр зайлхийх, эсхүл наад зах нь багасгах⁷;
- Газар эзэмшлийн эсхүл өртсөн хүмүүс газрыг ашиглах, газарт нэвтрэх хязгаарлалтын улмаас тулгарах сөрөг нийгмийн болон эдийн засгийн нөлөөг дараах замаар саармагжуулах: (i) активаа алдсаныг орлуулах өртгийн хэмжээнд нөхөн олговор олгох⁸; мөн (ii) сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийг мэдээллийн зохих нээлтэй байдал, зөвлөлдөөн болон өртөгсдийн мэдээлэлтэй оролцоотой хэрэгжүүлэх замаар газар эзэмшлийн сөрөг нийгмийн болон эдийн засгийн нөлөөг саармагжуулах, эсхүл өртсөн хүмүүс газар ашиглах, түүнд хүрэхэд тавьсан хязгаарлалтыг сулруулах,
- Газарт, цалинд, үйлдвэрт тулгуурласан байж болох арга хэмжээгээр дамжуулан нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн⁹ амьдрал орчин, амьжиргааны стандартыг сайжруулах, эсхүл наад зах нь төслийн өмнөх түвшинд хүргэх, ингэснээр тэдний нийгэм-эдийн засгийн статусын тогтворжуулалтыг хангах;
- Нүүлгэн шилжүүлэх цэгүүдэд эзэмшихэд аюулгүй¹¹, тохиромжтой байраар¹⁰ хангах замаар нүүж шилжсэн хүмүүсийн амьдралын нөхцлийг сайжруулах.

Хэрэглээний цар хүрээ

7. Энэ Гүйцэтгэлийн шаардлага биет эсхүл эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамаатай бөгөөд тэр нь дараах төрлийн хэлцлээс шалтгаалан бүрэн, хэсэгчилсэн, байнгын болон түр хугацааных байж болно:

- Төсөлд зориулсан газрын эрхийг албадан хураах мэт бусад заавал горим журмаар авсан.
- Төсөлд зориулсан газрын эрхийг өмчлөгч болон газар эзэмших хууль ёсны эрхтэй, үүнд тухайн орны хуулиар зөвшөөрдөг уламжлалт ба эдэлж заншсан эрхтэй этгээдүүдийн хооронд нүүж шилжихийг хэлэлцэн тохирох замаар авсан, хэрэв албадан хураах ба бусад заавал арга процесс хэлэлцээ бүтэлгүйдэхэд нөлөөлөх нөхцөлд¹².

- Хязгарлалт тавих нь хүмүүс бодит актив эсхүл байгалийн баялагт хүрэх боломжийг алдахад хүргэх бөгөөд ингэхдээ хязгаарлалт тавих ийм эрхийг хэлэлцээ хийх, албадан хураах, дарамтлан худалдаж авах эсхүл засгийн газрын зохицуулалтын арга хэмжээний дүнд олж авсан нь энд хамаагүй.
8. Сууж байгаа газраа эзэмших хүлээн зөвшөөрөгдөх хууль ёсны эрхгүй нүүж шилжсэн хүмүүст тавих шаардлага болон хариуцлагыг доорхи 31, 36 ба 39-р зүйлд заасан.
 9. Энэ ГШ сайн дурын газрын хэлцлээс урган гарах нүүн шилжилтэд хамаарахгүй /өөрөөр хэлбэл, худалдагч худалдах үүрэггүй, худалдан авагч хэрэв хэлэлцээ бүтэлгүйдвэл албадан хураах зэрэг хүчний арга хэрэгслийг хэрэглэх боломжгүй зах зээлийн хэлэлцээ тохиролцоо болно/.
 10. Энэ ГШ-г хэрэглэх эсэхийг байгаль орчин ба нийгмийн үнэлгээ хийх явцад дэрхи 7 - 9-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ЕСБХБ шийдвэрлэнэ. Энэ ГШ-г хангахад шаардагдах арга хэмжээний биелэлтийг үйлчлүүлэгчийн байгаль орчин ба нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /БОНАХТ/ болон менежментийн системаар удирдана. Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт Банк оролцохоос өмнө болсон бол а/аливаа зай завсар болон б/ энэ ГШ-тай нийцэх явдлыг хангахын тулд шаардагдаж болох засч залруулах арга хэмжээг тодорхойлохын тулд зохистой ажиллагааг явуулна. Тэгээд арга хэмжээний төлөвлөгөөг тохиролцоо хэрэгтэй. Нүүлгэн шилжүүлэх процессын үнэлгээ болон менежментийг энэ ГШ-д тусгав. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ, менежментийн шаардлагыг ГШ 1 ба ГШ 10-т тусгасан болно.

⁷ Хэрэв тэр нь Банкны үзэж байгаагаар өртсөн хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг дордуулахгүй бол.

⁸ Ер нь үүнийг активын зах зээлийн үнэ дээр тэдгээр активыг нөхөн сэргээхтэй холбогдсон хэлцлийн өртгийг нэмэх замаар тооцдог. Газрын ялгаварал, газрыг ашиглалтын нэхэмжлэгч, газрын зах зээлийн хөгжлийн түвшин гишүүн орнуудад өөр өөр байдгаас шалтгаалан нөхөн орлуулалтын өртгийн тооцоо нарийн төвөгтэй байдаг. Ийм учраас үйлчлүүлэгч газар эзэмшлийн улмаас нүүн шижих бүх хүн ба нийгмийн бүлгийг тогтоож зөвшилцөхийн хамт нүүн шилсэн хүмүүсийг хүлээн авагч нийгмийн бүлгүүдтэй мөн зөвлөлдөж, газрын эрх, нэхэмжлэх ба ашиглалтын талаар хангалттай мэдээлэл олж авах хэрэгтэй. Үнэлгээний энэ аргыг хэрэглэснээр бүтцүүд ба активын элэгдэл хорогдлыг анхааралдаа авахгүй. Газрын зах зээл дөнгөж эхлэлийн байдалд байгаа газарт үйлчлүүлэгч үнэлгээг гадны бие даасан мэргэжлийн үнэлгээний экспертуудаар хийлгэхийг эрмэлзэх шаардлагатай /эсхүл тэнд мэргэжлийн үнэлгээний экспертууд байхгүй бол ЕСБХБ болон үйлчлүүлэгчид хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох мэдлэг, туршлагатай мэргэжлийн хүмүүсээр хийлгэнэ/. Мөн 17-р тайлбарыг үзнэ үү.

⁹ Эдгээр нь хуулиар хүлээн зөвшөөрөгдөх газар эзэмших эрхтэй эсхүл нэхэмжлэхтэй хүмүүс, газарт заншлалын нэхэмжлэгтэй хүмүүсгазар эзэмших хуулиар хүлээн зөвшөөрөгдөөгүй газрын эрх, эсхүл нэхэмжлэхтэй хүмүүс, мал хариулах/загас барих гэр бүлгүүд, анчин, мөөг, жимс цуглуулагчид зэрэг улирлын нөөцийг ашигладаг хүмүүсийг багтааж болох бөгөөд тэд төслийн бүсэд байрлаж байгаа нийгмийн бүлгүүдтэй харилцан хамаатай байж болно.

¹⁰ Тохиромжтой байр буюу хоргодох байрыг чанар, аюулгүй байдал, үнэ, оршин суугчдын суурьшил, соёлын зохимж, хүртэмж болон байршлын шинж тэмдгээр хэмжиж болно. Тохиромжтой байр ажил эрхлэлтийн хувилбар, зах зээл, үндсэн дэд бүтэц ба үйлчилгээ /ус, цахилгаан, эрүүл ахуй, эрүүл мэнд ба боловсролын байгаллага зэрэг/-нд хүрэх бололцоогоор хангах ёстой. Энэ ГШ нь Нүүлгэн шилжүүлэх цэгүүдэд эзэмшихэд аюулгүй ¹¹, тохиромжтой байраар¹⁰ хангах чадвартай. Үйлчлүүлэгчид нүүлгэн шилжүүлэх цэгүүдэд сайжруулсан амьдралын нөхцлийг ялангуяа эзэлж байгаа газрын хувьд хууль ёсны эрх эсхүл нэхэмжлэх байхгүй хүмүүст санал болгох зорилгоор энэ өгүүлбэрт тохиромжтой байрны талаар нэг эсхүл түүнээс олон хөндөх асуудлыг оруулбал зохино.

¹¹ Нүүлгэн шилжүүлэх цэг хэрэв тэр бололцооны дээд хэмжээгээр нүүн шилжсэн хүмүүсийг байрнаас нь албадан хөөхөөс хамгаалж чадаж байвал тэр тэдгээрийн эзэмших эрхийг хамгаалахыг санал болж байна.

¹² Энэ хэлэлцээрийг газрыг эзэмших гэж байгаа хувийн салбарын компани эсхүл уг компанийн агент хийж болно. Газар эзэмших эрхийг засгийн газар авч өгч байгаа хувийн салбарын төслийн тохиолдолд хэлэлцээрийг засгийн газар, эсхүл түүний агент болох хувийн компаний явуулж болно.

Шаардлага

Ерөнхий шаардлага

Төслийн дизайн

11. Үйлчлүүлэгч нь бие махбодын ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх эсхүл багасгах чиглэлээр төслийн үндэслэл бүхий альтернатив дизайнуудыг авч үзэх бөгөөд ингэхдээ байгаль орчин, нийгэм болон санхүүгийн өртөг ба ашиг тусыг тэнцвэржүүлэхийг эрмэлзэнэ.

Зөвлөлдөөн

12. Холбогдох бүх мэдээллийг нээлттэй болгосны дараа үйлчлүүлэгч өртсөн хүмүүс болон нийгмийн бүлэгтэй, үүний дотор хүлээн авагч бүлэгтэй зөвлөлдөж, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой шийдвэр гаргах процесст тэднийг эрт, мэдээлэлтэй оролцохыг ГШ 10-ын дагуу дэмжиж тусална.

- Өртсөн хүмүүст ¹³ нөхөн олговрын багцын хэлэлцээр, тэгш эрхтэйгээр оролцох шаардлага, нүүн шилжилтийн туслалцаа, санал болгож буй нүүлгэн шилжүүлэлтийн цэгүүдийн тохижилт болон санал болгож буй цаг хугацааны хэлэлцээнд оролцох боломжийг олгох ёстой.
- Нутгийн уугуул хүмүүсийг, мөн эмзэг хэсэгт багтдаг хүмүүсийг ¹⁴ оролцуулсан зөвлөлдөөнд тусгай анхаарал тавих ёстой /ГШ 7-г үзнэ үү/.
- Энэ ГШ-н зорилгуудтай нийцэх үр дүнд хүрэхийн тулд зөвлөлдөөн хэрэгжилт, мониторинг, нөхөн олговрын төлбөрийг үнэлэх болон нүүн шилжих явцад үргэлжлэн явагдана.

Гомдол заргын механизм

13. ГШ №-ын дагуу гүйцэтгэгчээс байгуулах гомдол заргын механизмыг энэ ГШ-тай нийцэх процессын явцад нүүлгэн шилжүүлсэн хүмүүс болон хүлээн авагч нийгмийн бүлгийн гишүүдээс босгосон нөхөн олговор болон тараан суурьшуулахтай холбоотой тодорхой асуудлуудыг цаг хугацаанд нь хүлээн авч шийдвэрлэх гомдол заргын механизмыг аль болох түргэн бий болгох бөгөөд түүнд маргааныг үнэнч шударгаар шийдвэрлэхээр төлөвлөсөн туслалцаа, шударга ёсыг эрэх механизм багтана. ГШ 10-ын дагуу гомдол, тэдгээрийг шийдвэрлэх чиглэлээр авсан арга хэмжээний эмхэтгэлийг тогтмол үндснэг дээр олон нийтэд ил болгож байх ёстой.

¹³ Өмнөх эсхүл одоогийн зөрчилдөөний улмаас нүүж суурьшсан хийгээд биеэр байлцаж чадахгүй хүмүүсийг оруулна.

¹⁴ Эмзэг эсхүл эрдэлтэй бүлэгт хүйс, угсаа гарал, нас, биеийн эсхүл оюуны дутагдалтай, эдийн засгийн дутуу тал эсхүл нийгмийн статусын улмаас нүүлгэн шилжүүлэлтэд бусадтай харьцуулахад илүү өртсөн хэдий ч тархан суурьшилтын туслалцаа болон хобогдох ашиг тусыг нэхэмжлэх, давуу тал олж авах чадвар нь хумигдсан хүмүүс орно. Нүүлгэн суурьшилтын өнцгөөс эмзэг бүлэг мөн ядуугийн шугамын дор амьдардаг хүмүүс, газаргүй, өндөр настан, эмэгтэйгээр болон хүүхдээр тэргүүлсэн өрх, үндэсний цөөнх, байгалийн нөөц баялгаас шатгаалах нийгмийн бүлэг, эсхүл үндэсний газрын нөхөн олговор болон газар эзэмших эрхийн хууль тогтоомжоор хамгаалагдаагүй үлдсэн бусад нүүн суурьшсан хүмүүсийг мөн багтаана. Эдгээр бүлгийг байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессоор илрүүлэн тогтоох ёстой /ГШ 1-ийг үзнэ үү/. Эдгээр бүлэгт шилжин суурьшилтын төлөвлөлтөд утга учиртай оролцох болон хөгжлийн бололцооноос ашиг тус хүртэхэд зөвлөлдөөн болон хөгжлийн туслалцааны хэлбэр бүхий тусгай арга хэмжээ авах шаардлагатай байж мэднэ. Эмзэг хэмээн тодорхойлогдсон хүмүүс шилжин суурьшил болон нөхөн олговортой холбогдсон

өөрсдийн хувилбаруудыг бүрэн ойлгож, эрсдэл хамгийн багатай хувилбарыг сонгоход туслах шаардлагатай байна.

Тархан суурьшилтыг төлөвлөх ба хэрэгжүүлэх

14. Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх боломжгүй бол үйлчлүүлэгч зохих мэргэжлийн мэргэжилтнийг тодорхойлсон өртсөн бүс нутагт хүн амын тооллого явуулах, нийгэм-эдийн засгийн үндсийн үнэлгээг хийх, Тархан суурьшилтын арга хэмжээний төлөвлөгөө /ТСАХТ/-г буюу Аж амьдралыг сэргээн босгох тогтолцоо /ААСБТ/-г боловсруулахад туслах зорилгоор хөлсөлж, ажилд авна.

- Тооллого болон нийгэм-эдийн засгийн үндсийн үнэлгээ нь төслөөс нүүлгэн шилжүүлэх /бүрэн эсхүл хэсэгчлэн/ этгээдийг илрүүлж, хэн нөхөн олговор ба туслалцаа авахад тэнцэхийг тодорхойлж, таслах эцсийн өдрийг тогтоосноор дээрхи ашиг тусыг авах эрхгүй хүмүүсийн ¹⁵ ирцыг бууруулна.
- Үндэсний засгийн газар тодорхой горим журамгүй тохиолдолд хүн амын тооллого болон эд хөрөнгийн бүртгэлийг дуусгах өдөр сонгох эрхийг тодорхойлох эцсийн таслах өдөр болж хувирдаг. Таслах өдрийн мэдээллийг сайн баримтжуулж, төслийн бүс даяар тараана.
- Улирлын баялаг ашиглагчид төслийн бүс нутагт хүн амын тооллого явуулж байх үед байхгүй байсан байж болох хийгээд тэдгээр нийгмийн бүлгийн гомдолд онцгой анхаарал тавих хэрэгтэй.

Тархан суурьшилтын арга хэмжээний төлөвлөгөө

15. 7-р зүйлд дурдагдсан биет нүүлгэн суурьшуулалтын хэлцлийн тохиолдолд үйлчлүүлэгч байгаль орчин ба нийгмийн нөлөөний үнэлгээнд үндэслэн Тархан суурьшилтын арга хэмжээний төлөвлөгөө /ТСАХТ/-г боловсруулах бөгөөд тэр нь наад зах нь энэ ГШ-ын холбогдох шаардлагыг өртсөн хүмүүсийн тооноос үл шалтгаалан багтаана.

16. ТСААТ нь:

- Нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөг сааруулах, хөгжлийн боломжит ашиг тус илрүүлэх хийгээд өртсөн хүмүүсийн бүх зэрэглэл /хүлээн авагч нийгмийн бүлгийг оролцуулан/-ийн эрхийг тогтоохдоо онцгой анхаарлыг ядуу болон эмзэг хүмүүсийн хэрэгцээнд хандуулна;
- Газрын эрхийг авах бүх хэлцлийг баримтжуулах, мөн нөхөн олговрын арга хэмжээ, тархан суурьшилтын ажиллагааг баримтжуулна;
- Тархан суурьшилтын төлөвлөгөөний биелэлтэнд мониторинг хийх ба түүнийг үнэлэх горим журмыг тогтоож, шаардлагатай бол засч залруулах арга хэмжээг авах .

17. ТСААТ-ний цар хүрээ, нарийвчлалын түвшин нүүлгэн шилжүүлэлтийн хэмжээ, сөрөг нөлөөг саармагжуулахад шаардагдах арга хэмжээний нарийн төвөгтэй байдлаас шалтгаалан өөрчлөгдөх болно. Бүх тохиолдолд тэр энэ ТСААТ-ний зорилтуудыг биелүүлэх арга хэлбэрийг тодорхойно. Наад зах нь ТСААТ нь:

- тархан суурьшилтын зорилтыг зааж өгөх;
- төслийн нөлөөг тайлбарлах, нүүн шилжих гэж байгаа бүх хүнийг илрүүлэх , өртсөн активын бүртгэлийг явуулах;

¹⁵ Ашиг хонжоо хайсан тэнүүлчид болон саяхан ирсэн эдийн засгийн цагаачид, тэд таслах өдрийн дараа газрыг эзэлдэг.

- нүүлгэн шилжүүлэлт зайлшгүй байсан, түүний нөлөөг аль болохоор бууруулсныг тайлбарлах;
 - газар авч эзэмших, нөхөн олговор олгох хууль орчныг тайлбарлах;
 - тархан суурьшилтын боломжийн альтернативуудын талаар өртсөн хүмүүстэй хийсэн зөвөлгөөний процесс болон шийдвэр гаргах процесст тэдний оролцооны түвшинг тайлбарлах;
 - нүүн шилжсэн хүмүүсийн бүх зэрэглэлд зориулсан эдлэх эрхийг;
 - алдсан эд хөрөнгөд олгосон нөхөн олговрын ханшийг тоочиж, тэдгээр ханш нь хангалттай, тохиромжтойг тайлбарлах, өөрөөр хэлбэл алдсан эд хөрөнгийг нөхөн солих өртөгтэй тэнцүү гэдгийг итгүүлэх;
 - байр, орон сууцыг нөхөн солихтой холбогдуулан сонголт, хуварилалт, бэлтгэл боло газрын эрх олголтын процессыг тайлбарлах;
 - нүүлгэн шилжүүлэхэд үзүүлэх тусламжийг тайлбарлах;
 - нүүн шилжсэн хүмүүсийн аж амьдрал ба амьжиргааны стандартыг сайжруулах, эсхүл наад зах нь сэргээн босгох тохиролцооны нарийн зүйлсийг ярьж өгөх;
 - ТСААТ-ний биелэлтийн төлөөх институциональ/зохион байгуулалтын хариуцлага болон гомдол заргыг залруулах горим журмыг тоймчлох;
 - ТСААТ-ний биелэлтийн цаг хугацаа ба төсвийг нээлттэй болгох;
 - мониторинг, үнэлгээ, тайлагналтын талаархи хэлцээ тохиролцооны нарийвчилсан зүйлсийг ил тод гаргах; ба
 - газар эзэмшил нь аж амьдралд хохирол хүргээгүй эсхүл орлого алдагдаагүй газарт авсан газрын төлөө шударга нөхөн олговор олгож, тэнд алдсан хөрөнгийг зохих орлуулан солих өртгөөр солих.
18. ТСААТ дорой эсхүл эмзэг байж болох аливаа хүн эсхүл хэсгийг онцгойлон анхааралдаа авах ёстой. Юуны өмнө ТСААТ нь өмчийн акт, түрээсийн гэрээ нөхөн олговор /үүнд нөхөн олговрын төлбөрийг гүйцэтгэхийн тулд нээсэн бакны данс/ зэрэг өмчлөлийн эсхүл эзэмшлийн баримтууд нэг гэр бүлийн нөхөр, эхнэр эсхүл өрх тэргүүлж байгаа эмэгтэй нэр дээр нээлгэх замаар тэдгээр эмзэг, “эрсдэл дэх” хэсгүүд¹⁶ болон эмэгтэйчүүд тархан суурьшилтын процессын үеэр хохиролгүй, тэд өөрсдийн эрхийн тухай бүрэн мэдээлэлтэй бөгөөд ойлголттой, шилжин суурьшилтын боломж, ашиг тусаас тэнцүү хүртэх чадавхитай талаархи арга хэмжээг багтаах ёстойгоос гадна мэргэшлийн сургалт, зээл авах боломж, ажлын боломж зэрэг тархан суурьшилтын бусад тусламж эмэгтэйчүүдэд тэнцүү хүртээмжтэй бөгөөд тэдний хэрэгцээнд тохирсон байх явдлыг хангах ёстой. Үндэсний хууль болон өмчлөлийн систем нь эд хөрөнгө эзэмших, гэрээ хэлцэл хийх эмэгтэйчүүдийн эрхийг зөвшөөрдөггүй нөхцөлд эмэгтэйчүүдийн өмчлөлийн аюулгүй байдалд хамаарагдах явдал эрэгтэйчүүдтэй адил байна гэсэн заалтыг боломжийн хирээр тусгах шаардлагатай.
19. ТСААТ нь нүүн шилжсэн хүмүүс боломжтой газартаа газар авахын өмнө захиргааны шаардлагыг бүрдүүлэх, хэрэгцээтэй бол шүүхээс залруулгыг хайхад туслах хуулийн туслалцаагаар хангагдсан байх арга хэмжээг багтаасан байх хэрэгтэй.

20. Үйлчлүүлэгч өртсөн хүмүүс нөхөн олговрын горим журмыг ойлгох, төслийн янз бүрийн үе шатанд юуг хүлээж болохыг мэдэх / өөрөөр хэлбэл, тэдэнд хэзээ санал тавих, хариулахад хир удаан хугацаа хэрэгтэй болох, гомдол заргын горим журам,

¹⁶ Тайлбар 14-г тодорхойлсноор.
хэрэв хэлэлцээр бүтэлгүйдвэл дагалдах хуулийн ажиллагаа/ явдлыг хангахын тулд ТСААТ-нд тусгадсан мэдээллийг нэгтгэн нийтэд ил тод болгох ёстой.

21. ТСААТ-ний мониторингийг ГШ 1-ийн дагуу хийх бөгөөд өртсөн нийгмийн бүлэг мэт гол сонирхргч этгээлүүлийн оролцоог шаардаж магадгүй.
22. ТСААТ-нд тусгасан зорилго, мөн энэ ГШ-ын зорилготой нийцэх хэлбэр маягаар тархан суурьшилтын сөрөг нөлөөг шийдвэрлэх нөхцөлд тархан суурьшилт дууссан гэж үзнэ.
23. Төслийн тархан суурьшилтын хэмжээнээс шалтгаалан ТСААТ-ний заалтууд биелэгдсэнийг тогтоохын тулд түүний гадны төгсгөлийн аудитыг хийлгэх нь үйлчлүүлэгчийн хувьд зохистой байж мэднэ. Төгсгөлийн аудитыг ТСААТ-ний бүх орох мэдээлэл, үүний дотор хөгжлийн аливаа санаачилга орж дууссаны дараа, гэхдээ үйлчлүүлэгчийн ЕСБХБ-д төлөх санхүүгийн үүрэг биелэгдэхээс өмнө хийвэл зохино. Аудит хийх цаг хугацаа нь үйлчлүүлэгчид төсөл дуусахаас өмнө аудитуудаас өгсөн зөвлөмжийн дагуу засч залруулах арга хэмжээг авах боломжийг олгоно. Төгсгөлийн аудитын дүнд үндэслэн ЕСБХБ ба үйлчлүүлэгч энэ ГШ-ын зорилтууд биелэгдсэн эсэхийг хамтран тогтооно. Ихэнхи тохиодолд төгсгөлийн аудитаар тогтоосон засч залруулах арга хэмжээний дуусгавар нь тархан суурьшилт, нөхөн олговор, аж амьдралын сэргээн босголт болон хөгжлийн ашиг тусын талаархи үйлчлүүлэгчийн хариуцлагыг төгсгөл руу нь аваачдаг юм.

Аж амьдралыг сэргээн босгох тогтолцоо

24. 7-р зүйлд тайлбарласнаар хүмүүсийн бие махбодын бусь харин эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг багтаасан хэлцэлцээр тохиролцооны тохиолдолд үйлчлүүлэгч өртсөн хүмүүс болон бүлэгт энэ ГШ-ын зорилгыг хангах нөхөн олговор болон бусад туслалцааг санал болгох горимыг боловсруулна. Энэ нь Аж амьдралыг сэргээн босгох тогтолцоо /ААСБТ/-ны хэлбэрийг авах ёстой.
25. ААСБТ нь өртсөн хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн нэр, эрхийг тогтоож, тэдгээр нь ил тод, тууштай ба шударга хэлбэр маягаар олгогдох явдлыг хангана. Үйлчлүүлэгч ААСБТ-нд нөхөн олговрыг тогтоох ба олгох горим журмыг баримтжуулах ёстой, үүгээр :
- ААСБТ –ны зорилгыг тусгах;
 - төслийн нөлөөг тайлбарлах, эдийн засгийн хувьд нүүлгэн шилжүүлэх бүх хүнийг илрүүлэх, өртсөн эд хөрөнгө эсхүл нөөц баялгийн бүртгэлийг явуулах;
 - нүүн шилжилтээс зайлсхийх боломжгүй байсан ба түүнийг аль болохоор багасгасныг тайлбарлах;
 - нөхөн олговортой холбоотой хуулийн орчныг тайлбарлах;
 - альтернатив хувилбар болон шийдвэр гаргах процесст тэдний оролцооны түвшингийн талаар өртсөн хүмүүстэй хийсэн зөвлөлдөөний процессыг ярьж өгөх;
 - нүүн шилжсэн хүмүүсийн бүх зэрэглэлд зориулсан өмчийн эрхийг тайлбарлах;

- өртсөн эд хөрөнгө, баялгийг үнэлэхэд хэрэглэсэн арга, тэдгээрт нэвтрэх боломж, нөхөн солих бүрэн өртгийг тайлбарлах, төлөх ёстой нөхөн олговрын хэмжээ, ханшийг тоочих;
 - нүүн шилжсэн хүмүүсийн аж амьдрал ба амьжиргааны стандартыг сайжруулах, эсхүл наад зах нь сэргээн босгох бусад арга хэмжээг тайлбарлах;
 - газар авалтын /эсхүл хязгаарлалтыг хэрэглэх/ хуваарь, нөхөн олговрын төлбөрийг тоймчилж өгөх;
 - өртсөн хүмүүс шударга бус гэж үзсэн үнэлгээг давж заалдах процессыг тайлбарлах,
 - ААСБТ-ны биелэлтийн төлөөх институциональ/зохион байгуулалтын харицлага болон гомдол заргыг залруулах горим журмыг тоймчлох;
 - мониторинг, үнэлгээ, тайлагналтын талаархи хэлцээ тохиролцооны нарийвчилсан зүйлсийг ил тод гаргах; ба
 - ААСБТ-ны биелэлтийн цаг хугацаа ба төсвийг нээлттэй болгох.
26. Үйлчлүүлэгч өртсөн хүмүүс нөхөн олговрын горим журмыг ойлгох, төслийн янз бүрийн үе шатанд юуг хүлээж болохыг мэдэх / өөрөөр хэлбэл, тэдэнд хэзээ санал тавих, хариулахад хир удаан хугацаа хэрэгтэй болох, гомдол заргын горим журам, хэрэв хэлэлцээ бүтэлгүйдвэл дагалдах хуулийн ажиллагаа/ явдлыг хангахын тулд ААСБТ -нд тусгасан мэдээллийг нэгтгэн нийтэд ил тод болгох ёстой.
27. Үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлгүүдэд тогтсон горим журамд үндэслэсэн хэлэлцэрт оролцох боломжийг олговол зохино.
28. Өртсөн хүмүүс энэ ГШ-ын шаардлагыг хангасан нөхөн олговрын саналыг няцаах тохиолдолд түүний үр дүнд хураан авалт болон бусад хуулийн горим журмын эхлэл тавигдсон бол үйлчлүүлэгч хариуцагч засгийн газрын байгууллагатай хамтран ажиллах боломжийг хайх бөгөөд уг байгууллагаас зөвшөөрбөл, тархан суурьшилтын төлөвлөлт, хэрэгжүүлэлт ба мониторинг-т идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ.
29. ААСБТ -нд тусгасан зорилго, мөн энэ ГШ-ын зорилготой нийцэх хэлбэр маягаар нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөг шийдвэрлэсэн нөхцөлд ААСБТ-г хэрэгжүүлж дууссан гэж үзнэ.

Шилжин байршсан хүмүүст зориулсан нөхөн олговор ба ашиг тус

30. Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийлэх боломжгүй бол үйлчлүүлэгч шилжин байршсан хүмүүс болон бүлгүүдэд эд хөрөнгөө алдсаны нөхөн олговрыг нөхөн солилтын бүрэн өртгөөр ¹⁷ олгох санал болон энэ ГШ-д тусгаснаар тэдэнд амьжиргааны стандарт болон аж амьдралын түвшинг дээшлүүлэхгүй гэхэд сэргээн босгоход туслах саналыг дэвшүүлнэ. Нөхөн олговрын стандарт ил тод бөгөөд төсөлтэй уялдаж байна. Шилжин байршсан хүмүүсийн аж амьдрал газарт үндэслэсэн, эсхүл газрыг хамтран эзэмшдэг бол үйлчлүүлэгч газарт үндэслэсэн нөхөн олговрыг боломжтой бол санал болгоно. Үйлчлүүлэгч шилжин байршсан хүмүүс болон нийгмийн бүлэгт төслөөс хөгжлийн зохих ашиг тус олох боломж олгох талаар хүч чармайлт гаргана.

¹⁷ Алдсан активын нөхөн олголтын ханшийг орулуулан солих бүхэл өртгөөр тооцоолох ёстой, тухайлбал активын зах зээлийн үнэ дээр хэлцлийн өртгийг нэмэх. Үнэлгээний энэ аргыг хэрэглэхдээ бүтэц, активын элэгдэл, хорогдлыг анхааралдаа авах ёсгүй. Амархан үнэлж чадахгүй эсхүл мөнгөөр нөхөн олгох блөмжгүй алдагдлын хувьд биет нөхөн олговор зохимжтой байж магадгүй. Гэхдээ энэ нөхөн олговрыг тэнцүү юм уу илүү үнэ цэнэтэй бараа, баялгаар соёлын зохимжтой хэв аргаар төлөх ёстой. Газар ба бүтцүүдийн хувьд орлуулан солих өртгийг дараахаар тодорхойлно:

- Хөдөө аж ахуйн газар – адил бүтээмжийн ашиглалттай эсхүл потенциалтай, өртсөн гарын ойролцоо баршилтай газрын зах зээлийн үнэ, дээр нь өртсөн газрынх шиг эсхүл илүү сайн түвшинд бэлтгэх зардал, тэгээд дээр нь бүртгэл ба шилжүүлэлтийн татвар мэт хэлцлийн өртгийг нэмнэ.
- Суурин бүс дэх газар – тэнцүү бүсийн болон ашиглалттай газрын зах зээлийн үнэ, адил эсхүл сайжруулсан дэд бүтэц ба үйлчилгээтэй байршил нь болвол өртсөн гэзрын ойролцоо дээр нь бүртгэл ба шилжүүлэлтийн татвар мэт хэлцлийн өртгийг нэмнэ.
- Байшин ба бусад бүтэц - өртсөн бүтцийнх шиг бүсэд орших, чанарын хувьд ижил эсхүл илүү сайн чанарын шинэ бүтцийг худалдан авах эсхүл барих, дээр нь бүртгэл ба шилжүүлэлтийн татвар мэт хэлцлийн өртгийг нэмнэ.

Шилжин суурьшилт

31. Шилжин байршсан хүмүүсийг дараах байдлаар ангилж болно: (i) газар эзэмших албан ёсны хуулийн эрхтэй хүн /үүнд үндэсний хуулиар хүлээн зөвшөөрөгддөг заншлын болон уламжлалт эрх орно;/; (ii) хүн амын тооллогын үеэр газар эзэмших албан ёсны хуулийн эрхгүй хүн, гэхдээ үндэсний хуулиар¹⁸ хүлээн зөвшөөрөгдсөн эсхүл хүлээн зөвшөөрөгдөх газрын талаар нэхэмжлэхтэй хүн, (iii) эзэмшиж байгаа газрын¹⁹ талаар хүлээн зөвшөөрөгдөх хуулийн эрх эсхүл нэхэмжлэхгүй хүн. Хүн амын тооллого шилжин суурьшсан хүний статусыг тогтооно. Төслийн байрлал руу таслан хаалтын өдрийн дараа /14-р зүйлийг үзнэ үү/ шилжиж байгаа скваттерчууд болон саяхан ирсэн эдийн засгийн цагаачид зэрэг этгээдүүд нөхөн олговор хүртэх эсхүл өөр ямар нэгэн туслалцаа авах эрхгүй.
32. (i) and (ii) –р зүйлд хамрагдах этгээдүүд алдсан газрын төлөөх нөхөн олговор болон 34 ба 35-р зүйлүүдийн дагуу бусад тусламж авдаг. 31 (iii)-р зүйлд хамрагдах этгээдүүд газрын нөхөн олговор авах эрхгүй, гэвч тэд эзэмшиж болон байрлаж байгаа бүтэц болон газар дээр хийсэн аливаа бусад сайжруулалтын төлөөх нөхөн олговрыг орлуулан солих бүрэн өртгийн хэмжээгээр авах ёстой. Үүнэс гадна тэдэнд шилжин суурьших тусламжийг бололцоотой альтернатив талбай дээр амьжиргааныхаа стандартыг сэргээн босгоход хүрэлцээтэй хэмжээгээр санал болгох ёстой. Шилжин суурьших тусламжийн хувилбаруудыг шилжин байршсан хүмүүстэй хийх зөвлөлдөөнөөр гаргаж ирэх ёстой хийгээд тэдний тэргүүлэх зорилго болон сонирхлыг тусгах хэрэгтэй. Эдгээр заалт төслийн талбайг бүхэлд нь эсхүл хэсгийг нь таслан хаах өдрийн өмнө эзэмшиж байсан хүмүүст хамаатай.
33. Төслийн зориулалтаар газар авах явдал хүмүүсийн бодит нүүлгэн шилжүүлэлт, мөн эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хүргэж мэднэ. Үүний үр дүнд биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн аль алинд тавих шаардлага урган гарч болно.

Бодит нүүлгэн шилжүүлэлт

34. Хэрэв төслийн бүсэд амьдарч байгаа хүмүүс өөр тийшээ нүүх шаардлагатай бол үйлчлүүлэгч: (i) нүүн шилжих хүмүүст нүүн суурьшилтын боломжит хувилбаруудаас сонгол хийхийг санал болгох, үүнд тохиромжтой сэлгээний байр эсхүл зохимжтой бол мөнгөн нөхөн олговор олгох, (ii) нүүн шилжих хүмүүсийн бүлгийн хэрэгцээнд тохирсон шилжин нүүдлийн тусламжийг олгох, ингэхдээ онцгой анхаарлыг ядуу болон эмзэг хүмүүсийн хэрэгцээнд хандуулна. Альтернатив байр болон мөнгөн нөхөн олговрыг нүүдэл суудлын өмнө хангана. Шинээр барисан нүүлгэн суурьшуулах цэгүүд нүүж шилжсэн хүмүүст амьдрах сайжруулсан нөхцлийг санал болгоно.
35. 31 (i) or (ii)-р зүйлд хамаарах биеэрээ нүүж шилжсэн хүмүүсийн хувьд үйлчлүүлэгч ижил эсхүл илүү өндөр үнэтэй, адил эсхүл илүү чанартай, сайн байршилтай орлон солих эд хөрөнгийг авах эсхүл зохимжтой бол орлуулан солих бүрэн үнэтэй тэнцэх мөнгөн нөхөн олговрыг авах сонголтыг санал болгоно²⁰.

¹⁸ Ийм нэхэмжлэх идэвхгүй эзэмшлээс, заншмал эсхүл уламжлалт хуулиас үүсч болно.

¹⁹ Албан ёсны хуулийн зөвшөөрөлгүйгээр газрыг нэхэмжлэдэг, эсхүл газрыг ашигладаг уугуул хүмүүс, хэвшсэн ашиглагчид, малчин, дотооддоо шилжин суурьшсан этгээдүүд, скваттерчууд болон хүний өмчийг эзэмшин түүнээс орох ашгийг авах, өртсөн газарт болон бусад нөөц баялагт хэвшсэн, үэдэсний хуулиар хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрөгдөхгүй, нэхэмжлэх тавьдаг бусад хүмүүс.

²⁰ Алддагдсан активд бэлэн мөнгөөр нөхөн олговрыг олгох нь дараах тохиолдолд зохимжтой байна: (а) аж амьдрал нь газар дээр үндэслээгүй; (b) дээр үндэслэгдсэн боловч төсөлд авсан газар нь өртсөн активуудын өчүүхэн хэсэг болох бөгөөд үлдсэн газар эдийн засгийн чадвартай; (с) газар, орон сууц, хөдөлмөрийн идэвхтэй зах зээл байдаг бөгөөд нүүн шилжсэн хүмүүс тэдгээрийг ашигладаг хийгээд тэнд газар, орон сууцны хангалттай нийлүүлэлт байдаг. Мөнгөн нөхөн олговрын түвшин нь алдагдсан газар болон бусад активыг орон нутгийн захын орлуулан нөхөх бүрэн өртөгт хүрэлцэхүйц байх ёстой.

36. 31 (iii)-р зүйлд хамаарах биерээ нүүж шилжсэн хүмүүсийн хувьд үйлчлүүлэгч өмчлөлийн аюулгүй байдал хангагдсан тохиромжтой орон хувилбаруудаас сонголт хийж, хуулийн дагуу нүүн орж, албадан хөөх эрсдэлгүй байхыг санал болгоно.

- Хэрэв нүүн шилжсэн хүмүүс бүтэц байгууламжуудыг өмчлөн байрладаг болох үйлчлүүлэгч газраас бусад, орон сууц болон газар дээр хийсэн бусад сайжруулалтыг алдсаны нөхөн олговрыг орлуулан солих бүрэн өртгийн хэмжээгээр төлнө, ингэхдээ эдгээр хүмүүс санал өгөх эрхтэйгээр төслийн бүсийг таслан хаах өдрөөс өмнө эзэгнэж байсан байх ёстой.
- Хэрэв 20-р тайлбарт тусгасан нөхцлүүд оршиж байгааг ЕСБХБ-д зохистой түвшинд нотолж чадвал биет нөхөн олговрыг зохимжтой бол мөнгөн нөхөн олговрын оронд олгох санал дэвшүүлнэ. Энэ нь тухайн улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн заншмал болон уламжлалт эрхтэй хүмүүст, таслан хаах өдрийн өмнө газар эзэмших албан ёсны хуулийн эрхгүй байсан боловч тэрхүү газар ба активын талаар нэхэмлэхтэй байсан, тухайлбал идэвхгүй эзэмшлийн²¹ замаар, нэхэмжлэгчдэд хамаатай бөгөөд 31-р зүйлд дурдсан мэргэшил чадвараас шалтгаалан байрлаж байгаа газрын хувьд хүлээн зөвшөөрөгдөх хуулийн эрх эсхүл нэхэмжлэх байхгүй хүмүүст мөн хамаатай.
- Тийм нүүн шилжсэн хүмүүстэй хийсэн зөвлөлдөөнийг үндэслэн үйлчлүүлэгч тэдэнд нүүн шилжих туслалцааг боломжийн альтернатив талбайд²² өөрсдийн амьжиргааны стандартыг сэргээн босход хангалттай хэмжээгээр үзүүлнэ.

37. Үйлчлүүлэгч таслан хаах өдрөөс хойш төслийн талбай дээр тэнүүчлэх хүмүүст нөхөн олговор олгох, туслах шаардлагагүй.

38. Нутгийн уугуул хүмүүсийн бүлэг тэдний хамтран эзэмшдэг уламжлалт ба заншмал газраас биеэрээ нүүлгэн шилжүүлэгдэхэд хүрвэл үйлчлүүлэгч энэ ГШ болон ГШ 7-ийн холбогдох шаардлагыг хангана.

Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт

39. Хэрэв 7-р зүйлд заасан төрлийн хэлцэл, тухайлбал хүний өөрийн ажил эрхлэлт эсхүл үр дүнтэй активт хүрэх, очих боломжийг хаах эсхүл хязгарлах замаар түүний орлого эсхүл аж амьдралыг алдахад хүргэж байвал өртсөн хүн биеэр шилжин нүүсэн эсэхийг үл харгалзан, үйлчлүүлэгч:

- Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүнд активаа алдсан эсхүл активт хүрч очих боломжийг хаасны төлөө нөхөн олговрыг, орлуулан солих бүрэн өртгийн хэмжээгээр яаралтай олгох. Хэрэв нөхөн олговрыг хариуцсан засгийн газрын байгууллага төлөх бол үйлчлүүлэгч төлбөрийг яаравчлуулахын тулд тэрхүү байгууллагатай хамтран ажиллах ёстой. Хэрэв засгийн газрын бодлого эсхүл практикийн улмаас төлбөрийг яаралтай хийж чадахгүй бол үйлчлүүлэгч нүүлгэн суурьшилтын туслалцааны хувилбаруудыг судалж, нүүн шилжсэн хүмүүст орлогоо түр хугацаагаар алдсаны тусламж үзүүлнэ.
- Газар эзэмшил няаж ахуйн бүтцүүдийг хөндөж байгаа нөхцөлд өртсөн бизнесийн эзэнд дараахи нөхөн олговрыг төлөх, үүнд (i) аж ахуйн ажиллагааг хаа нэгэн

²¹ Тодорхой нөхцөлтэйгээр хуулиар тогтоосон хугацаанд хөрөнгийг эзэмших замаар бодит хөрөнгийн эрхийг эзэмших арга

²² Суурин газарт албан бус суугчдыг шилжүүлэн байршуулах нь олонтаа эерэг, сөрөг талтай. Жишээлбэл, шилжин байршсан гэр бүлүүд эзэмшлийн хамгаалалттай болж болно, гэвч тэд байршлын давуу талаа алдаж мэднэ.

- Ижил эсхүл илүү үнэтэй орлуулах эд хөрөнгө /өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн ба арилжаа аж ахуйн талбай/-ийг гаргаж өгөх, эсхүл зохимжтой бол мөнгөн нөхөн олговрыг орлуулан солих бүрэн өртгийн хэмжээгээр үндэсний хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эсхүл хүлээн зөвшөөрөгдөх хуулийн эрх, эсхүл нэхэмжлэл бүхий хүмүүст өгөх;
 - Нийгмийн бүлгийн хамтарч эзэмшдэг баялгийн²³ алдагдлыг нөхөх тусламжийг олгох. Энэ нь нийгмийн бүлэг нэвтрэн орох боломжтой үлдсэн баялгийн үр шимийг нэмэгдүүлэх санаачилга, нэвтрэн орох боломжгүй болсны нөхөн олговрыг биет эсхүл мөнгөн хэлбэрээр олгох, эсхүл алдсан баялгийн альтернатив эх үүсвэрт нэвтрэн орох боломжоор хангах зэрэг хэлбэртэй байж болно,
 - Хуулиар хүлээн зөвшөөрөгдөх газрын талаар нэхэмжлэхгүй, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүст /31 (iii) -р зүйлд алдсан активыг үзнэ үү/ газраас бусад (үр тариа, услалтын дэд бүтэц болон газар дээр хийсэн бусад сайжруулалт г.м.)/ нөхөн олговрыг орлуулан солих бүрэн өртгийн хэмжээгээр олгох. Үйлчлүүлэгч таслан хаах өдрөөс хойш төслийн талбай дээр ашиг хонжоо олохын тулд суурьшсан хүмүүст нөхөн олговор олгох, туслах шаардлагагүй.
 - Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн, аж амьдрал болон орлогын түвшинд сөргөөр нөлөөлөсөн хүмүүст тэдний орлого олох чадавхи, үйлдвэрлэлийн түвшин, амьжиргааны стандартыг дээшлүүлэх, эсхүл наад зах нь сэргээхэд чиглэсэн нэмэлт тусламж (өөрөөр хэлбэл, зээлийн хэргсэл, сургалт эсхүл ажлын бололцоо) болон тусламжийг үзүүлэх. Төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэлтийн улмаас бизнес доройтох, эсхүл хаагдахад хүрэх тохиолдолд бизнес эрхлэгч болон түүний ажилтнууд тийм туслалцаа авах эрхтэй.
 - Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүсийн орлого олох чадавхи, үйлдвэрлэлийн түвшин ба амьжиргааны стандартыг сэргээхэд шаардлагатай цаг хугацаанд үндэслэн тэдэнд шилжилтийн тусламжийг олгох.;
40. Төсөлтэй холбоотой газар авалтын улмаас нутгийн уугуул хүмүүсийн бүлэг эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн /гэхдээ шилжин суурьшаагүй/ нөхцөлд үйлчлүүлэгч энэ ГШ, мөн ГШ 7-ийн шаардлагыг хангах ёстой.

Нийтийн тохь тухын алдагдал²⁴

41. Төсөл нийтийн тохь тухыг алдагдахад хүргэвэл үйлчлүүлэгч ГШ 10-ын дагуу утга учир бүхий зөвлөлдөөнийг орон нутгийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй боломжтой бол хийж, зохимжтой альтернативуудыг илрүүлж тохирох ёстой.

Засгийн газрын удирдлагын дор хийгдэх нүүлгэн суртшуулалтын үед хувийн секторын хүлээх хариуцлага

42. Газрыг эзэмшилд авах болон нүүлгэн шилжүүлэлт нь хүлээн авагч засгийн газрын хариуцлага байх тохиолдол байж болно. Ийм тохиолдолд үйлчлүүлэгч энэ ГШ-ын

зорилгуудтай нийцэх үр дүнд хүрэхээр засгийн газрын хариуцах байгуулагатай байгууллагаас зөвшөөрсөн цар хэмжээнд хамтран ажиллана. Үүнээс гадна засгийн газрын чадавхи хязгаардмал тохиолдолд үйлчлүүлэгч нүүлгэн шилжилтийн төлөвлөлт, хэрэгжилт ба мониторингт идэвхтэй үүрэгтэй байна. Үйлчлүүлэгч төлөвлөгөө /эсхүл бүдүүвч/ боловсруулах бөгөөд тэр нь засгийн газрын хариуцах байгууллагаас бэлтгэсэн баримтуудын хамт энэ ГШ-ын шаардлагыг хангах ёстой. Үйлчлүүлэгч өөрийн төлөвлөгөөндөө дараахийг оруулах хэрэгтэй байж мэднэ: (i) холбогдох хууль журмын дагуу нүүн шилжсэн хүмүүсийн эрхийн тодорхойлолт; (ii) тийм эрх болон энэ ГШ-ын шаардлагын хоорондын аливаа зай завсрыг холбох санал болгож буй арга хэмжээ; ба (iii) засгийн газрын байгууллага болон/эсхүл үйлчлүүлэгчийн санхүүгийн болон хэрэгжүүлэх хариуцлага.

²³ Үүний жишээнд бэлчээр, зүсмэл материалын бус ой модны нөөц /тухайлбал, эм зүйн ургамал, барилгын болон гар урлалын материал/, зүсмэл материалын ойн эдэлбэр газар ба түлшний мод эсхүл загасчлалын газар орно.

²⁴ Нийтийн тохь тухын тодорхойлолтыг тайлбар толиноос харна уу. Соёлын өвийн алдагдлыг ГШ 8-д тусгасан.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 6:

Биологийн олон төрөлхт байдлыг хадгалах ба амьд байгалийн нөөц баялаг

Танилцуулга:

1. ЕСБХБ хөрөнгө оруулалт хийж байгаа төсөлтэй холбогдуулан биологийн олон төрөлхт байдлыг хамгаалах, хадгалах хэрэгцээг хүлээн зөвшөөрч байна. “Биологийн олон төрөлхт байдал” хэмээх нэр томъёог Биологийн олон төрөлхт байдлын тухай Конвенци /БОТБК/-д дараахаар тодорхойлсон байна “*Бүх эх үүсвэрээс гаралтай амьд организмын хоорондын ялгарал, даширамд үүнд газрын, далайн болон бусад усны экосистем болон тэдний хэсэг болох экологийн комплексууд орно, энэ нь зүйлүдийн дундах ялгарал, зүйл болон экосистемийн хоорондын ялгарлыг бгтаана*”. Банк биологийн олон төрөлхт байдлыг хадгалах, тогтвортой ашиглах асуудалд болгоомжтой хандах, түүнд учирч болох нөлөөний менежментийг Рио-гийн тунхаглал болон БОТБК-ийн дагуу явуулахыг дэмждэг.
2. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхдээ Банк холбогдох олон улсын хууль, конвенци болон ЕХ-ны захирамжийг удирдамж болгодог бөгөөд тэдний хэрэгжилтийг дэмждэг (тэдгээрийн жишээг доорхи тайлбарт татсан болно)¹.

Зорилтууд:

3. Энэ Гүйцэтгэлийн шаардлага /ГШ/-ын зорилтууд дараахид оршино. Үүнд:
 - Биологийн олон төрөлхт байдлыг хамгаалах, хадгалах;
 - Биологийн олон төрөл байдалд үзүүлэх нөлөөнөөс зайлсхийх, багасгах, саармагжуулах, бололцоотой бол биологийн олон төрөлхт байдал дээр цэвэр алдагдал эсхүл цэвэр ашигтай байхгүй зорилгод хүрэх үүднээс үлдэх үлэмж нөлөөг балансжуулах;

¹ Холбогдох конвенци ба захирамжийн жишээ:

- Биологийн олон төрөл зүйлийн тухай Конвенци ба түүний протоколууд
- Олон улсын ач холбогдолтой намагжсан газар, ялангуяа Уотерфаулын орчны тухай Конвенци
- Хил хязгаар давсан байгаль орчны нөлөөний үнэлгээний тухай Конвенци (Еспу Конвенци)
- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлсийг хадгалах Конвенци
- Хар далайг бохирдлоос хамгаалах тухай Конвенци
- Зөвлөлийн захирамж 92/43/ЕЕС 1992 оны 5-р сар – Байгалийн орчин болон Зэрлэг амьтны аймаг ба ургамлын аймгийг хадгалах тухай, шинэчилсэн
- Зөвлөлийн захирамж 79/409/ЕЕС 1979 оны 4-р сар –Шувууг хадгалах тухай
- Зөвлөлийн захирамж 2004/35/ЕС April 2004 оны 4-р сар - Байгаль орчны хариуцлагын тухай
- Зөвлөлийн захирамж 85/337/ЕЕС 27 June 1985 оны 6-р сарын 27, Захирамж 97/№№/ЕС 1997 оны 3-р сарын 3-ны Байгаль орчны нөлөөний тухай захирамжаар шинэчлэгдсэн.
- Зөвлөлийн захирамж 2001/42/ЕС 2001 оны 6-р сар – Байгаль орчны стратегийн үнэлгээний тухай

- Тогтвортой менежмент ба байгалийн баялгийн ашиглалтыг дэмжих;
- Нутгийн уугуул хүмүүс болон орон нутгийн нийгмийн бүлгүүд шийдвэр гаргах процесст зохих ёсоор оролцох явдлыг хангах;
- Төслийн хөгжил болон генетик нөөцийг ашигласнаас гарах ашиг тусыг шударга, тэнцүү хуваах явдлыг хангах;
- Биологийн олон төрөлт байдлын бизнесийн эрсдэл, мөн боломж хэмээн хамгийн сайн практик менежментийн замаар компанийн ажиллах лицензи, нэр хүнд ба өрсөлдөх давуу талыг бэхжүүлэх,
- Байгалийн орчин тойронг тогтвортой бус хэлбэрээр ашиглахын оронд альтернатив аж амьдралыг санал болгох биологийн олон төрөлхт байдлын төлөөх бизнесийг дэмжин урамшуулах.

Хэрэглээний цар хүрээ

4. Энэ бүх төрлийн орчинд байгаа төслүүдэд хамаатай ингэхдээ тэднийг урьд нь эвдэлж сүйтгэсэн эсэх, эсхүл тэд хамгаалалттай байсан эсэх, эсхүл менежментийн төлөвлөгөөний хэсэг болж байгаа эсэхийг үл харгалзана.
5. Энэ ГШ-ын хэрэглээг Банк байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессын явцад тогтоодог. Энэ ГШ-тай нийцэхийн тулд хангах ёстой генерик шаардлагыг Банк тоймлодог байхад үйлчлүүлэгч өөрийн байгаль орчин болон нийгмийн арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө /БОНАХЕТ/ болон менежментийн системийн хэсэг болгон нийцэлтийг хангах үүднээс авах тусгай арга хэмжээний багцыг Банкаар хянуулахаар санал болгох ажлыг хариуцна. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагыг ГШ 1 ба ГШ 10-т тоймлон тусгасан. Банк бие даасан биологийн олон төрөлхт байдлын мэргэжилтнийг зохистой ажиллагаанд туслуулахаар хөлсөлж болно.

Шаардлага

Асуудал болон нөлөөний үнэлгээ

6. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессоор үйлчлүүлэгч төслөөс шалтгаалан үүсч болох биологийн олон төрөлхт байдалд тусах боломжит нөлөөг илрүүлж тодорхойлно. Зохистой ажиллагааны хэмжээ нь эрсдэл ба нөлөөг болгоомжтой хандлагатай уялдуулан бүрэн тодорхойлох, ингэхдээ холбогдох хувь эзэмшигчдийн санаа зовоосон зүйлсийг тусгана. Зохих ёсоор туршлагажсан болон мэргэшсэн экспертүүдыг энэ процесст оруулах хэрэгцээтэй байж мэднэ. Биологийн олон төрөлт байдлын асуудал анхаарлын төвд байх нөлөөний үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгч биологийн олон төрөлхт байдлыг нөлөөний үнэлгээнд² нэгтгэх хамгийн сайн практик удирдамжийг баримтлах ёстой. Мөн үнэлгээ цаг уурын өөрчлөлт ба дасч амьдрах асуудлыг анхааралдаа авах хэрэгтэй. 13, 14 ба 15-р зүйлийн шаардлага тавигдвал үйлчлүүлэгч үнэлгээг хийхэд туслуулахаар мэргэжилтэй хийгэд туршлагатай гадны экспертыг авч үлдээнэ.
7. Зохистой ажиллагаа нь болзошгүй нөлөөний шинж чанар, хэмжээ, үргэлжлэх хугацаа болон болзошгүй нөлөөний эрчийг асуудлыг багтааж, нөлөө үүсэх боломжийг үнэлж, тэдгээр нөлөөний ноцтой байдлыг тодорхойлох ёстой.
8. Үйлчлүүлэгч болзошгүй сөрөг нөлөөнөөс зайлхийх, багасгах, саармагжуулах арга хэмжээг тодорхойлох хэрэгтэй бөгөөд зохимжтой бол хийгээд тэр эцсийн арга бол биологийн олон төрөлхт байдлын балансжилт, өртсөн биологийн олон төрөл зүйл

² Биологийн олон төрөлхт байлыг нөлөөнийг үнэлгээнд уялдуулах оруулах практик шилдэг удирдамж:

- Биологийн олон төрөлхт байлыг байгаль орчны үнэлгээнд оруулах тухай сайн дурын удирдамж /2006 оны НҮБ-ын Талуудын 8-р Зөвлөгөөний БОТБ-ын тухай Шийдвэр VIII/28-д байгаа/
- Биологийн олон төрөлхт байдал Нөлөөний Үнэлгээнд (IAIA-Нөлөөллийн Үнэлгээний Олон Улсын Ассоциаци Тусгай хэвлэлийн сери № 3)
- *Эрчим хүч ба биологийн олон төрөлхт байдлын янз бүрийн бүтээгдэхүүн*

| Биологийн олон төрөлхт зүйл саармагжуулах шат дараалал | |
|---|---|
| Арга хэмжээ | Хариу |
| 1. Зайлсхийх | Үйлчлүүлэгч биологийн олон төрөлхт байдалд үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх арга замыг хайна. |
| 2. Багасгах | Биологийн олон төрөлхт байдалд үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх боломжгүй бол үйлчлүүлэгч биологийн олон төрөлхт байдалд үзүүлэх нөлөөг багасгах үүднээс төслийг шинэчлэх арга замыг хайж олох ёстой |
| 3. Саармагжуулах | Биологийн олон төрөлхт байдалд үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх эсхүл багасгах боломжгүй бол үйлчлүүлэгч тэрхүү нөлөөг саармагжуулах арга замыг хайж олох ёстой. |
| 4. Балансжуулах | Хэрэв тэдгээр нөлөөнөөс зайлсхийх, багасгах, саармагжуулах оролдлого хийсэн боловч биологийн олон төрөлхт байдалд ноцтой үлдэгдэл нөлөө хадгалагдвал үйлчлүүлэгч тэдгээр нөлөөг баланслуулах арга хэмжээ, төслийг хайж олно. Баланслуулах аливаа төслийг бүтэцжүүлэн ЕСБХБ-тай тохирно. |

Орчныг хамгаалах ба хадгалах

Ерөнхий зүйл

9. Бүх орчин (сайжруулсан, байгалийн эсхүл туйлын чухал орчин эсэхийг үл харгалзан) төрөл зүйлсийн ялгарал, олшрол, экосистем болон эдийн засгийн үнэлгээний хувьд ялгавартай амьд организмын харилцан хэцүү, үл ойлгогдох уялдаа холбоог дэмждэг юм. Иймээс үйлчлүүлэгчээс явуулах зохистой ажиллагаа нь төсөлд өртөж болзошгүй зөвхөн байгалийн хөндөгдөөгүй орчны, үүнд мөн хадгалалтын туйлын чухал үнэ бүхий орчны тодорхойлолтыг багтаахаас гадна хүний үйл ажиллагааны улмаас эвдэрч сүйдсэн орчин болон усан сан, бэлчээр мэтийн шинэ, хүн хийсэн орчныг багтаана. Ийм зохистой ажиллагаа санал болгож байгаа хөгжилд хэрэглэх аливаа саармагжуулах арга хэмжээний үнэлгээг багтаах ёстой.
10. Сааруулах арга хэмжээ нь мэдрэмгий талбайгаас зайлсхийх, мэдрэмгий үед /өөрөөр хэлбэл, мал амьтан төллөх үе/ нураан сүйтгэх ажлаас татгалзах, зүйлсийг түр зуурын эсхүл байнгын альтернатив талбайд нүүлгэн суурьшуулах, төслийн дараа талбайг нөхөн сэргээх, дахин колоничлах ба үлдэгдэл нөлөөг /балансжуулахын тулд/ адил амьдрах орчинг байгуулах. Биологийн олон төрөлхт зүйлсийг алдагдалд шууд өртсөн хүмүүс болон нийгмийн бүлгүүдэд тэнцүү хэмжээгээр ба зохистой нийгэм-соёлын хэлбэрээр нөхөн олговор олгох ёстой.

Сайжруулсан орчин

11. Сайжруулсан орчин гэдэг нь байгалийн орчинд илт өөрчлөлт оруулсан, олонхи тохиолдолд ургамал болон ан амьтны харийн төрөл зүйлсийг нэвтрүүлсэн орчин юм, тухайлбал хөдөө аж ахуйн бүс нутаг. Сайжруулсан эсхүл шинээр байгуулсан орчин нөлөөлөгдөхөөр байвал үйлчлүүлэгч орчин цаашид муудах эсхүл орчин хувирах явдлыг багасгах зорилго тавих ёстой. Хэрэв хадгалах үндэслэлэр гавъяаны цол олгож, тэр нь төслийн шинж чанар, цар хүрээнээс шалтгаалдаг бол үйлчлүүлэгч орчинг сайжруулах, биологийн олон төрөлхт байдлыг хадгалж хамгаалах боломжийг хайж олох, эсхүл тухайн бүсэд тогтвортой ургац хураалт/менежментийг дэмжин хөхүүлэх ёстой. Энэ нь тэжээл тарих, зөгийг үржүүлэх, шувуу ажиглах гэх мэтийг багтааж болно.

Байгалийн орчин

12. Байгалийн орчин гэдэг нь газар ба усны бүс нутаг бөгөөд тэнд биологийн бүлгүүд голдуу уугуул ургамал ба амьтны төрлөөс бүрддэг хийгээд хүний үйл ажиллагаа бүс нутгийн анхдагч экологийн функцийг мэдэгдэхүйц өөрчилж чадаагүй байдаг. Байгалийн орчны бүс нутагт орчны дарахид тулсан сүрхий эвдрэл хувирал байх ёсгүй: (i) экологийн нэгтгэл болон экосистемийн ажиллагаа аюулд орох, эсхүл (ii) орчин амьдрах чадвартай өөрийн уугуул төрөл зүйлсийг цаашид дэмжиж чадахгүй болтлоо хоосрох, хэрэв:
- Техникийн болон эдийн засгийн хувьд боломжит, үндэслэлтэй альтернативууд байхгүй бол;
 - Төслийн нийт ашиг тус өртгөөс давах, үүнд байгаль орчин ба биологийн олон төрөлхт байдалд оруулна;
 - Тухайн орчинд, зохимжтой бол хадгалалтын илүү үнэтэй орчинд цэвэр алдагдалгүй, чадвал биологийн олон төрөлхт байдлын үнэд цэвэр нэмэр авчрах явдлыг хангах үүднээс холбогдох саармагжуулах арга хэмжээг авбал зохино.

Туйлын чухал орчин

13. Байгалийн эсхүл сайжруулсан гэдгээс үл хамааран зарим орчныг туйлын чухал гэж дараахийн улмаас тооцож болно. Үүнд: (i) түүний биологийн олон төрөлхт байдлын өндөр үнэ, (ii) ховордсон эсхүл маш ноцтой ховордсон зүйлсийн амьд үлдэхэд түүний ач холбогдол, (iii) тухайн орон нутгийн эсхүл газар зүйн хувьд хязгаардмал зүйлс, дэд зүйлсийн хувьд түүний ач холбогдол, (iv) нүүдлийн зүйлсийн хувьд түүний ач холбогдол, (v) гол эволюцийн процессудтай холбогддог зүйлсийн цугларалтыг дэмжихэд түүний гүйцэтгэх үүрэг, роль, (vi) орон нутгийн нийгмийн бүлгүүдэд чухал нийгмийн, эдийн засгийн, соёлын ач холбогдолтой биологийн олон төрөлхт байдлыг дэмжихэд түүний гүйцэтгэх үүрэг, роль, (vii) бүхэл экосистемд амьдралын чухал зүйлсийн хувьд түүний ач холбогдол (үндсэн зүйлс/).
14. Туйлын чухал орчныг хувиргах юм уу сүйтгэж болохгүй. Тиймээс туйлын чухал орчны бүс нутагт дараах нөхцлийг хангаагүй бол үйлчлүүлэгч ямар нэгэн төслийн ажиллагаа явуулахгүй:
- Олон улсын үүрэг эсвэл дотоодын хуульд шаардсан аливаа зохистой процессын нөхцлийг биелүүлэх нь хүлээн авагч улс төслийн ажиллагааг туйлын чухал орчинд эсхүл ойролцоо газарт явуулах зөвшөөрөл олгохын заавал урьдчилгаа болно³.
 - 13-р зүйлд заасан арга замаар амьдарч ажиллаж чадвараа алдаж мэдэх туйлын чухал орчинд хэмжих боломжтой сөрөг нөлөө эсвэл түүнтэй адилтгах юм байдаггүй.

- Болгоомжтой хандлагыг удирдлага болгон авч үзэхэд төсөл нь ховордсон ба нэн ховордсон зүйлсийн тоог цөөрөхөд хүргэнэ, мөн тухайн орчны талбайг бөх голтой, төлөөлөл бүхий хүлээн авагч экосистемийн амьдрах чадвар аюулд ортол багасгана гэж үзэх үндэслэл байхгүй.
- Дээрхийг үл тооцон, бусад бүх нөлөөг сааруулалтын шат дарааллын дагуу сааруулах болно.

³ Тухайлбал, улс орнууд түүнд үнэмшилтэй альтернатив байхгүйэлхү уг төсөл улсын үндэсний ашиг сонирхолд нийцэж байгааг харуулж болно.

Хамгаалалттай ба зориулалттай талбай

15. Засгийн газрын байгууллага талбайг янз бүрийн зорилгоор хамгаалалттай гэж зориулж болно, үүнд олон улсын конвенцийн дагуу улсын үүргийг биелүүлэх явдал орж болно. Тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомж хамгаалалттай талбайд болон орчин тойрны газар хөгжлийн ажиллагаа явуулахыг зөвшөөрч болно. Дээрхи 14-р зүйлийн холбогдох шаардлагаас гадна үйлчлүүлэгч:
- ГШ 10-ын дагуу хагаалалттай талбайн спонсор ба менежер, орон нутгийн нийгмийн бүлэг болон бусад гол сонирхогч этгээдүүдтэй санал болгож байгаа төслийн талаар зөвлөлдөх;
 - Тийм талбайд санал болгож байгаа аливаа хөгжлийн төсөл хуулиар зөвшөөрөгдсөн, тэрхүү зөвшөөрлийг авахад хүргэх зохистой процессыг хүлээн авагч орон биелүүлсэн, хэрэв хамаатай бол үйлчлүүлэгч болон хөгжлийн төсөл нь саармагжуулалтын шат дарааллыг (зайлхийх, багасгах, саармагжуулах, балансжуулах) зохих ёсоор баримталж байгааг харуулах;
 - Зохимжтой бол хамгаалалттай талбайн хадгалалтын зорилтыг урамшуулан дэмжих, түүнийг хангахад чиглэсэн нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Харийн түрэмгий зүйлс

16. Тохиолдлоор эсхүл санаатайгаар харийн зүйлсийг уугуул орчинд алдах, эсвэл тавих нь биологийн олон төрөлхт байдалд үлэмж сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.
- Үйлчлүүлэгч санаатайгаар харийн эсвэл орон нутгийн бус зүйлсийг тэднийг өмнө нь олж байгаагүй талбайд тавих ёсгүй, хэрэв уг нэвтрүүлэлтийг удирдаж байгаа зохицуулалтын бүтцээс өгсөн зааврын н дагуу хийгдээгүй тохиолдолд. Ямар ч нөхцөл байдалд түрэмгий нь мэдэгддэг зүйлсийг шинэ байгаль орчинд нэвтрүүлэх ёсгүй.
 - Зохистой чармайлт/ажиллагааны үеэр үйлчлүүлэгч харийн зүйлсийн тохиолдлын дамжилт ба тавилтын боломжийг үнэлж /өөрөөр хэлбэл, эрсдлийн шинжилгээний замаар/, тэднийг чөлөөлөх боломжийг, хэрэв байвал, аль болохоор багасгах арга хэмжээг тодорхойлно.
 - Бараа ба үйлчилгээний олон улсын усан онгоцны тэвэрлэлтийн хувьд Банк *Усан онгоцны усан тохируулагч дайвар болон тундасын хяналт ба менежментийн тухай олон улсын Конвенцийг* удирдлага болгодог. Үйлчлүүлэгч дээрхийн хүрээнд боловсруулсан үүргүүдийг биелүүлэх ёстой.

Генетикаар сайжруулсан организм (ГСО)

17. ГСО-г байгаль орчинд санаатайгаар чөлөөлөн тавих (ЕХ Захирамж 2001/18/ЕС), ГСО-г агуулсан эсхүл ГСО-аас бүрдсэн хүнс, тэжээллэг бүтээгдэхүүнийг зах зээл дээр гаргах (ЕХ Захирамж 1829/2003), ГСО-ын экспорт эсвэл ГСО-г тохиолдлоор

Тогтвортой менежмент ба амьд баялгийн ашиглалт

18. Үйлчлүүлэгч амьд баялгийн менежментийг тогтвортой арга хэлбэрээр явуулна. Амьд баялгийн ашиглалтыг багтаасан төслийн санхүүжилтийг хайсан үйлчлүүлэгч баялгийн ашиглалтын тогтвортой байдалд үнэлгээ хийх зохистой ажиллагаа явуулах хийгээд дараах зарчмыг анхааралдаа авна:
- Аливаа баялгийн ашиглалтыг экосистемийн дотор түүний гүйцэтгэх үүргийн үүднээс авч үзнэ. Тухайлбал, ой мод огтлолт хөрсний идэгдэл, голын сав газрын гидрологи болон загасны аж ахуйд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Үүний адил, загасны нэг зүйлийг хэтрүүлэн барих нь экологийн баланс болон экосистемуудын урт хугацааны нэгтгэлийг хөндөх талтай.
 - Болгоомжтой хандлагыг хүлээн зөвшөөрөх ёстой, мөн хамтын ба хуримтлагдсан нөлөөг авч үзэх ёстой.
 - Амьд баялгийг ашиглагчид хаягдлыг болон байгаль орчны сөрөг нөлөөг аль болохоор багасгах, ашиглалтаас гарах ашиг тусыг оновчтой болгох арга замыг хайх ёстой.
 - Байрлалд төрөлхийн бус зүйлс эсхүл популяцийн, тэгээд бас түрэмгийлэл болон орон нутгийн зүйлсийг давамгайлах туршилтанд ороогүй, тариалах буюу үржүүлэх явдлыг хязгаарлах ёстойгоос гадна тэдгээрийг ашиглалтын өмнө зохих судалгаанд оруулж, зөвшөөрөл авах ёстой.
 - Хөгжлийн бүст эсхүл орчин тойронд амьдардаг, биологийн олон төрөлхт байдлыг ашигладаг уугуул болон орон нутгийн нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ хөгжилд өртөж магадгүй бөгөөд түүнийг авч үзэхийн зэрэгцээ экосистемийг хадгалах, түүнийг тогтвортой байдлаар ашигласанд тэдний гүйцэтгэсэн эерэг үүрэг ролийг мөн харж үзэх хэрэгтэй.
19. Төслийн хөрөнгийн ашиггалийн тогтвортой байдлыг үнэлэхдээ Банк *Абба-ийн Биологийн олон төрөлхт байдлыг тогтвортойгоор ашиглах зарчим ба удирдамжийг* удирдлага болгох бөгөөд тэр нь биологийн олон төрөлхт байдлын баялгийг тогтвортой ашиглах⁴ явдлыг хангах явдлыг эрж хайдаг юм. Мөн Банк зохистой байдлаар экосистемийн менежментийн өртгийг шингээхийг төсөл, холбогдох засгийн газрын байгууллага болон бусад хариуцлагатай байгууллагад уриалж байна. Ой модны болон загасны салбарт ажиллаж байгаа үйлчлүүлэгчид доорхи холбогдох заалтуудтай нийцэж ажиллана.

Байгалийн ба тариалсан ой модны аж ахуй

20. Дээр тоймлосноор эвдэрсэн газар эсхүл байгалийн орчныг ой модны аж ахуй болгож хувиргах нь зохистой ажиллагааны асуудал юм. Ой модны салбар дахь

Банкнаас үндэслэлтэй гэж үзсэн цаг хугацаанд багтаан нийцэлтийг хангах _

⁴ Тогтвортой ашиглалт буюу менежментийг хүмүүс болон нийгмийн бүлгүүдэд тэдгээрийн өнөөгийн нийгэм, соёл болон эдийн засгийн сайн сайхан байдлыг хангахуйц хэмжээ, арга хэлбэрээр баялгийг ашиглахын хамт ирээдүйн үр удмын үндэслэлтэй, урьдчилан таах боломжтой хэрэгцээг хангах нөөц баягийн потенциалыг авч үлдэх болон агаар, ус болон хөрсний экосистемийн амьдралыг дэмжих чадавхийг, мөн туйлын чухал орчнуудын урт хугацааны бүрэн бүтэн байдлыг хадгалах явдал гэж тодорхойлдог.

менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Ойн бүтээгдэхүүнийг тогтвортой аргаар түүж хураах ёстой.

Загасны аж ахуй

21. Загас болон бусад усны зүйлс барих ажилд оролцож байгаа үйлчлүүлэгчид тэдний бүх ажиллагаа /барихаас эхлээд боловсруулахаар дуусах/ тогтвортой замаар явч байгааг Банкинд харуулах ёстой. Үүнд бие даасан гэрчилгээ⁵ /тийм юм байдаг бол/ олж авах эсвэл зохистой ажиллагааны хэсэг болгон судалгаа хийх замаар хүрч болно. Загасны аж ахуй заавал загас барихаар хязгаарлагдахгүй. Дахин үржүүлэх эсхүл өөр зүйлс эсвэл популяцийг нэвтрүүлэх /ялангуяа нуур шиг хаалттай байгаль орчинд/ нь шинэ загас одоогийн орон нутгийн загасны зүйлсийг устгахгүй юм уу хөөж нүүлгэхгүй байх явдлыг хангах ёстой.

Нийлүүлэлтийн хэлхээ

22. Хэрэв төсөл амьд баялаг /цаашид “баялаг”-ийн гадны нийлүүлэгчдийг ашигладаг бөгөөд тэдний хувьд үйлчлүүлэгч менежментийн хяналтгүй хийгээд энэ баялаг төслийн үндсэн үүрэг функцийн цөм бол үйлчлүүлэгч дараахийг хангах баялгийг тогтвортой нийлүүлэх бодлого, горим, арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч хэрэгжүүлнэ:

- зөвхөн хууль ёсны ба тогтвортой гаралтай баялгийг худалдаж авах;
- баялгийн гарлын мониторингийг хийх,
- баялаг нь хамгаалалттай бүс эсхүл экологийн өндөр үнэтэй гэж тооцогддог бүсээс гаралтай биш, өртсөн экосистемийн биологийн олон төрөл зүйлс болон функцийг олон улсын ба үндэсний баталсан стандартын дагуу хянан хамгаалах.

Боломжтой бол үйлчлүүлэгчид юуны өмнө олон улсын хүлээн зөвшөөрсөн тогтвортой менежментийн гэрчилгээтэй баялгийг худалдан авах.

Биологийн олон төрөлхт байдал ба жуулчлал

23. Шинэ эсхүл үлэмж өргөжиж байгаа жуулчлалын ажиллагааны байгаль орчны болон нийгмийн үнэлгээ нь *Биологийн олон төрөл зүйлс ба аялал жуулчлалын хөгжлийн тухай удирдамжтай*³ нийцэж байх ёстой. Тэр хэрэгцээтэй суурь мэдээллийг тоймлоно, авч үзэх ёстой асуудлуудын хүрээ, нөлөөг сааруулахын мөн чанар ба зохих мониторинг болон тайлагналтыг тоймлох хийгээд тэдгээрийг төслийн арга хэмжээний дараагийн төлөвлөгөөнд оруулах ёстой.

⁵ Далайн удирдах Зөвлөлийн тогтвортой засгас барилтын зарчмууд болон шалгуур үзүүлэлтүүд мэт.

ЕХШБ Гүйцэтгэлийн шаардлага 7: Нутгийн уугуул хүмүүс

Танилцуулга

1.Хувийн секторын төслүүд уугуул хүмүүст төсөлтэй хобоотой ажиллагаанд оролцож ашиг тус олох бололцоо нээж өгч чадахын хамт тэр нь эдийн засаг-нийгмийн хөгжлийн талаархи тэдний хүсэл тэмүүллийг биелүүлэхэд тусалж болох юм. Энэ Гүйцэтгэлийн шаардлага (“ГШ”) уугуул хүмүүс хувийн сектор ба түүний засгийн газрын төлөөлөгчидтэй түншийн нэгэн адил хөгжлийн замд мөр тулан ажиллаж, ажиллагаа болон үйлдвэрийн газруудыг дэмжин хөхүүлэх, удирдах замаар нээлттэй зах зээлийн эдийн засагт шилжих процесст зохих үүрэг гүйцэтгэж чадахыг хүлээн зөвшөөрч байна.

Нөхөрлөл. Энэ ГШ уугуул хүмүүст түнш гэдэг талаас хандаж байгаа бөгөөд тэднийг хүн гэж хүндэтгэн тэдгээр хүн зөвхөн өөрийнхөөсөө гадна үндэсний нийгэм-эдийн засгийн хөгжилд том хувь нэмэр оруулж чадна гэж үзэж байна. Гэхдээ энэ ГШ уугуул хүмүүс нийгмийн бүлгийн хувьд үндэсний нийгэмд давамгайлж байгаа бүлгүүдээс ялгагдаж байгаа бөгөөд олонтоо хүн амын хамгийн тусгаарлагдсан ба эмзэг хэсэгт багтадгийг хүлээн зөвшөөрч байна. Тэдний эдийн засгийн, нийгмийн болон хуулийн статус олонтоо өөрсдийн ашиг сонирхол, газар, байгалийн болон соёлын баялгийг эзэмших эрхээ хамгаалах чадавхийг хязгаарлаж байгаа бөгөөд хөгжилд оролцож ашиг тусыг нь хүртэх боломжийг хязгаарлаж болох талтай. Хэрэв тэдний газар ба баялгийг хувиргах, тэдний нийгмийн бүлгийн гишүүн бус хүмүүсийн халдлагад өртөх, эсхүл үлэмж муудах тохиодолд тэд нэн эмзэг болдог.

1. *Тусгай арга хэмжээний шаардлага.* Энэ ГШ уугуул хүмүүсийн нэгдмэл шинж чанар, соёл, газар болон нөөц баялаг нь хосгүй уялдаа холбоотой хийгээд зарим төрлийн хөрөнгө оруулалтаар авчрах өөрчлөлтөнд үлэмж эмзэг бөгөөд тэдний хэл, соёл, шашин шүтлэг, оюуны итгэл ба тогтолцоо аюулд нэрвэгдэж болзошгүй байгааг хүлээн зөвшөөрч байна. Ийм нөхцөл байдал уугуул хүмүүсийг төрөл бүрийн эрсдэл, түүний хатуу ширүүн нөлөөнд өртөх, үүнд нэгдмэл шинж чанар, соёл, байгалийн баялаг дээр үндэслэн аж амьдралаа алдах, мөн ядуурал ба өвчинд нэрвэгдэх аюулд ойртуулж байна. Уугуул соёлд эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн үүрэг роль нь давамгайлж байгаа бүлэгт байдгаас ялгаатайг цаашид хүлээн зөвшөөрч байна, эмэгтэйчүүд ба тэдний хүүхдүүд олонтоо тэдний өөрсдийн нийгмийн бүлэг дотроо ч, мөн гадны хөгжлийн улмаас улам бүр тусгаарлагдсан байдаг. Энэ бодит байдлын улмаас уугуул хүмүүст хамаатай асуудлууд олонтоо хэцүү ярвиг байдаг. Иймээс уугуул эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийг хохиролтой байдалд оруулахгүй, тэд зохих ёсоор Банкнаас дэмжиж буй төсөлд оролцож ашиг тусыг нь хүртэх явдлыг хангах тулд тусгай арга хэмжээ шаардлагатай байна.

4.Чөлөөтэй, урьдчилсан ба мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрлийн хэрэгцээ. Энэ ГШ Уугуул хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал¹ тоймлосон доорхи 31-34-р зүйлд тусгагдсан, төсөлтэй холбогдсон ажиллагаанд өртсөн уугуул хүмүүсийн урьдчилсан, мэдээлэлд тоймлосон доорхи 31-34-р зүйлд

¹ 2007 оны 9-р сарын 13-нд баталсан Ерөнхий Ассемблейн Уугуул хүмүүсийн эрхийн тухай тунхаглал

тоймлосон доорхи 31-34-р зүйлд тусгагдсан, төсөлтэй холбогдсон ажиллагаанд өртсөн уугуул хүмүүсийн урьдчилсан, мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөл шаардлагатай, учир нь тийм төслийн сөрөг нөлөөнд уугуул хүмүүс онцгой өртөмтгий гэсэн зарчмыг энэ ГШ хүлээн зөвшөөрдөг.

2. 5. *ЕСБХБ ажиллагаа явуулж байгаа орнууд:* Энэ ГШ ЕСБХБ ажиллагаа явуулж байгаа орнуудын нөхцөл байдал тэдний түүхээс шалтгаалан хосгүй онцлогтойг зөвшөөрч байна. Уугуул хүмүүс одоо заншиж сурсан аж амьдралаар амьдардаггүй болсон хийгээд тэдний нэгдмэл шинж чанарыг зөвхөн уламжлалт аж амьдрал, амьдралын хэв маягтай зүйрлэх боломжгүй болсон. Үүнээс гадна, уугуул хүмүүс холилдсон угсаатны суурин газарт олонтоо амьдардаг хэдий ч нүүдлийн амьдралын үргэлжлэл, бэлчээрийн мал оторлолт болон сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийн түүх нь одоо болтол тодорхой газартай шууд холбох явдал тэр болгон зохистой биш гэдгийг харуулж байна.

Зорилтууд

6. Өвөрмөц зорилтууд дараахи болно:

- Шилжилтийн процесс нь уугуул хүмүүсийн нэр хүнд, эрх, хүсэл тэмүүлэл, соёл болон байгалийн баялагт үндэслэсэн аж амьдралыг хүндэтгэх явдлыг хангах;
- Уугуул хүмүүсийн нийгмийн бүлгийн амьдрал, аж амьдралд үзүүлэх төслийн сөрөг нөлөөнөөс зайлхийх, хэрэв зайлхийлэх боломжгүй бол түүнийг багасгах, саармагжуулах эсхүл нөхөн олговор төлөх;
- Уугуул хүмүүст төслөөс ашиг тусыг соёлч боловсон хэлбэрээр хүртэх боломжоор хангах;
- Төслийн бүхий л ажиллагааны хугацаанд төсөлд өртсөн уугуул хүмүүстэй байнгын харилцаа тогтоож хадгалах явдалд үйлчлүүлэгчийг дэмжих;
- Хэрэв төсөл нь уугуул хүмүүсийн ашигладаг уламжлалт эсвэл заншмал газарт байрших болсны улмаас заншмал эсхүл уламжлалт бус аж амьдрал төсөлд өртөх, эсхүл уугуул хүмүүсийн соёлын баялгийг ашиг хонжвор олохоор ашиглах бол уугуул хүмүүстэй үйлчлүүлэгч хийх сайн итгэл санааны хэлэлцээ, уугуул хүмүүсийн мэдээлэлтэй оролцоог дэмжих;
- Уугуул хүмүүсийн заншмал хууль, ёс заншлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэх хийгээд тэдгээрийг анхааралдаа авах;
- Уугуул хүмүүсийн хүсэлтийн дагуу тэдний соёл, мэдлэг ба практикийг хүндэтгэн хамгаалах.

Хэрэглээний цар хүрээ

7. Төсөл уугуул хүмүүст нөлөөлөхөөр байвал энэ ГШ-г хэрэглэнэ.
8. Энэ ГШ-ын хэрэглээг Банк байгаль орчны болон нийгмийн үнэлгээ хийх үед доорхи 9-12-р зүйлд тоймлосон шалгуур үзүүлэлтийн дагуу шийдвэрлэнэ. Эдгээр шаардлагыг хангах арга хэмжээнүүдийн биелэлтийн менежментийг энэ ГШ, ГШ 1, ГШ 5, 8 ба 10-ын дагуу хийнэ.

9. “Уугуул хүмүүс” гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн тоёолол байхгүй. Уугуул хүмүүс гэдгийг янз бүрийн оронд янз бүрээр тайлбарладаг.
10. Бодлогод болон энэ ГШ-д “Уугуул хүмүүс” гэсэн нэр томъёог техникийн утгаар үндэсний нийгмийн хүрээнд давамгайлж байгаа бүлгээс ялгагдах нийгэм ба соёлын цөөнхийн бүлэгт хамааруулан хэрэглэж байгаа бөгөөд тэр бүлэг дараах шинж чанарыг янз бүрийн хэмжээнд агуулж байна:
- Ялгагдах орон нутгийн угсааны эсвэл соёлын бүлгийн гишүүн хэмээн өөрийгөө танин мэдэх бөгөөд тэр нийтлэг шинж чанарыг бусад хүмүүс хүлээн зөвшөөрөх;
 - Хамт олноороо газар зүйн хувьд ялгаатай орчин, төслийн бүс доторхи уламжлалт газар эсхүл өвөг дээдсийн нутаг дэвсгэрт, мөн тэдгээр орчин, нутаг дэвсгэр дээрх байгалийн баялагт уяастай байх²;
 - Уламжлалт ёсоор³ цалингүй /олонтоо нүүдлийн мал аж ахуй, бэлчээрийн оторлолтыг дагаж ирсэн/ аж амьдралын стратегийг хөөн ирсэн хүн амаас гаралтай, байр суурь нь тэдний өөрсдийн заншил буюу уламжлалт ёсоор, эсхүл тусгай хууль журмаар зохицуулагддаг;
 - Заншмал соёл, эдийн засаг, нийгэм эсвэл улс төрийн тогтолцоо нь давамгайлах нийгминхээс буюу соёлынхоос тусгаар;
 - Ялгаатай хэл буюу аялгуу, улс орон эсхүл бүсийн албан ёсны хэл буюу аялгуугаас нэлээд ялгаатай.
11. Бүлэг, бүлгийн гишүүд нүүдлийн буюу бэлчээр даган оторлох амьдралын замыг хөөж байгаа, холилдсон буюу хот суурийн газарт амьдарч байгаа, уламжлалт газар дээрээ улирлын чанартай очиж байгаа, хүчээр таслуулан салгуулах халыг туршиж үзсэн бодит байдал нь эхний харцаас энэ ГШ-г хэрэглэхэд саад болох учиргүй.
12. Энэ ГШ-ын зорилгоор ямар нэгэн бүлэг уугуул хүмүүст тооцогдох эсэхийг тогтоохын тулд Банк экспертийн зөвөлгөө эрж болно.

Шаардлага

13. Уугуул хүмүүс өртөх магадлалтай⁴ төслүүдийн хувьд үйлчлүүлэгчээс уугуул хүмүүст учрах нөлөөний үнэлгээ /доор үзнэ үү/ хийхийг шаардана. Түүний үр дүнгээс шалтгаалан үйлчлүүлэгч эхлээд сөрөг нөлөөнөөс зайлсхийлэх оролдлого хийх бөгөөд боломжгүй бол аливаа боломжит сөрөг нөлөөг багасгах ба/эсхүл сааруулах хийгээд ашиг тусыг тодорхойлох Уугуул хүмүүсийн хөгжлийн төлөвлөгөө /доорхи 21-р зүйлийн дагуу/-г боловсруулна. Үйлчлүүлэгчээс мөн өртсөн уугуул нийгмийн бүлгүүдтэй мэдээлэлтэй

² Албадан салгалтын улмаас төслийн бүс доторхи газар зүйн хувьд ялгаатай орчин эсхүл өвөг дээдсийнхаа нутгаас хамтын хавсарга байдлаа алдсан бүлэг төсөлд өртөхөөр байвал энэ ГШ-аар олгох хамгаалалтыг эдлэх эрхээ хадгална. “Албадан салгалт” гэдэг нь газар зүйн хувьд ялгаатай орчин эсхүл өвөг дээдсийнхаа нутгаас хамтын хавсарга байдлаа зөрчилдөөн, засгийн газрын нүүлгэн шилжүүлнр хөтөлбөр, өмчлэх эрх хасагдсан, байгалийн гай гамшиг, эсхүл тэр нутаг газрыг хот, суурин газартай нийлүүлснээс алдсан явдлыг хэлнэ. Энэ ГШ-ын зорилгоор “суурин газар” гэж ерөнхийдээ дараах шинж чанарыг анхааралдаа аван том хот, хотыг хэлдэг бөгөөд тэдгээр шинж чанарыг аль нь ч тогтсон, хүлээн зөвшөөрөгдсөн биш болно: (а) дотоодын хуулиар тэр бүсийг суурин газар гэж хууль ёсоор тогтоосон; (b) хүн амын өндөр нягтрал; (c) хөдөө аж ахуйн ажиллагаатай харьцуулбал хөдөө аж ахуйн бус ажиллагаа өндөр хувь эзэлдэг.

³ Хэрэв хөөцөлдөөн дуусгаар болсон ч үүнийг хэрэглэнэ өмнөх тайлбарын адил...

⁴ Төсөлд өртсөн уугуул хүмүүс гэдэг бол тэдгээрийн нийгэм-эдийн засгийн статус ба/эсхүл уламжлалт соёл болон амьралын зам нь төсөлд өртсөн уугуул хүмүүсийг хэлнэ.

зөвлөлдөн болон оролцоог зохион байгуулах, өвөрмөц зарга гомдлын механизмыг хэрэгжүүлэх, нөхөн олговор болон ашиг тусыг хуваалцах зорилгоор зохих арга замыг хайн олж шийдвэрлэхийг хүлээж байна.

14. Хэрэв үйлчлүүлэгч уугуул хүмүүст нөлөөлсөн байж болзошгүй эсхүл нөлөөлж мэдэх төслийн ажиллагааг Банк оролцож эхлэхээс өмнө эхлүүлсэн бол зохистой ажиллагааг а) аливаа зай завсрыг болон б) энэ ГШ-д нийцэх, шаардагдаж болох засч залруулах арга хэмжээг хайж олох зорилгоор явуулна. Тэгээд дараа нь авах арга хэмжээний төлөвлөгөөг тохиролцох ёстой.
15. Үйлчлүүлэгчийн байгууллагын хүрээнд зохих нөөц байхгүй бол туршлагатай ба бие даасан нийгмийн мэргэжилтнүүдийн зөвлөгөөг Төслийн хөгжил болон хэрэгжүүлэлтийн бүхий л явцын турш эрж хайх болно.

Үнэлгээ

16. Хэрэв тэнд нийгмийн үнэлгээний өвөрмөц төрлийг хийх үндэсний хуулийн шаардлага байдаг бол үйлчлүүлэгч түүнийг хийх ёстой бөгөөд уг үнэлгээг ЕСБХБ-тай хуваалцах ёстой, үүний дээр Банкнаас шаардсан аливаа нийгмийн үнэлгээг хийнэ.
17. Төсөл эхлээгүй тохиолдолд үйлчлүүлэгч нийгмийн үнэлгээний туслалцаатайгаар төслийн нөлөөллийн бүсийн хүрээнд эергээр ч ба сөргөөр ч төсөлд өртөж болзошгүй уугуул хүмүүсийн бүх нийгмийн бүлгийг илрүүлэх, мөн тэдэнд учирч болзошгүй нийгмийн, соёлын /соёлын өвийг оруулан/, байгаль орчны нөлөөний мөн чанар болон түвшинг тогтоож, (i) сөрөг нөлөөнөөс зайлсхийх эсхүл саармагжуулах, (ii) төсөлтэй холбоотой аливаа ашиг тусыг хуваалцах талаар төлөвлөсөн арга хэмжээг бэлтгэнэ.
18. Санал болгосон төслийн хувьд барилгын ажил, төсөлтэй холбоотой ажиллагаа, үйлдэл эхэлчихсэн байгаа тохиолдолд үйлчлүүлэгч Банкныг баримт болон мэдээллээр /компанийн өнгөрсөн үеийн гүйцэтгэлийг оролцуулан/ болон эрх баригчдад өмнө нь явуулсан баримтуудын тэмдэглэлэр хангах ёстой бөгөөд тэдгээр нь үйлчлүүлэгч төсөлд өртсөн уугуул хүмүүсийн санал бодлыг тогтоож, тэр бүхэн дээрхи санал бодлын үндсэн дээр ажилласан ба боломжийн хирээр энэ ГШ-д тусгасан процессыг дагаж мөрдсөнийг харуулах учиртай.
19. Хэрэв 18-р зүйлийн шаардлагыг хангасан бол Банк үйлчлүүлэгчээс бодитой бөгөөд бие даасан, төслийн уугуул хүмүүст үзүүлсэн нөлөөг ч, төслийн талаархи тэдний бодол санааг ч хамруулсан судалгааг гүйцэтгэхийг хүснэ. Соёлын зохимжтой хэв маягаар хийгдэх уугуул хүмүүсийн амьдрал, аж амьдралын түвшинд хийгдэх энэ судалгаа өнөөгийн цаг мөч хүртэл үзүүлж байгаа нөлөө, сөрөг нөлөөг сааруулах болон төслийн ашиг тусыг илрүүлэн хуваалцах болон төслийн төлөвлөлт болон хэрэгжилтэд уугуул хүмүүсийн оролцооны түвшинг хянаж нягтлах болно.

Сөрөг нөлөөнөөс зайлсхийх

20. Бүх чармайлт юуны өмнө уугуул хүмүүст үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийхэд чиглэгдэх ёстой. Хэрэв сөрөг нөлөөнөөс зайлсхийж болохгүй бол үйлчлүүлэгч тэр нөлөөг багасгах, саармагжуулах эсхүл тэр нөлөөг зохистой, пропорциональ хэлбэр маягаар нөхөн төлнө.

Уугуул хүмүүсийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах

21. Сөрөг нөлөөг багасгах, саармагжуулах, сөрөг нөлөөний нөхөн олговор олгох, ашиг тусыг илрүүлэх, хуваалцах үйлчлүүлэгчийн санал болгосон арга хэмжээнүүдийг өртсөн уугуул хүмүүсийн мэдээлэлтэй оролцоотойгоор улам боловсронгуй болгож, цаг хугацаа заасан Уугуул хүмүүсийн хөгжлийн төлөвлөгөө /УХХТ/, аль эсвэл нийгмийн бүлгийн хөгжлийн илүү өргөн, уугуул хүмүүсийн тусгаа бүрэлдэхүүн хэсэгтэй төлөвлөгөө болгож өөрчилнэ. Төлөвлөгөөг боловсруулахын тулд үйлчлүүлэгч техникийн мэргэшилтэй мэргэжлийн нийгмийн эрдэм шинжилгээний ажилтнуудыг авч үлдээнэ.

УХХТ-ний түвшин, хамрах хүрээ тухайн төсөл, төслийн ажиллагааны шинж чанар болон цар хүрээнээс шалтгаалан өөрлөгдөнө. Ерөнхийдээ УХХТ дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

1-р хэсэг – *Нийгмийн үнэлгээний тойм*

- Суурь мэдээлэл
- Гол дүгнэлтүүд : нөлөө, эрсдэл, бололцооны дүн шинжилгээ

2-р хэсэг – *Зөвлөлдөөн ба оролцоо*

- Зөвлөлдөөний үр дүн ба ирээдүйн ажил хэргийн төлөвлөгөө

Хэрэгжүүлэх төлөвлөгөө

- Сөрөг нөлөөнөөс зайлсхийх, багасгах, сааруулах ба эерэг нөлөөг хүчтэй болгох.
- Нийгмийн бүлэгт тулгуурласан байгалийн баялгийн менежментийг үргэлжлүүлэх явдлыг хангах арга хэмжээ
- Төслийн ашиг тус болон/эсхүл хөгжлийн бололцоог гарган авах арга хэмжээ
- Зарга гомдлын механизм
- Өртөг, төсөв, цаг хугацаа ба зохион байгуулалтын хариуцлага
- Мониторинг, үнэлгээ ба тайлагналт.

Мэдээллийг ил тод болгох, утга учиртай зөвлөлдөөн ба мэдээлэлтэй оролцоо

22. Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй байнгын харилцааг аль болохоос эртнээс, төслийн төлөвлөлтийн процессын явцад тогтоож, түүнийгээ төсөл дуустал үргэлжлүүлэх. Тэднийг шууд хөндөх асуудлуудаар, санал болгосон саармагжуулах арга хэмжээ, хөгжлийн ашиг тусыг хуваалцах болон хэрэгжилтийн асуудлаар тэдний мэдээлэлтэй оролцоог дэмжих зорилгоор ажил хэргийн процессын чвцад утга учиртай зөвлөлдөөнийг хийж байна.

23. Үйлчлүүлэгч төсөлд өртсөн уугуул хүмүүст зохих соёлтой боловсон хэлбэрээр ЕСБХБ-ны ГШ-дын тухай, мөн тэднийг хөндөж байгаа төслийн төлөвлөгөөний тухай мэдээллээр хагалттай хангах явдлыг хариуцна.

24. Нийгмийн бүлэгтэй тулж ажиллах процесс соёлтой, уугуул хүмүүсийн хамтын шийдвэр гаргах процессыг хүндэтгэсэн, уугуул хүмүүст учрах эрсдэл болон боломжийн нөлөөтэй зохицсон байна. Энэ процессыг зохих ёсоор явуулж байгаагаар ЕСБХБ-д харуулах нь үйлчлүүлэгчийн асуудал болно

25. Ялангуяа, ажил хэргийн процесс дараахийг багтаана:

- Уугуул хүмүүсийн төлөөлөгчийн байгууллага /тухайлбал, өндөр настны зөвлөл, тосгоны зөвлөл г.м./, уугуул хүмүүсийн байгууллага, мөн өртсөн хувь хүний оролцоог хангах;
- Ёс заншлын холбогдох хуулийг ойлгох, хүндэтгэх;

- Уугуул хүмүүсийн хамтын шийдвэр гаргах процесст хангалттай хугацаа олгох;
- Уугуул хүмүүс сонгосон хэл дээрээ өөрсдийн санал бодол, санаа зовоосон зүйл болон саналыг хөндлөнгийн булхайтай оролцоогүй, сүрдүүлэггүй бөгөөд соёлч боловсон байдлаар илэрхийлэхийг дэмжих;
- Уугуул бүлгүүдийг хөндөж болзошгүй нийгмийн болон экологийн нөлөөний нөлөөтэй холбогдох бүх төлөвлөгөө, мэдээллийг соёлч боловсон байдлаар ойлгомжтой хэлээр тайлбарлах;
- Нийгмийн бүлгийн нэг төрлийн бус байдлыг хүлээн зөвшөөрөх, ингэхдээ дараахийг бодолцох:
 - Уугуул хүмүүс холимог бүлэгт уугуул бус хүмүүстэй хамт амьдардаг;
 - Уугуул хүмүүс олон хэлтэй; зөвлөлдөөн болон оролцоонд бүх хүйс, нас, хасагдсан бүлгүүдийг татан оруулах ёстой;
 - Холбогдох мэдээллийг ЕСБХБ-д хүргүүлэх, бололцоотой бол Банкнийг зөвлөлдөх процесст оруулах;
- Зөвлөлдөөний процессыг бүрэн баримтжуулах⁵.

Зарга, гомдлын механизм ба гарал үүсэл дээр тулгуурласан ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх

26. Үйлчлүүлэгч төсөлд зориулж зарга гомдлын механизмыг тогтоох явдлыг хангана, ГШ 10-т зааснаар тэр нь соёлын хувьд зохимжтой бөгөөд уугуул хүмүүст дөхөм байна; тэр бичгэн горим журамд бага тулгуурлаж, голдуу аман харилцааны сувагт тулгуурлах магадлалтай.

27. Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийг угсаа гаралын үндсэн дээр гадуурхаж байгаа төслүүдийг санхүүжүүлэхгүй. Хэрэв Банк санхүүжүүлж байгаа төслүүд дээр уугуул хүмүүсийг ашиг тусаас, тухайлбал ажил эрхлэх бололцооноос угсаа гаралын үндсэн дээр салгах далд хүчин зүйлс үйлчилж байгаа бол төслийн ажиллагаа дараах засч залруулах арга хэмжээг багтаана: (i) уугуул хүмүүсийн байгууллага, хувь хүнд хөдөлмөрийн, нийгмийн, санхүүгийн болон бизнесийн хууль тогтоомжийн дагуу тэдний эдлэх эрх болон байгаа тусламж эрэх механизмын тухай мэдээлэх; (ii) зохих болон үр дүн бүхий мэдээлэл тараалт, сургалт, мөн зээл, ажил эрхлэлт, бизнесийн үйлчилгээ, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ, төслүүдээс үүсэх бусад ашиг тус зэрэг төслүүдээс үүсэх, дэмжигдэх ашиг тус, баялгийг хүртэхэд саад, хорио болж байгаа зүйлсийг үгүй хийх арга хэмжээг авах, (iii) уугуул ажилчид, бизнес эрхлэгчид болон ашиг хүртэгчдэд үндэсний хууль тогтоомжоор төстэй салбар ба зэрэглэлийн хувь хүнд олгодогтой адил хамгаалалтыг олгох, ингэхдээ хүйсийн асуудал болон барааны ба хөдөлмөрийн зах зээлд байгаа угсаа гаралын сегментчилал болон хэлний хүчин зүйлийг анхааралдаа авах.

Нөхөн олговор ба ашиг тусыг хуваалцах

28. Оролцооны арга зам бол саармагжуулалт, ашиг тусыг хуваалцах, заншлалын амьдралын хэв маягийг дэмжих арга хэмжээний үндсийг тодорхойлох суурь болно. Банк үйлчлүүлэгчээс өртсөн уугуул хүмүүст төсөлтэй холбоотой үйл ажиллагаанаас учрах аж амьдралын аливаа алдагдал /энэ ГШ-ын дагуу тооцсон/-ын төлөө шууд нөхвөр олгох, ашигласан аливаа газрыг өмнөх статуст хүртэл нөхөн сэргээхийг шаардана. Нөхөн олговрыг хүлээж авах боломж хувийн эсхүл хамт олных байж болно, эсвэл тэлний хослол байж болно. Нөхөн олговрыг заншмал аж амьдралд үзүүлэх сөрөг нөлөө, мөн цалин хөлс, эсхүл ашгаас шалтгаалах эдийн засгийн санаачилганд үзүүлэх сөрөг нөлөө, АШГААС шалтгаалах эдийн засгийн санаачилганд учруулах сөрөг нөлөөнд төлнө.

⁵ Эдгээр нь бичсэн бичлэг ба тэмдэглэл ба/эсхүл дуун бичлэгийг багтааж болно.

“Заншлалын аж амьдрал” гэсний утга чанарыг уян хатан /этно-жуулчлал болон хоол бэлтгэл мэт түр зуурын орчин үеийн хялбаршуулалтыг багтаахын тулд/ ойлгоно. Нөхөн олговрыг тооцохдоо үйлчлүүлэгч анхааралдаа уугуул хүмүүсийн уламжлалт амьдралын маяг болон гэр бүлийн амьдралд төслийн үзүүлэх сөрөг нөлөөг авна. Үүнийг уугуул хүмүүсийн төлөөлөгч болон экспертуудын хамтын ажиллагааны туслалцаатайгаар гүйцэтгэнэ. Энэ зүйлийн заалтуудыг үйлчлүүлэгч орон нутгийн болон бүс нутгийн төлөөлөгч байгууллагуудад нөхөн олговор төлөх тохиолдолд хэрэглэнэ.

29. Нөхөн олговор болон УХХТ-г хэрэгжүүлэх бололцоотой болон хуулийн хувьд үндэслэлтэй арга замыг уугуул хүмүүстэй хийх зөвлөлдөөний үеэр авч хэлэлцэнэ. Эдгээр зөвлөлдөөн дээр үндэслэн нөхөн олговрыг болон баялгийг шилжүүлэх механизмыг боловсруулан тохиролцоно. Хэрэв шаардлагатай бол зохих менежментийн болон удирдлагын системийг тогтооход тусламж/дэмжлэгийг үйлчлүүлэгч үзүүлнэ.

30. Үйлчлүүлэгч утга учиртай зөвлөлдөөн болон уугуул хүмүүсийн⁶ өртсөн бүлгүүдийн мэдээлэлтэй оролцооны процессоор дамжуулан соёлын зохимжтой ашиг тусыг хүртэх бололцоогоор хангана. Тийм бололцоо төслийн нөлөөний хэм хэмжээтэй, тэдний амьжиргааны стандарт, аж амьдралыг зохистой хэв маягаар дээшлүүлэхтэй болон тэдний түшиг болох байгалийн баялгийн урт хугацааны тогтвортой байдалтай дүйцэх ёстой. Үйлчлүүлэгч энэ ГШ-ын шаардлагатай нийцэх хөгжлийн илрүүлсэн ашиг тусыг баримтжуулж, тэдгээрээр цаг хугацаанд нь хангана. Заншлалын аж амьдралын ажиллагааг хүчтэй дэмжих ёстой бөгөөд үүнд уламжлалт эдийн засгийн ажиллагаа болон түүний орчин үеийн үүсмэл зүйл болох гар урлал ба этно-жуулчлал багтана.

Тусгай шаардлага

31. Уугуул хүмүүс төслийн дор дурдсан нөхцөл байдалд, ялангуяа өртөмхий байж мэдэх тул дээр дурдсан Ерөнхий шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг мөн хэрэглэнэ. Эдгээр шаардлагын нэг нийтлэг зүйл бол үйлчлүүлэгч дараахийг гүйцэтгэх ёстой:

- уугуул хүмүүстэй итгэлцэл, сайн санааны хэлэлцээ хийх;
- уугуул хүмүүсийн мэдээлэлтэй оролцоог хангах;
- дор заасан ажиллагааг эхлэхийн өмнө уугуул хүмүүсийн чөлөөтэй, урьдчилсан ба мэдээлэлтэй зөвшөөрлийг⁷ авах.

Дараах аливаа нөхцөл байдлын тохиолдолд үйлчлүүлэгч 32-37-р зүйлд дурдсан ажиллагааг явуулах, баримтжуулахад туслуулахаар мэргэжлийн бие даасан нийгмийн эрдэм шинжилгээний ажилтнуудыг авч үлдээнэ.

Ашиглалтанд байгаа уламжлалт эсхүл заншмал газарт тусгах нөлөө

32. Уугуул хүмүүс олонтоо тохиолдолд тэдний заншмал газар, түүний ой мод, ус, зэрлэг амьтад болон бусад байгалийн баялагтай ойрын хэлхээ холбоотой бөгөөд хэрэв төсөл тийм хэлхээ холбоонд нөлөөлөх бол тусгай анхаарал шаардагдана.

⁷ Зөвшөөрөл гэдэг нь уугуул хүмүүсийн өртсөн бүлгүүд өөрсдийн соёлын уламжлал, заншил ба практикийн дагуу санал болгосон төсөлд оролцох эсэхийн талаар шийдвэрт хүрэх процессыг хэлж байна.

Хэдийгээр үндэсний хуулийн дагуу эдгээр газар нь хуулийн өмчлөлд байхгүй байж болох боловч уугуул хүмүүсийн нийгмийн бүлгүүдийн зүгээс аж амьдралаа хангах,

эсхүл тэдний нэгдмэл шинж чанар болон бүлгийг тодорхойлдог соёлын, ёслолын, сүсэг бишрэлийн зорилгоор эдгээр газрыг ашигладаг бол, үүнд улирлын ба циклын ашиглалт орно, түүнийг нэг бус удаа нотолж, баримтжуулж болно.

33. Хэрэв үйлчлүүлэгч төслийг ашиглалтанд байгаа заншмал газар дээр байршуулах эсхүл түүний хүрээнд байгаа байгалийн баялгийг арилжааны зорилгоор ашиглах санал тавибал уугуул хүмүүсийн аж амьдрал, эсхүл тэдний нэгдмэл шинж чанар болон бүлгийг тодорхойлдог соёлын, ёслолын, сүсэг бишрэлийн ашиглалт сөрөг нөлөөнд⁸ өртөж болзошгүй тул үйлчлүүлэгч тэдгээрийг дараах байдлаар ашиглахыг хүндэтгэнэ:

- Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийн өрсөн нийгмийн бүлгүүдтэй итгэлцэл сайн хэлэлцээ хийж эхлэх бөгөөд хэлэлцээний үр дүн болгож тэдний мэдээлэлтэй оролцоо болон зөвшөөрлийг баримтжуулна.
- Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийн ашиглаж, байрлаж ба/эсхүл эзэмшиж байгаа хийгээд төсөлд зориулагдсан газраас татгалзар, эсхүл түүний хэмжээг аль болохоор багасгахын тулд гаргасан хүч чармайлтаа баримтжуулна.
- Уугуул хүмүүсийн газрын ашиглалтыг экспертүүд уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй хамтран уугуул хүмүүсийн газрын талаархи аливаа бусад нэхэмжлэхэд хохирол учруулахгүйгээр баримтжуулна.
- Уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдэд үндэсний хуулийн дагуу газрын талаар тэдний эдлэх эрхийн тухай мэдээлнэ, үүний дотор заншлалын эрх эсхүл ашиглалтыг хүлээн зөвшөөрдөг үндэсний аливаа хуулийн тухай.
- Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдэд хамгийн багаар нөхөн олговрыг санал болгохоос гадна үндэсний хуулийн дагуу тэдний газрыг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд газартай холбогдсон бүрэн хуулийн эрхтэй хүмүүст зохих процессыг соёлын зохимжтой хөгжлийн бололцооны хамт санал болгоно; боломжтой бол газарт үндэслэсэн нөхөн олговор эсвэл бодит нөхөн олговрыг мөнгөн нөхөн олговрын оронд санал болгоно.
- Үйлчлүүлэгч өртсөн уугуул хүмүүсийн нийгмийн бүлгүүдэд дотроо тохиролцоо хангалттай цаг хугацааг үйлчлүүлэгчээс өөрийн санааг шууд эсхүл шууд бус тулгалгүйгээр өгнө.

34. Үйлчлүүлэгч омбудсмен ба/эсхүл холбогдох үндэсний системд ажилладаг төстэй олон нийтийн байгууллагын үүрэг функцийг төслийн талаархи/үйлчлүүлэгчээс санал болгосон газар ашиглалт/саармагжуулах багцын талаархи нийгмийн бүлгийн зөвшөөрлийг гаргах явдлыг ханган дэмжих зорилгоор ашиглаж болно. Төслийн хэрэгжилтийн явцад уугуул хүмүүс болон үйлчлүүлэгчийн хооронд үүссэн, төслийн зарга гомдлын механизмаар орсон хэдий ч шийдвэрлэгдээгүй аливаа зөрчлийг үйлчлүүлэгч ЕСБХБ-ны анхааралд нэн даруй хүргэнэ. Банк нөхцөл байдлыг үнэлж, асуудлыг шийдвэрлэхэд зохимжтой хандлагын талаар шийдвэр гаргана.

Уугуул хүмүүсийг уламжлалт эсхүл заншлалын газраас нүүлгэн шилжүүлэх

35. Үйлчлүүлэгч уугуул хүмүүсийг ашиглалтанд байгаа тэдний хамтран эзэмшдэг уламжлалт эсхүл заншлал газраас нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх үндэслэл бүхий альтернатив төслийн дизайныг эрж хайна. Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх

⁸ Сөрөг нөлөө нь төслийн ажиллагаанаас шалтгаалан актив эсхүл баялгийг алдах, газар ашиглалтанд, эсхүл уламжлалт амьдралын замыг хөөн амвдрахад хязгаар тавихыг багтааж болно бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

боломжгүй бол үйлчлүүлэгч өртсөн уугуул хүмүүсийн нийгмийн бүлгүүдээс чөлөөтэй, урьдчилсан ба мэдээлэлтэй зөвшөөрлийг итгэдцэл, сайн санааны хэлэлцээний үр дүнд олж авахаас өмнө тийм нүүлгэн шилжүүлэлтийг явуулахгүй. Эдгээр хэлэлцээ нь уугуул хүмүүсийн хууль, уламжлал, ёс заншил газрын эзэмшлийг анхааралдаа авах ёстой бөгөөд тэдний бүрэн оролцоог шаардана. Уугуул хүмүүсийн аливаа нүүлгэн шилжүүлэлт ГШ 5-т заасан Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт болон Хэрэгжилтийн шаардлагатай нийцэж байх ёстой. Уугуул хүмүүс уламжлан эзэмшиж байсан, эсхүл эзлэн амьдарч байсан, эсхүл ашиглаж байсан, гэхдээ одоо тэдний чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөлгүйгээр төслийн улмаас хураагдсан, авагдсан, эзлэгдсэн, ашиглагдсан эсхүл эвдэрч гэмтсэн газар, нутаг дэвсгэр болон байгалийн баялгийн төлөө шударга, тэнцүү нөхөн олговор авах ёстой.

36. Үндэс боломж байгаа бол шилжин нүүсэн уугуул хүмүүс шилжин нүүлгэлтийн шалтгаан арилах тохиолдолд өөрсдийн уламжлалт эсхүл зашмал газарт буцаж очих боломжтой байх ёстой бөгөөд газрыг нөхөн сэргээсэн байх ёстой.

Cultural Resources

37. Хэрэв төсөл нь уугуул хүмүүсийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаачилга эсхүл практикийг арилжааны зорилгоор ашиглах санал тавибал үйлчлүүлэгч уугуул хүмүүст: (i) үндэсний хуулиар олгогдсон тэдний эрх; (ii) санал болгосон арилжааны хөгжлийн цар хүрээ ба шинж чанар; (iii) тийм хөгжлийн боломжит үр дагаврын тухай мэдээлнэ. Хэрэв тэр дараахийг хангахгүй бол үйлчлүүлэгч тийм ашиг хонжоо олох ажлаар хөөцөлдөхгүй: (i) уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй итгэлцлийн хэлэлцээ хийх; (ii) тийм ажиллагаа явуулах тэдний мэдээлэлтэй оролцоо болон тэдний чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл олгохыг баримтжуулсан байх; болон (iii) тэдний ёс заншил ба уламжлалтай холбоотой тийм мэдлэг, шинэ санаачилга эсхүл практикийг ашиг хонжоо олох үйл ажиллагаанд чиглүүлснээс олох ашиг тусыг шударга, тэнцүү хуваах явдлыг хангана.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 8: Соёлын өв

Танилцуулга

1. ЕСБХБ нь одоогийн болон ирээдүйн үе удамд үзүүлэх соёлын өвийн чухлыг хүлээн зөвшөөрч байна. Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай Конвенци ба Материаллаг бус өвийг хамгаалах тухай Конвенцитай нийцэж байгаа энэ Гүйцэтгэлийн шаардлага орлуулшгүй соёлын өвийг хамгаалах болон үйлчлүүлэгчдийг бизнесийнхаа ажиллагааны явцад соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх эсхүл багасгахад чиглүүлж байна. Үүнээс гадна, энэ Гүйцэтгэлийн шаардлагын соёлыг өвийг төсөл ашиглахтай холбогдсон шаардлагууд хэсэгчлэн Биологийн олон төрөлхт байдлын тухай Конвенциар тогтоосон стандартуудад үндэслэж байгаа болно. Банк нь соёлын өвийн менежмент, түүний тогтвортой ашиглалтанд болгоомжтой, Рио-гийн Тунхаглалын дагуу хандах явдлыг дэмжиж байна.
2. Соёлын өв үнэ цэнэтэй түүхийн болон шинжлэх ухааны мэдээллийн эх үүсвэрийн хувьд, эдийн засаг-нийгмийн хөгжлийн активын хувьд, хүмүүсийн соёлын нэгдмэл шинж чанарын салшгүй хэсэг болохын хувьд чухал юм.
3. Хамгаалалт, хадгалалтын эдгээр зорилтын биелэлтийг хангахдаа Банк холбогдох олон улсын Конвенциуд болон бусад хэрэгслийг¹ мөрдлөг болгон дэмждэг. Төслийн нөлөөний бүс нутагт соёлын өвд хамаатай хууль, журмыг бүх тал дагаж мөрдөх, мөн ажиллагаа явуулж байгаа орны олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хүндэтгэх шаардлагыг ЕСБХБ хүлээн зөвшөөрдөг. Эдгээр хууль нь соёлын өв эсхүл эртний эд зүйлсийн тухай хууль, төлөвлөлт эсхүл барилгын ажлын зөвшөөрлийн тухай хууль, хадгалалтын эсхүл хамгаалалтын талбайн тухай журам болон бий болсон түүхийн орчин тойрныг зохицуулсан бусад хууль, журам эсхүл уугуул хүмүүсийг хамгалахтай хамаатай хууль байж болно.

4. Зорилтууд

Энэ Гүйцэтгэлийн шаардлага /ГШ/-ын зорилтууд бол:

4. ЕСБХБ-ны санхүүжүүлж байгаа төслүүдийн нөхцөлд соёлын өвийг хадгалахыг дэмжих;
 1. Соёлын өвийг төслийн ажиллагааны сөрөг нөлөөнөөс хамгаалах;
 2. Бизнесийн ажиллагаанд соёлын өвийг ашигласнаас олох ашиг тусыг тэнцүү хуваах явдлыг дэмжих;
 3. Боломжтой газар бүр соёлын өвийн тухай ойлголт болон үнэлэлт талархлыг дэлгэрүүлэн дэмжих.
 4. Боломжтой газар бүрт соёлын өвийн тухай ойлголт, бахархлыг дэлгэрүүлэх
5. Энэ ГШ соёлын өвийг сөрөг нөлөөнөөс зайлсхийх замаар хамгаалах, хэрэв зайлсхийлэх боломжгүй бол ЕСБХБ-ны санхүүжүүлж байгаа ажиллагаанаас учирч

¹ Тухайлбал, дараах:

- Дэлхийн соёлын болон байгалийн өвиог хамгаалах тухай Конвенци, 1972 /ЮНЕСКО Дэлхийн өвийн Конвенци/
- Материаллаг бус соёлын өвийг хамгаалах тухай Конвенци, 2003 /ЮНЕСКО Материаллаг бус өвийн Конвенци/
- Усан доогуурх өвийг хамгаалах тухай Конвенци, 2001 /ЮНЕСКО Усан доогуурх өвийн Конвенци/
- Нийгмийн хувьд соёлын өвийн үнэ цэнийн тухай Европын Зөвлөлийн бүдүүвч Конвенци, 2005

- Соёлын ач холбогдолтой газрыг хамгаалах тухай Австралийн ХТОУЗ-ийн Тунхаг бичиг /Буррагийн Тунхаг бичиг/ Австралийн ХТОУЗ

болзошгүй сөрөг нөлөөг зохих болон пропорциональ маягаар багасгах, сааруулах ерөнхий бүдүүвчийг үйлчлүүлэгчдэд тогтоож өгч байгаа юм.

Хэрэглээний цар хүрээ

6. Хэрэв төсөл орлуулшгүй соёлын өвийг хөндөж болзошгүй тохиолдолд энэ Бодлогыг хэрэглэнэ. Энэ ГШ-ын заалтуудыг соёлын өв хууль ёсоор хамгаалалтад авагдсан эсэх, эсхүл урьд нь гэмтсэн эсэхийг үл харгалзан хэрэглэнэ.
7. Энэ ГШ-ын зорилгуудын үүднээс соёлын өв гэсэн нэр томъёог дараахаар тодорхойлно: өнгөрсөн үеэс өвлөсөн баялгийн бүлэг, хүмүүс тэднийг өмчлөлийг харгалзахгүйгээр тэдний байнга хөгжиж буй үнэт чанар, итгэл, мэдлэг болон уламжлалын тусгал болон илэрхийлэл хэмээн тодорхойлдог. Тэр материаллаг /биет/ болон материаллаг бус өвийг багтаадаг бөгөөд түүний хил хязгаар нь өвийн экспертиудын дунд өрнөсөн үлэмж маргааны цөм болж байна. Соёлын өвийг орон нутгийн, бүсийн, үндэсний түвшинд эсхүл олон улсын хамт олны ² хүрээнд үнэлж болно.
 - Биет соёлын өв археологийн, палеонтологийн, түүхийн, архитектурын, шашин шүтлэгийн, гоо сайхны ач холбогдолтой хөдлөх ба үл хөдлөх зүйлс, талбай, бүтцийн хэсэг, байгалийн онцлог чанар болон гоо үзэсгэлэнт газрыг хамааруулна.
 - Материаллаг бус соёлын өв гэж нийгмийн бүлэг, хэсэг болон зарим тохиолдолд хувь хүн тэдний соёлын өвийн хэсэг гэж үздэг, нэг үе удамаас дараах үе удамд³ шилжин ирдэг практик, төсөөлөл, илрэл, мэдлэг, ур чадвар, мөн хэрэгсэл, зүйлс, хүний гараар бүтсэн зүйл болон тэдгээртэй холбоотой соёлын орчинг хэлнэ.
8. Соёлын өвийн үнэ цэн эсхүл ач холбогдлыг илэрхийлсэн талбай эсхүл зүйлсийг батлагдсан төслийн бодит хэрэгжилтийн үеэр хүлээж байгаагүй байрлалд олж болохыг ЕСБХБ хүлээн зөвшөөрч байна. Төсөлд энэ ГШ-ын заалтуудыг хэрэглэнэ, хэрэв тэр:
 - үлэмж хэмжээний газар ухалт, эвдрэл сүйдэл, газрын хөдөлгөөн, үер зэрэг биет байгаль орчинд өөрчлөлт оруулах ажиллагааг багтааж байвал,
 - ажиллагаа явуулж байгаа орны хүлээн зөвшөөрсөн соёлын өвийн талбай дотор, эсхүл ойролцоо байрлаж байгаа бол,
 - уугуул хүмүүсийн соёл, мэдлэг ба практикт сөрөг нөлөө үзүүлмээр байвал.
9. Бусад тохиодолд энэ ГШ-ыг хэрэглэх асуудлыг Банк байгаль орчин болон нийгмийн үнэлгээний процессын явцад шийдэнэ /Доорхи 10-р зүйлийг үзнэ үү/. Соёлын өвийн хадгалалт болон менежментийг дэмжихээр онцлон зориулагдсан төслүүдийг Банк нэг бүрчлэн хянан нягтална. Зохимжтой бол энэ ГШ-ын шаардлагуудыг, байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний бүхэл төлөвлөгөөний /БОНААТ/ ба менежментийн системийн нэг хэсэг болгон хэрхэн чиглүүлж, зохицуулахыг Банк үйлчлүүлэгчтэй тохиролцоно. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ болон менежментийн шаардлагыг ГШ 1 ба ГШ 10-т тоймлосон болно.

² Энэ тодорхойлолт нь Нийгмийн хувьд соёлын өвийн үнэ цэнийн тухай Европын Зөвлөлийн бүдүүвч Конвенцитай нийцэж байгаа болно. Соёлын өвийг мөн соёлын удам дамжсан өв хөрөнгө, соёлын актив, соёлын баялаг эсхүл соёлын хөрөнгө гэж нэрлэдэг.

³ Материаллаг бус соёлын өвийг хамгаалах тухай Конвенцид тусгаснаар.

Шаардлага

Үнэлгээ

Соёлын өвөнд учирч болзошгүй эрсдэл ба нөлөөг шалгах

10. Байгаль орчны болон нийгмийн үнэлгээний эрт үе шатанд /ГШ 1-ийг үзнэ үү/ үйлчлүүлэгч аливаа соёлын өв төслийн сөрөг нөлөөнд өртөж болохыг илрүүлж, санаандгүй аливаа олдцотой тааралдах боломжийг үнэлнэ /16-р зүйлийг үзнэ үү/. Үүнийг хийх явцад үйлчлүүлэгч зохистой маягаар холбогдох яамд, эксперт болон орон нутгийн нийгмийн бүлгүүдтэй уулзаж, зөвлөлдөнө.⁴ Соёлын баялгийн судалгааны эрч хүч нь болгоомжтой хандлага болон холбогдох хувь эзэмшигчдийн сэтгэлийн зовиурын тусгалтай нийцэх эрсдэл ба нөлөөг бүрэн дүүрэн тодорхойлоход хангахуйц байх ёстой.

Материаллаг бус өвөнд үзүүлэх нөлөө

11. Хэдийгээр соёлын материаллаг бус өвөнд үзүүлэх боломжит нөлөө соёлын материаллаг өвд үзүүлэх нөлөөнөөс бага илэрхий байж болох боловч тэд адил үр дагавартай байж болно. Уламжлалт ур чадвар, мэдлэг ба итгэлийг хадгалахад байгаль орчин шийдвэрлэх ач холбогдолтой бол аливаа нүүлгэн байршуулалт эсхүл салгалт уламжлалт мэдлэг, болон/эсхүл жижиг хэл, аялгууг алдахад хүргэж болох бөгөөд эцсийн эцэст нийгмийн бүлгийн задралд хүргэж мэднэ.

Нөлөөнөөс зайлсхийх

12. Үйлчлүүлэгч соёлын өвөнд ноцтой хохирол учруулахгүй төслийг байршуулах болон төлөвлөхийн төлөө хариуцлага хүлээнэ. Хэрэв төслийн хөгжлийн эрт үе шатанд боломжит нөлөөг илрүүлсэн бол, дизайны болон барилгын талбайг сонгох үе шатанд сөрөг нөлөөнөөс зайлсхийх явдыг илүүд үзвэл зохино.

Зайлсхийх боломжгүй нөлөөг үнэлэх

13. Нөлөөнөөс зайлсхийх боломжгүй бол үйлчлүүлэгч урьдчилсан шалгалтын дүнд үндэслэн боломжит нөлөөг, шаардлагатай бол зураг төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлтүүдийг үнэлэх судалгааг хийнэ. Энэ судалгааны цар хүрээг ЕСБХБ-тай төсөл бүрчлэн тохирно. Судалгааг мэргэжлийн, туршлагатай соёлын өвийн мэргэжилтнүүд ГШ 1-ийн дагуу бүхэл байгаль орчны болон нийгмийн үнэлгээний нэг хэсэг болгон, эсхүл тусад нь хийнэ. ЕСБХБ гадны экспертуудын оролцоог шаардаж болно.
14. Соёлын өвөнд нөлөөлөх нөлөөний үнэлгээ ба саармагжуулалтыг үндэсний болон/эсхүл орон нутгийн хууль, журам болон хамгаалалтын бүсийн менежментийн төлөвлөгөө, олон улсын хууль ба олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн сайн практикийн дагуу хийнэ. ЕСБХБ-ны ажиллагаа явагдаж байгаа ихэнхи оронд хууль нь биет соёлын өвийн объектыг зайлуулах ба талбайг эвдэлж сүйтгэхийг хориглодог. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн сайн практик нь археологийн эсхүл палеонтологийн хээрийн судалгаа, олдсон зүйлсийн лабораторийн шинжилгээ, шинэ олдцыг харуулсан үзэсгэлэн, баримт бичгийг багтаана, гэхдээ түүгээр хязгаарлагдахгүй.

Соёлын өвөнд учрах нөлөөний менежмент

⁴ ГШ № ба 10-ыг үзнэ үү. А зэрэглэлийн төслүүдийн тохиолдолд үүнийг судалгаа тооцооны уулзалтын үед хэлэлцэж болно. ГШ 10-ын 10-р хэсгийг үзнэ үү.

15. Үйлчлүүлэгч хээрийн судалгааны үр дүнд үндэслэн, соёлын өвийн ач холбогдлын талаархи экспертын үнэлгээ, үндэсний хууль тогтоомж болон холбогдох олон улсын конвенциудын шаардлага, мөн өртсөн нийгмийн бүлгүүдтэй хийсэн зөвлөлдөөний үр дүнд /17-р зүйлийг үзнэ үү/ үндэслэн тэр соёлын өвөнд учрах аливаа сөрөг нөлөөг багасгах, саармагжуулах зорилгоор зохих саармагжуулах арга хэмжээг хэрэгжүүлэлтийн хуваарь ба тэдгээр арга хэмжээнд шаардагдах төсвийн хамт боловсруулах шаардлагатай болно. Тэдгээр саармагжуулах арга хэмжээг төслийн Байгал орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө болон тусгаа Соёлын өвийн менежментийн төлөвлөгөөнд оруулж болох юм. Үйлчлүүлэгч саармагжуулах арга хэмжээний биелэлтийг хянах сургалтанд хамрагдсан болон мэргэжлийн ажилтнуудыг бэлэн байлгах, төсөл дээр ажиллаж байгаа аливаа гэрээт гүйцэтгэгч шаардагдах ур чадвар болон мэргэжилтэй байх бөгөөд тэдний менежмент ба мониторингийг ГШ 1-ийн 19 –р зүйлийн дагуу хийх явдлыг хангана.

Тохиолдлын олдочны горим журам

16. Үйлчлүүлэгч тохиолдлын олдочны, төслийн хэрэгжилтийн явцад санаандгүй олсон биет соёлын өв хэмээх, менежментийн заалтууд биелэгдэх явдлыг хангана. Эдгээр заалт нь олсон зүйлс эсхүл талбайны тухай холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдээлэх; төслийн ажилтнуудыг тийм санаандгүй олоц олдох боломжийн талаар сэргийлэх; болон цаашдын бужигнаан эсхүл эвдрэл сүүдлээс зайлхийлэхийн тулд олоц олдсон бүсийг тойруулан хашаа барих зэргийг багтаана. Үйлчлүүлэгч зориулалтын болон мэргэжлийн мэргэжилтэн үнэлгээг хийж, үндэсний хууль тогтоомж болон энэ ГШ-тай нийцэх арга хэмжээг тодорхойлол аливаа тохиолдлын олоцыг эвдэхгүй байна.

Өртсөн нийгмийн бүлгүүдтэй хийх зөвлөлдөөн

17. Хэрэв төсөл соёлын өвийг хөндөх магадлалтай бол үйлчлүүлэгч хүлээн авагч орны дотор урт хугацааны зорилтын тулд соёлын өвийг ашиглаж байгаа, эсхүл санаанд орох хугацаанд ашиглаж байсан өртсөн нийгмийн бүлгүүдтэй чухал ач холбогдолтой соёлын өвийг тодорхойлох хийгээд үйлчлүүлэгчийн шийдвэр гаргах процесст өртсөн нийгмийн бүлгүүдийн тийм соёлын өвийн талаархи санал бодлыг тусгаж оруулахын тулд, зөвлөлдөөн хийнэ. Үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлгүүдэд төслийн цар хүрээ, байршил, хугацаа болон соёлын өвөнд нөлөөлж болох аливаа ажиллагааны тухай мэдээллийг ил тод, зохих хэл дээр хүргүүлнэ. Тийм зөвлөлдөөн ГШ 10-ын шаардлагыг даган мөрдөх ёстой бөгөөд ГШ 10-ын дагуу төслийн байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн тухай илүү өргөн зөвлөлдөөний процессын нэг хэсэг байж болно. Зөвлөлдөөн мөн соёлын өвийг хамгаалах үүрэг бүхий холбогдох үндэсний эсхүл орон нутгийн зохицуулалтын байгууллагуудыг оролцуулна. Соёлын өвөнд үзүүлэх нөлөөг өртсөн нийгмийн бүлгүүдийн мэдээлэлтэй оролцоотойгоор зохих ёсоор сааруулна.
18. Хэрэв төсөл соёлын өвийг ноцтой хөндөх магадлалтай хийгээд түүний эвдрэл эсхүл алдагдал нь ажиллагаа явагдаж байгаа, соёлын өвийг урт хугацааны зорилгоор ашигладаг улс орон доторхи нийгмийн бүлгүүдийн соёлын эсхүл эдийн засгийн амьдрах чадварт аюул учруулах бол үйлчлүүлэгч 17-р зүйлийн шаардлагыг хэрэглэх бөгөөд дараахийг хийтэл цаашдын алхмыг хийхгүй: (i) өртсөн нийгмийн бүлгүүдтэй итгэлцэл сайн санааны хэлэлцээ хийх; (ii) тэдний мэдээлэлтэй оролцоо болон хэлэлцээний амжилттай үр дүнг баримтжуулах.

Соёлын өвийг төсөл ашиглах нь

19. Хэрэв төсөл нь уламжлалт амьдралын хэв маягийг биежүүлж байгаа уугуул хүмүүсийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаачилга эсхүл практикийг арилжааны зорилгоор ашиглах санал тавибал үйлчлүүлэгч уугуул хүмүүст: (i) үндэсний хуулиар олгогдсон тэдний эрх; (ii) санал болгосон арилжааны хөгжлийн цар хүрээ ба шинж чанар; (iii) тийм хөгжлийн боломжит үр дагаврын тухай мэдээлнэ. Хэрэв тэр дараахийг хангахгүй бол үйлчлүүлэгч тийм ашиг хонжоо олох ажлаар хөөцөлдөхгүй: (i) уламжлалт амьдралын хэв маягийг биежүүлж байгаа уугуул хүмүүсийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй сайн итгэлцлийн хэлэлцээ хийх; (ii) тийм ажиллагаа явуулах тэдний мэдээлэлтэй оролцоо болон тэдний чөлөөтэй, урьдчилсан, мэдээлэлтэй зөвшөөрөл олгохыг баримтжуулсан байх; болон (iii) тэдний ёс заншил ба уламжлалтай холбоотой тийм мэдлэг, шинэ санаачилга эсхүл практикийг ашиг хонжоо олох үйл ажиллагаанд чиглүүлснээс олох ашиг тусыг шударга, тэнцүү хуваах явдлыг хангах. Хэрэв төсөл нь уугуул хүмүүсийн соёлын баялаг, мэдлэг, шинэ санаа эсхүл практикийг ашиглахыг санал болгож байгаа бол ГШ 7-ийн 37-р зүйлийн шаардлагуудыг хэрэглэнэ.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 9: Санхүүгийн зуучлагчид

Танилцуулга

1. Санхүүгийн зуучлагчид /СЗ/ бол тогтвортой санхүүгийн зах зээлийг хөхүүлэн дэмжих ЕСБХБ-ны гол хэрэгсэл бөгөөд ЕСБХБ-ны санхүүжилтийг бичил, жижиг болон дунд хэмжээний үйлдвэрийн /ЖДҮ/ салбарт хуваарилах механизм юм. Өөрийн түнш СЗ-дын сүлжээгээр дамжуулан ЕСБХБ эдийн засгийн хөгжлийг үйлдвэрийн хэмжээнд дэмжих чадвартай, энэ нь ЕСБХБ-ны шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлдгээс жижиг юм. ЕСБХБ янз бүрийн санхүүгийн үйлчилгээг хүргэгчдийг дэмждэг, үүнд бусдын дунд хувийн үнэт цаасны сан, банк, түрээслэгч компани болон тэтгэврийн сангууд ордог. СЗ-ид өргөн хүрээний ажиллагаанд оролцдог, тухайлбал бичил санхүү, ЖДҮ-т зээд олгох, худалдааны санхүүжилт, дунд ба урт хугацааны корпоратив эсхүл төслийн санхүүжилт болон орон сууцны санхүүжилт.
2. Зуучлалын санхүүжилтийн мөн шинж чанар нь ЕСБХБ нь хэлцлийн үнэлгээ болон мониторинг, мөн бүхэл үнэт цаасны менементийн төлөөх хариуцлагыг СЗ-дад шилжүүлж байгааг илтгэж байна. Байгаль орчны болон нийгмийн эрсдлийн менежмент нь СЗ-дад шилжүүлсэн хариуцлагын нэгэн хэсэг болно. Гэсэн ч түүний СЗ-тай тогтоосон харилцааны улмаас ЕСБХБ-ны үнэлгээ болон мониторингод бөгөөд СЗ-дын бизнесийн ажиллагаатай холбоотой байгаль орчны болон нийгмийн эрсдлийн асуудалд СЗ-ид хангалттай хариу барьж чадсан эсэхэд тавих сонирхол хэвээр үлдэнэ. Шилжүүлэлтийн болон ЕСБХБ-ны хяналт тавих нарийн арга зам хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд үүнд СЗ-дын шинж чанар ба тэдгээрийн бизнесийн ажиллагаа, олгож буй санхүүжилтийн төрөл ба тухайн орон доторхи бизнесийн орчин зэрэг орно.

Зорилтууд

3. Энэ ГШ-ын зорилтууд бол:
 - Тогтвортой хөгжлийг дэмжих Банкны эрхэм эрх үүргийг СЗ-дын хөрөнгө оруулалтанд арилжааны санхүүгийн секторт байгаа олон улсын шилдэг практикийн дагуу хэрэгжүүлэх практик арга замыг тодоорхойлох;
 - СЗ-дын бизнесийн ажиллагаатай холбоотой байгаль орчны болон нийгмийн эрсдлийн менежментийг хийх боломжийг тэдэнд олгох ба тэдний үйлчлүүлэгчдийн дунд байгаль орчны болон нийгмийн бизнесийн сайн практикийг дэмжин дэлгэрүүлэх;
 - СЗ-дын хүрээнд байгаль орчны болон хүний нөөцийн сайн менежментийг дэмжин хөхүүлэх.

Хэрэглээний цар хүрээ

4. Энэ Гүйцэтгэлийн шаардлага Бодлогын 24-р зүйлийн дагуу “СЗ” гэсэн зэрэглэлтэй бүх төсөлд хамаарна.
5. Энэ ГШ-ын зорилгоор “төсөл” хэмээх үгийг ЕСБХБ болон СЗ хоорондын хэлцэлд хамааруулан хэрэглэнэ, харин “дэд төсөл” хэмээх үгийг СЗ-аас санхүүжүүлж байгаа үйлчлүүлэгч/төсөлд хамааруулан хэрэглэнэ.

6. Хэрэв ЕСБХБ зээлийн шугам эсхүл бусад сонгосон санхүүгийн хэрэгслийг санхүүжүүлж байгаа бол энэ ГШ-ын шаардлагууд ЕСБХБ-ны хөрөнгийг ашиглан санхүүжүүлж байгаа бүх дэд төсөлд хамаатай.
7. Хэрэв ЕСБХБ СЗ-д үнэт цаасны болон бэлэн мөнгө, үнэт цаасны холимог санхүүжилтийг олгож байгаа бол энэ ГШ-ын шаардлагууд ЕСБХБ доорхи 16-р зүйлийн дагуу хувьцаа эзэмшигч эсхүл хөрөнгө оруулагч болсон цагаас эхлэн бий болсон СЗ-ийн арилжааны дэд төслүүдийн бүхэл багцад хамаарна.
8. Хэрэв ЕСБХБ нь СЗ-ийн төслийг хамгийн бага эсхүл байгаль орчны болон нийгмийн сөрөг эрсдэлгүй төсөл гэж үзвэл онцгой шаардлагууд хамаагүй болж, тэгээд СЗ байгаль орчны болон нийгмийн эрсдлийн менежментийн аливаа горим журмыг нэвтрүүлэх шаардлагагүй болно.

Шаардлага

Байгаль орчны болон нийгмийн зохистой ажиллагаа ба мониторингийн горим журам

9. СЗ нь түүний ажиллагаатай холбоотой байгаль орчны болон нийгмийн эрсдлийн түвшинтэй болон ЕСБХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа төслийн төрөлтэй дүйцэхүйц байгаль орчны болон нийгмийн зохистой ажиллагаа болон мониторингийн горим журам /цаашид “горим журам” гэх/-ыг баталж хэрэгжүүлнэ. Эдгээр горим журмыг ЕСБХБ-тай тохиролцоно.
10. Хэрэв СЗ байгаль орчны болон нийгмийн эрсдлийн менежментийн горим журмын багцтайгаа харуулж чадвал ЕСБХБ тэдгээрийн агуулгыг болон СЗ-ийн хэрэгжүүлэх чадварыг энэ ГШ-ын шаардлагуудтай тулган хянан нягтална.
11. СЗ нь энэ горим журмыг доорхи 13-16-р зүйлсийн шаардлагыг хангахаар төсөвлөнө. Горим журам нь мөн эрсдлийг үнэлэх, мониторинг хийх механизмыг зохистойгоор багтаах бөгөөд түүнд дараах орно:
 - санал болгосон дэд төслүүдийн эрсдлийн зэрэглэл;
 - үйлчлүүлэгч болон дэд төслүүдийн талаар илрүүлсэн эрсдлүүдтэй дүйцэхүйц зохистой ажиллагааг явуулах;
 - дэд төслүүд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр болон олон нийтийн зөвлөлдөөний талаарх үндэсний шаардлагыг хангаж байхаар тэднийг бүтэцжүүлэх, шаардлатай бол үйлчлүүлэгчдээс засч залруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаардах ;
 - дэд төслүүд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөр болон олон нийтийн зөвлөлдөөний талаарх үндэсний шаардлагыг хангах, зохих нөхцөлд засч залруулах арга хэмжээний төлөвлөгөөний мониторингийг хийх.
12. Горим журмыг практикт нэвтрүүлэхэд СЗ-дад туслахын тулд ЕСБХБ байгаль орчин болон нийгмийн эрсдлийн менежментийн гарын авлага (“EManual”) –г боловсруулсан хийгээд тэр нь загвар Горим журам болон СЗ-дын янз бүрийн төрөлд болон санхүүгийн үйлчилгээнд зориулсан удирдамжийг мөн багтаадаг. Адил тэнцүү горим журмыг нэвтрүүлээгүй СЗ-аас холбогдох дэд төслүүдийн хувьд ЕГарын авлагын холбогдох хэсгүүдийг ашиглахыг шаардаж байна.

Дэд төслүүдэд тавих шаардлага

13. Энэ ГШ-ын хавсралтанд тусгасан Банкны Байгаль орчин болон нийгмийн хасалтын жагсаалттай тулган СЗ-ид бүх дэд төслүүдийг шалгана. Тэр жагсаалтанд

14. Энэ ГШ-ын 2-р хавсралт нийгмийн байгаль орчны онцгой өндөр эрсдэлтэй хэд хэдэн бизнесийн ажиллагааг багтаадаг. Хэрэв дэд төсөл энэ ГШ-ын 2-р хавсралтан заасан ажиллагааг оролцуулж байвал СЗ тэр дэд төслийг Банкинд явуулах бөгөөд уг дэд төслийг ЕСБХБ-ны зохих Гүйцэтгэлийн шаардлага /ГШ/-тай харьцуулан тэмдэглэсэн байх явдлыг хангана. ЕСБХБ СЗ-дыг эдгээр дэд төслүүдийг өөрсдийн зохистой ажиллагааны процессын эхний шатуудад хэлэлцэхийг хүчтэй дэмжиж байна. ЕСБХБ тэдгээр дэд төслийн үнэлгээг хийхэд нь СЗ-дад тусална. ЕСБХБ-ны байгаль орчны/нийгмийн мэргэжилтнүүд СЗ-ын цуглуулсан зохистой ажиллагааны мэдээллийг нягтлан хянаж, нэмж шаардагдах мэдээллийг тодорхойлж, зохих саармагжуулах арга хэмжээг тодорхойлоход нь тусалж, шаардлагатай бол дэд төслүүд цаашдаа хэрэгжих боломжтой нөхцлийг тодорхой зааж өгнө.
15. СЗ-ид нь бүх үйлчлүүлэгчээс дараахтай холбоотой үндэсний журам, стандартыг мөрдөхийг шаардана. Үүнд: (i) байгаль орчин, (ii) олон нийтийн зөвлөлдөөн, (iii) ажил эрхлэлт, үүнд ямар нэгэн хязгааргүй мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа, хүүхдийн хөдөлмөр, албадан ажил эрхлэлт, үүнд ямар нэгэн хязгааргүй хөдөлмөр, ажил эрхлэлттэй холбогдсон ялгаварлан гадуурхалт, мөн холбоо байгуулах ба хамтын хэлэлцээ хийх чөлөө багтана.
16. Хэрэв СЗ-ид ЕСБХБ-ны зээлийн шугамаар дэд төслүүдэд нийт төслийн капиталын өртөг 10 сая бөгөөд түүнээс дээш ам. доллар болох төслийн санхүүжилт¹ олгож байгаа бөгөөд тэд нь (i) шинэ хөгжил, эсхүл (ii) одоогийн байгууламжийн өргөтгөл эсхүл сайжруулалтыг оролцуулсан хийгээд цар хүрээнд орох өөрчлөлт нь үлэмж нэмэгдэл байгаль орчны болон нийгмийн нөлөөг үүсгэхээр бол тэдгээр дэд төсөл ЕСБХБ ГШ 1-8 ба 10-ын шаардлагыг хангах ёстой.
17. ЕСБХБ нь СЗ-ийн шинж чанар, түүний багц болон ажиллаж байгаа орноос² шалтгаалан нэмэгдэл эсхүл альтернатив байгаль орчны болон нийгмийн шаардлагуудыг тогтоож болно.

СЗ-ийн доторхи зохион байгуулалтын чадвар

¹ Төслийн санхүүжилт бол “зээлдүүлэгч цорын ганц төслөөс олох орлого нь буцаан төлөлтийн эх үүсвэр болон хэцүү үед баталгаа болоход анхаарлаа төвлөрүүлдэг санхүүжилтийн арга юм”. Санхүүжилтийн энэ төрлийг ихэнхдээ том, хэцүү болон үнэтэй байгууламжууд, тухайлбал эрчим хүчний үйлдвэр, химийн боловсруулах үйлдвэр, уурхай, тээвэрлэлтийн дэд бүтэц, байгаль орчин болон телехолбооны дэд бүтцийн хувьд хэрэглэдэг. Төслийн санхүүжилт нь шинэ үндсэн хөрөнгийн байгууламжийг барихыг санхүүжүүлэх, эсхүл сайжруулалттай эсхүл сайжруулалтгүйгээр одоо байгаа байгууламжийг дахин санхүүжүүлэх хэлбэрийг авч болох юм. Ийм хэлцлүүдэд зээлдүүлэгчид байгууламжийн бүтээгдэхүүнийг худалдах гэрээнээс орж ирэх мөнгөнөөс төлдөг, тухайлбал эрчим хүчний үйлдвэрээс зарсан цахилгааны мөнгөнөөс. Зээлдэгч голдуу ТЗААН /Тусгай зориулалтын аж ахуйн нэгж/ байдаг тэгээд тэр байгууламжийг босгох, эзэмших ба ажиллуулахаас өөр ямар нэгэн функцийг биелүүлэх зөвшөөрөлгүй байдан. Үр дагавар нь бол буцаан төлөлт голдуу төслийн бэлэн мөнгөний урсгал болон төслийн активуудын барьцааны үнээс шалтгаалдаг. Эх үүсвэр: Банкны хяналтын Базелийн хороо, Үндсэн хөрөнгийн хэмжилт ба капиталын стандартын олон улсын конвергенци (“Базель II), 2005 оны 11-р сар. <http://www.bis.org/publ/bsbs118.pdf>.

² Тухайлбал, тухайн орон ОУХБ-ын үндсэн конвенциудыг батамжлаагүй /ОУХБ-ын конвенци 29 ба 105 (албадан ба хамжлагат хөдөлмөл), 87 (холбоо байгуулах эрх чөлөө), 100 ба 111 (ялгаварлан гадуурхах), 138 (доод нас), 182 (хүүхдийн хөдөлмөрийн хамгийн адгийн хэлбэрүүд) ба тэдгээрийг үндэсний хуульд шилжүүлсэн.

18. СЗ нь ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 2 - Хөдөлмөр ба ажлын нөхцөл - ийн дагуу хүний нөөцийн бодлого, менежментийн систем болон практикийг мөрдлөгө болгоно

19. СЗ нь байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг бүхэлд нь, үүний дотор горим журмын хэрэгжилтийг хариуцсан менежментийн гишүүнийг томилно.

20. СЗ-ийн хэмжээ болон түүний ажиллагаанаас шалтгаалан СЗ нь мөн: (i) горим журмын өдөр тутмын мөрдөлтийг хянах болон хэрэгжилтэнд туслалцаа үзүүлэх нэг эсхүл түүнээс олон ажилтнуудыг томилох; (ii) боломжит өндөр байгаль орчны болон нийгмийн эрсдэлтэй хэлцлүүдийг үнэлэх зохих техникийн мэдлэг, туршлагатай, байрны дотор ба гадаа ажиллах мэргэжилтнүүдийг бэлэн байлгах явдлыг хариуцах ёстой.

21. СЗ нь горим журам болон 9 – 20 зүйлүүдэд туссан шаардлагуудыг холбогдох бүх ажигтанд тод тодорхой хүргүүлэх явдлыг хангаж, ажилтнууд шаардагдах чадвараар ба түүний дэмжлэгээр хангагдсан байх үүднээс зохих сургалт явуулна. .

ЕСБХБ-д тайлагнах

22. СЗ нь ЕСБХБ-д горим журмын хэрэгжилт болон түүний хөрөнгө оруулалт/зээлийн багцын байгаль орчны болон нийгмийн асуудлуудын гүйцэтгэлийн талаар үе үе /голдун жилийн/ тайланг хүргүүлнэ. Тайлангийн стандарт хэлбэрийг ЕГарын авлагад оруулсан болно.

Сонирхогч этгээдүүдийн оролцоо

23. СЗ нь байгаль орчны болон нийгмийн асуудлуудаар гадны харилцаа холбоотой ажиллах системтай болно, тухайлбал байгаль орчны болон нийгмийн асуудлуудтай холбоотой олон нийтийн асуулга, санаа зоволттой ажиллах холбооны цэг байгуулна. СЗ нь тэдгээр асуулга, санааны зовиурт тухай бүр, хугацаанд нь хариу өгч байна.

Шилдэг практик

24. ЕСБХБ нь өөрийн бүх СЗ-дыг өөрсдийнхөө зээлийн ба хөрөнгө оруулалтын ажиллагаанд тогтворжуулалтын менежментийн шилдэг практикийг тэд ЕСБХБ-наас санхүүжигдэж байгааг үл харгалзан даган мөрдөхийг дэмжин уриалж байна. Ялангуяа СЗ-ыг дараахийг нэвтрүүлэхийг уриалан дэмжиж байна:

- өөрсдийнхөө гадны хувь эзэмшигчдэд байгаль орчны болон нийгмийн асуудлуудыг өөрсдийн бизнес болон ажиллагаанд хэрхэн шийдвэрлэдэг талаар үе үе тайлагнах. Үүнийг, жишээлбэл, СЗ-ийн жилийн тайланд, вебхуудасд эсхүл өөр олон нийтийн хүртээл болох баримтанд энэ ГШ-д тусгасан шаардлагуудыг хангахад тэдний чин эрмэлзлийг нэгдгэсэн хэсгийн оруулах замаар хийж болно.
- шилдэг практикийг байрны доторхи байгаль орчны менежментэд хэрэглэх чиглээлийн ажил /үүнд эрчим хүч ба баялгийн ашигт ажиллагаа, хаягдлын багасалт ба дахин боловсруулалт орно/.
- Горим журам болон ЕГарын авлагын тэдний бүх бизнесийн ажиллагаанд тэлэн хэрэглэх, энэ ГШ хамаагүй ч буйг оролцуулан.
- Зохимжтой тохиолдолд байгаль орчны болон/эсхүл нийгмийн өндөр ашиг тустай санхүүгийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломжийг илрүүлэх /тухайлбал, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, нөхөн сэргэгдэх эрчим хүч эсхүл биологийн олог төрөл зүйлсийг дэмжих хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан бүтээгдэхүүн, бичил бизнес эрхлэгчдэд зээл олгох/.

Шилдэг практикийн тухай нэмэлт удирдамж ЕСБХБ-ны ЕГарын авлагад байгаа. СЗ нь санхүүгийн салбарт шилдэг практикийг дэмждэг зохих олон улсын санаачлагуудад нэгдэх асуулдлыг авч үзэх хэрэгтэй, тухайлбал Эквадорын зарчмууд, НҮБОХ-ийн Санхүүгийн санаачилга ба Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд¹ г.м.

¹ www.equator-principles.com; www.unepfi.org; www.unpri.org .

ГШ 9 Хавсралт 1:

ЕСБХБ Байгаль орчны болон нийгмийн хасалтын жагсаалт

ЕСБХБ мэдэж байгаад дараахийг агуулсан төслүүдийг шууд эсхүл шууд бус санхүүжүүлэхгүй. Үүнд:

а) Хүлээн авагч орны /өөрөөр хэлбэл, үндэсний/ хууль тогтоомж, олон улсын конвенци ба гэрээ эсхүл олон улсын аажмаар багасгах ажиллагаа, хоригийг зөрчсөн аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах, аливаа үйл ажиллагаа:

(i) ПФБ: Полифлоринатжуулсан бифенил ⁴ агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эсхүл худалдах

(ii) Олон улсын аажмаар багасгах ажиллагаа, хоригийг зөрчсөн эм, пестицид/гербицид болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, худалдах ⁵

(iii) Олон улсын аажмаар багасгах ажиллагаанд хамаарах озоныг цөллөх бодисыг үйлдвэрлэх, худалдах ⁶

(iv) Зэрлэг ан амьтныг худалдах, Trade in wildlife or production of or trade in wildlife products regulated under ХЗОУХК-аар зохицуулагддаг зэрлэг ан амьдыг эсхүл зэрлэг аймгийн бүтээгдэхүүнийг худалдах, үйлдвэрлэлд ашиглах ⁷

(v) Олон улсын хуулиар хориглогдсон хил давуулан хаягдал зөөвөрлөх ⁸

b) Асбестосын наалдаагүй зөөлөн эд эсхүл асбестос агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах ⁹

c) Байгалийн олон төрөлхт байдлыг эсхүл соёлын өв уламжлыг хамгаалах хүлээн авагч орны хууль тогтоомж ба олон улсын конвенциор хориглосон үйл ажиллагаа ¹⁰

d) 2.5 км ба илүү урт тор ашиглан далайд тор хөвүүлэн загас барих

e) ИМО шаардлагыг ¹¹ хангаагүй ачааны тээврийн онгоцонд /танкер/ газрын тос болон бусад аюултай бодис материалыг тээвэрлэх

f) Шаардлагатай экспорт эсхүл импорт лицензгүй, эсхүл холбогдох орнуудын экспорт, импорт, зохимтой бол транзитын эрх бүхий зөвшөөрөлгүйгээр барааг худалдаалах.

⁴ ПФБ: Полифлоринатжуулсан бифенил маш хортой химийн бодисын бүлэг. ПФБ-ыг 1950-1985 оны тосоор дүүргэсэн цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжинд олж болно.

⁵ Иш баримтууд нь бол: Зарим аюултай химийн бодисын экспорт ба импортын тухай нэмэлт оруулсан ЕХ-ны журам /ЕЕС/ № 2455/92, Засгийн газруудаас хэрэглээ болон/эсхүл худалдааг нь хорисон, татан авсан, хатуу хязгаарласан эсхүл батлаагүй бүтээгдээний НҮБ нэгдсэн жагсаалт, Олон улсын худалдаанд зарим аюултай химийн бодис болон пестицидэд урьдчилсан мэдээлэлтэй зөвшөөрөл олгох горим журмын тухай Конвенци /Роттердамын Конвенци/, Тэсвэртэй органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенци, ДЭМБ-ын пестицидын аюулын ангилалал.

⁶ Озоныг цөллөх бодисууд /ОЦБ/: Өргөнөөр нийтлэгдсэн “озоны нүх” бий болгохо хүргэдэг стратосферийн озонтой урвалд орж түүнийг цөллөдөг химийн бодисууд. Монреалийн Протокол ОЦБ-ыг , тэдний зорилтот багалгалт ба аажмаар устгах хугацааг тоочсон байдаг. Аэрозоль, хөргөх бодис, хөөс үлээгч бодис, уусгагч

болон галаас хамгаалах бодисыг багтаасан Монреалийн Протоколоор зохицуулагддаг химийн бодисын жагсаалтыг гарын үсэг зурагч орнуудын нарийвчлал болон устгах зорилгот хугацааны хамт ЕСБХБ авч болно.

- ⁷ ХЗОУХК: Амьтны болон ургамлын аймгийн ховордсон зүйлсийн олон улсын худалдааны тухай Конвенци. ХЗОУХК-ар хамгаалагдсан зүйлсийн жагсаалтыг дараахаас харж болно: www.cites.org/eng/app/index.shtml.
- ⁸ Иш татсан баримтууд: Хаягдал зөөвөрлөх тухай журам /ЕС/ №1013/2006, Нөхөн сэргээлтэд зориулсан хаягдлыг хил давуулан тээвэрлэлтэд тавих хяналтын тухай эцсийн Шийдвэр С/92/39-ийн өөрчлөлттэй хамаатай /ЭЗХАХБ-ын Зөвлөлийн эцсийн Шийдвэр С/2001/ 107, аюултай хаягдаыг хил давуулан тээвэрлэлт ба түүний устгалтад тавих хяналтын тухай 1989 оны 6-р сарын 14-ний Базелийн Конвенци.
- ⁹ Энэ нь наалдаастай асбест-цементен хамгаалалтын бүрхүүл /түүнд асбест <20% байх ёстой/ -ийг худалдан авах, ашиглахад хамаарахгүй.
- ¹⁰ Холбогдох олон улсын конвенциудад : Зэрлэг амьтдын нүүдлийг хамгаалах тухай Конвенци /Бонны Конвенци /, Convention; Олон улсын ач холбогдолтой намагдуу газар, ялангуяа Уотерфаулын орчны тухай Конвенци /Рамсар Конвенци/; Европын зэрлэг ан агтан ба Байгалийн орших газрыг хамгаалах тухай Конвенци /Берны Конвенци/; Дэлхийн өв удамшлын Конвенци; Биологийн олон төрөлхт байдлын тухай Конвенци ба Протоколууд орох хийгээд дээрхээр хязгаарлагдахгүй.
- ¹¹ Энэ нь: шаардагдах бүх УОБСОУК ДАААҮУК-ийн сертификат (үүнээр хязгаарлахгүйгээр, МДШМ кодод нийцэхгүй) ачааны хөлөг онгоцууд, Европын Холбооны хар жагсаалтад орсон ачааны онгоц эсхүл Боомтын улсын хяналтын таалаархи Ойлголцлын тухай Парижийн Санамж бичиг Парижийн /ОСБ/ -ийн шийдвэрээр хориглогдсон, мөн УОБСОУК13 G журмын дагуу аажмаар хасагдах танкерууд багтаана. Бүтэн бие нь 25 жилээс илүү болсон аливаа ачааны онгоцыг ашиглах ёсгүй.

ГШ 9 Хавсралт 2:

Дараах байгаль орчны эсхүл нийгмийн хувьд мэдрэмгий бизнесийн ажиллагааг СЗ-аас санхүүжүүлэхэд ЕСБХБ-наас лавлагаа авна.

Санал болгосон төслүүд хангах шаардлагатай үндсэн Гүйцэтгэлийн шаардлалыг налуу үсгээр тодорхойлов.

- a) Сайн дурын бус нүүлгэн шилжилтийг багтаасан ажиллагаа- *ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага*⁵
- b) Үндэсний хууль эсхүл олон улсын конвенцийн дагуу хамгаалалтын бүс дотор, түүний хажууд эсхүл дээд талд явуулах ажиллагаа, шинжлэх ухааны сонирхолтой талбай, цөөн/ховордсон зүйлсийн орчин, эдийн засгийн ач холбогдолтой загасны аж ахуй болон экологийн ач холбогдолтой анхны/эртний ой мод - *ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага* 6
- c) Уугуул хүмүүс болон/эсхүл эмзэг бүлгүүдийн эзэлж байгаа газар дотор, хажууд эсхүл дээд талд явуулах ажиллагаа, үүнд мал бэлчээх, ан хийх эсхүл загас барих мэтийн амь зуух ажиллагаанд ашигладаг газар ба гол горхиуд орно - *ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага* 7
- d) Соёлын эсхүл археологийн ач холбогдол бүхий талбайд сөргөөр нөлөөлж болох ажиллагаа - *ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага* 8
- e) Цөмийн түлш үйлдвэрлэх цикл /уран олборлох, цөмийн түлшний үйлдвэрлэл, баяжуулалт, хадгалалт эсхүл тээвэрлэлт/ дэх ажиллагаа¹²
- f) Цөмийн түлшийг ашиглан эрчим хүч гаргах (цахилгааны импорт/экспортыг оруулахгүй)¹³
- g) ГСО-ыг байгаль орчинд тавих ажиллагаа - *ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага* 6
- h) Жижиг усан хүрхрээ барих – *ЕСБХБ-ны Жижиг усан төслүүдийн Нийцэх боломжийн шалгуур үзүүлэлт*

¹² ЕСБХБ-ны Эрчим хүчний бодлогын дагуу Банкинд өөрийн санхүүжилтийг /шууд эсхүл СЗ-даар дамжуулан шууд бус/ цөмийн аюулгүй ажиллагааны сайжруулалт, радиоидэвхт хаягдал болон ашигласан цөмийн хаягдлын аюулгүй хийгээд баталгаатай менежмент, өндөр эрсдэлтэй реакторуудын хаалтанд шууд холбоогүйгээр ашиглалтаас гаргахтай холбогдуулан ашиглахыг зөвшөөрсөн юм. Тиймээс цөмийн түлш үйлдвэрлэх цикл дэх аливаа ажиллагааг СЗ-дын санхүүжилтээс хассан болно.

¹³ ЕСБХБ-ны Эрчим хүчний бодлогын дагуу Банкинд өөрийн санхүүжилтийг /шууд эсхүл СЗ-даар дамжуулан шууд бус/ цөмийн аюулгүй ажиллагааны сайжруулалт, радиоидэвхт хаягдал болон ашигласан цөмийн хаягдлын аюулгүй хийгээд баталгаатай менежмент, өндөр эрсдэлтэй реакторуудын хаалтанд шууд холбоогүйгээр ашиглалтаас гаргахтай холбогдуулан ашиглахыг зөвшөөрсөн юм. Тиймээс цөмийн түлшийг ашиглан эрчим хүч гаргах аливаа ажиллагааг СЗ-дын санхүүжилтээс хассан болно.

ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага 10:
Мэдээллийг ил тод болгох ба Сонирхогч этгээдүүдийн оролцоо

Танилцуулга

1.ЕСБХБ нь сонирхогч этгээдүүдийн оролцоог сайн бизнесийн практикийн чухал хэсэг болон корпоратив иргэншлийн чухал хэсэг болон төслүүдийн чанарыг дээшлүүлэх зам гэж үздэг. Ялангуяа, нийгмийн бүлгийн үр дүнтэй оролцоо нь төсөлд өртсөн нийгмийн хэсэгт учрах эрсдэл болон нөлөөний амжилттай менежментад, мөн нийгмийн бүлгийн сайжруулсан ашиг туст хүрэхэд гол зүйл юм.

2.Ялангуяа байгаль орчны асуудлуудаар Банк НҮЕЭЗК Аархус Конвенцийн хандлагыг дэмждэг бөгөөд тэр нь байгаль орчныг *нийтийн бараа* хэмээн тодорхойлдог. Конвенци нь байгаль орчны байдал, түүнд ямар эмисс болон ялгаруулалтыг гаргаж байгааг олон нийт мэдэх эрх, мөн байгаль орчинд нөлөөлж болох санал болгосон төсөл эсхүл хөтөлбөрийн талаар утга учиртай зөвлөлдөөн хийх эрх, хэрэв тэд байгаль орчныг анхааралдаа хангалтгүй авсан гэдэгт итгэж байгаа бол гомдол гаргах эрхийг нь баталгаажуулж байгаа юм.

3.Хувь эзэмшигчдийн оролцоо бол (i) утга учиртай зөвлөлдөөн хийхийн тулд үйлчлүүлэгчээс зохих мэдээллийг ил тод болгох (ii) өртөж болзошгүй талуудтай хийх утга учиртай зөвлөлдөөн, ба (iii) хүмүүс шүүмжлэл эсхүл гомдол гаргах горим журам буюу бодлогыг агуулсан үргэлжлэн явагдах процесс юм. Энэ процесс төслийн төлөвлөлтийн аль болох эртний үе шатанд эхэл, төслийн бүхий л хугацаанд үргэлжлэх ёстой.

Зорилтууд

4.Энэ Гүйцэтгэлийн шаардлага /"ГШ" / сонирхогч этгээдүүдийн оролцооны талаархи системийн хандлагыг тоймлож байгаа бөгөөд тэр нь үйлчлүүлэгчид сонирхогч этгээдүүдтэй, ялагуяа орон нутгийн өртсөн нийгмийн бүлгүүдтэй бүтээлч харилцаа тогтоож, урт хугацаанд хадгалахад тусална. Сонирхогч этгээдүүдийн оролцооны процесс нь үйлчлүүлэгчийн хөрөнгө оруулалттай холбоотой байгаль орчны болон нийгмийн асуудлуудын үнэлгээ, менежмент ба мониторингийг хийх явдлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тиймээс энэ гүйцэтгэлийн шаардлагыг ГШ 1-ийн хамт уншвал зохино.

ГШ 1 ба ГШ 10-ын өвөрмөц зорилтууд дараах болно:

| Байгаль орчны болон нийгмийн үнэлгээ ба менежмент (ГШ 1) | Мэдээллийг ил тод болгох ба сонирхогч этгээдүүдийн оролцоо (ГШ 10) |
|--|---|
| <ul style="list-style-type: none"> • Төсөлтэй холбоотой байгаль орчны болон нийгмийн сөрөг бө эерэг нөлөө, асуудлыг илрүүлэх, үнэлэх; • Ажилчид, өртсөн нийгмийн бүлэг болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөнөс зайлсхийх, хэрэв зайлсхийх боломжгүй бол түүнийг багасгах, саармагжуулах эсхүл баланслуулах/ нөхөн олговор олгох арга хэмжээг батлах; • Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг илрүүлэх, боломжтой бол батлах; | <ul style="list-style-type: none"> • Төсөлд өртөх магадлалтай хүмүүс, нийгмийн бүлгүүдийг, мөн бусад сонирхогч талуудыг тодорхойлох; • Мэдээллийг ил тод болгох ба утга учиртай зөвлөлдөөний процессын явцад тэдэнд нөлөөлж болох байгаль орчны болон нийгмийн асуудалд сонирхогч этгээдүүд зохих ёсоор оролцох явдлыг хангах; • Төслийн хэрэгжилтийн явцад утга учиртай оролцоогоор сонирхогч этгээдүүдтэй тогтоосон бүтээлч харилцааг үргэлж хадгалж байх. |

| | |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэлийн мониторинг ба үнэлгээний динамик процессоор сайжруулсан байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийг дэмжих. | |
|--|--|

Хэрэглээний цар хүрээ ¹

5.Энэ ГШ-ын холбогдох шаардлагуудыг үйлчлүүлэгчийн бүхэл байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процесс, байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /БОНАХТ/ болон/эсхүл менежментийн систем /ГШ 1-т тоймлосон/-ийн хэсэг болгон биелүүлэхийг Банк үйлчлүүлэгчтэй тохирно.

Шаардлага

6.Сонирхогч этгээдүүдийн хэлэлцээ нь булхай, гадны оролцоо, албадлага, сүрдүүлгээс чөлөөтэй байх бөгөөд хугацаат, хамаатай, ойлгомжтой болон хүртэж болох мэдээллийн үндсэн дээр соёлын зохимжтой хэлбэрээр явагдана.

7.Өртсөн нийгмийн бүлгүүдэд учирсан эрсдэл болон сөрөг нөлөө, тухайн салбарын болон байгаль орчны мэдрэмгийн байдал ба олон нийтийн сонирхлын түвшингээс шалтгаалан сонирхогч этгээдүүдийн оролцооны шинж чанар болон давтамж нь төслөөс төсөлд өөр байж болно.Хэлэлцээрийг үйлчлэгч болон төслийн онцлогт тохируулахын тулд ЕСБХБ-ны санхүүжилтийг хайж байгаа бүх үйлчлүүлэгч байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессын эхний шатуудад доорхи 8-10-р зүйлд заасан алхмуудыг хийх нь нэн чухал юм. Банк нь өөрийн зохистой ажиллагааны нэг хэсэг болгон мэдээллийг нээлттэй болгох явдлын болон энэ ГШ-ын шаардлагад нийцүүлэн үйлчлүүлэгчтэй хийсэн зөвөлгөөний түвшинг үнэлэх бөгөөд нэмэлт хэлэлцээ хийхийг шаардаж болно. Нийтийн мэдээлэл болон зөвөлгөөнтэй хамаатай үндэсний хуулийн шаардлагыг, үүнд олон улсын хуулийн ² дагуу хүлээн авагч орон хүлээсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн хууль орно, үргэлж хангаж байх ёстой.

Төслийн бэлтгэлийн үеийн оролцоо

Сонирхогч этгээдийг тогтоох ба судалгаа хийх

8.Үйлчлүүлэгчийн хувьд амжилттай оролцогч талуудын хэлэлцэрийн эхний алхам бол (i) төсөлд өртсөн эсхүл өртөж мэдэх /шууд эсхүл шууд бус/ янз бүрийн хувь хүмүүс болон бүлгүүд /өртсөн талууд/, эсхүл (ii) төсөлд сонирхолтой байж мэдэх /”бусад сонирхолтой талууд”/-ыг илрүүлэх явдал юм. Олон нийтийн мэдээлэл болон зөвлөлдөөний хөрөнгө юуны өмнө өртсөн талууд руу чиглэгдсэн байх ёстой.

9.Сонирхогч этгээдийг тогтоох процессын нэгэн хэсэг болгон үйлчлүүлэгч өөрсдийн ядуу эсхүл эмзэг статусын улмаас төсөлд ялгавартай, пропорциональ бус өртөх магадлалтай хувь хүмүүс болон бүлгүүдийг тогтооно. Үйлчлүүлэгч мөн сонирхогч этгээдийн хэрхэн өртөж болохыг болон боломжит /бодит ба төсөөллийн/ нөлөөний хир хэмжээг тодорхойлно. Хэрэв нөлөө төсөөллийн бол нөлөөний түвшингийн тухай мэдээлэл болон баталгаагаар хангах нэмэлт холбо харилцаа шаардагдаж магадгүй. Банкинд хэлэлцэгдэж байгаа төсөлд зохимжтой холбоо харилцааны түвшинг тогтооход дөхөм болох үүднээс сонирхогч этгээдийг тогтоох ба судалгаанд

¹ Үүнээс гадна, онцгой байдлын бэлтгэл болон хариутай холбоотой тусгай заалтуудыг ГШ 4-д тусгасан.

² Тухайлбал, Эрхус ба Эспоо конвенциуд

тогтооход дөхөм болох үүднээс сонирхогч этгээдийг тогтоох ба судалгааг нарийвчлалын хангалтай түвшинд хийсэн байх ёстой. Ажилтнуудыг ямагт сонирхогч этгээдэд тооцдог.

10. А зэрэглэлийн төслийн тохиолдолд БОННУ процессын нэг хэсэг болгон шинжлэх бүх гол асуудлыг тодорхойлох явдлыг хангахын тулд үйлчлүүлэгч тогтоосон сонирхогч этгээдүүдтэй судалгаа тооцооны процесст оролцоно. Судалгаа тооцооны процесс нь мөн төсөлд зориулсан сонирхогч этгээдийн оролцооны төлөвлөгөөг боловсруулахад дөхөм болно. Судалгаа тооцооны процессын нэг хэсэг нь сонирхогч этгээд нь Сонирхогч этгээдийн оролцооны төлөвлөгөөний төсөл болон аливаа бусад судалгаа тооцооны баримтанд өөрийн шүүмжлэл болон зөвлөмжийг өгөх чадвартай байх ёстой.

Сонирхогч этгээдийн оролцооны төлөвлөгөө

11. Үйлчлүүлэгч ЕСБХБ-нд төслийн бэлтгэл ба хэрэгжүүлэлтийн явцад тогтоосон сонирхогч этгээдүүдтэй холбоо харилцааг хэрхэн барих, үүнд зарга гомдлын процессын төлийг тусгана /доорхи 24-26 –р зүйлсийг үзнэ үү/. Өртсөн талууд болон бусад сонирхогч талуудад оролцоо ба зөвлөлдөөний янз бүрийн түвшин зохимжтой байж болно. Үйлчлүүлэгч ажилчдын оролцоо болон өртсөн нийгмийн бүлгүүдийн оролцоонд зориулж тустаа процессудыг боловсруулах шаардлагатай; мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааг багтаасан ажлын нөхцлийн тухай яриа хэлэлцээ, ажлын байрны харилцаа наад зах нь ГШ 2-ын шаардлагыг дагах ёстой. Хэрэв сонирхогч этгээдүүдийн бүлгийг ядуу эсхүл эмзэг гэж тогтоосон бол шударга үнэнч хандлага ба нөөц болоцооны нэмэгдсэн түвшин тийм сонирхогч этгээдүүдтэй харилцахад шаардагдаж мэднэ, ингэснээр тэд өөрсдөд нь нөлөөлж байгаа асуудлуудын талаар бүрэн ойлгоцтой болно. ЕСБХБ-нд санхүүжилтийг хүсч очихоос өмнө үйлчлүүлэгчид мөн ЕСБХБ-д аливаа олсон мэдээлэл болон хийгдсэн зөвлөлдөөний ажиллагааны тухай мэдээлж байна.

Мэдээллийг ил тод болгох

12. Төсөлтэй холбоотой мэдээллийг ил тод болгох нь сонирхогч этгээдэд төслийн эрсдэл, нөлөөлөл болон боломжийг ойлгоход тус болно. Хэрэв нийгмийн бүлгүүд төслөөс үүсэх сөрөг байгаль орчны болон нийгмийн нөлөөнд өртөж болзошгүй бол үйлчлүүлэгч тэдэнд дараах мэдээллийг /"Мэдээлэл"/ нээж өгнө:

- төслийн зорилго, шинж чанар, цар хүрээ;
- санал болгосон төслийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа;
- байгаль орчин, ажилны эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа, нийтийн эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаанд учрах аливаа эрсдэл ба боломжит нөлөө болон нийгмийн бүлэгт тулгарч болох нийгмийн нөлөө ба санал болгосон саармагжуулалтын төлөвлөгөө;
- хэрэв байгаа бол тусгагдсан зөвлөлдөөний процесс болон олон нийт оролцож болох боломж, арга зам; ба
- төлөвлөсөн нийтийн уулзалтын цаг/болох газар, уулзалтын тухай мэдэгдэх, нэгтгэх ба тайлагнах процесс.

13. Мэдээллийг орон нутгийн хэл дээр, ойлгоход хялбар ба соёлын зохимжтой хэв маягаар ил тод болгох бөгөөд эмзэг хүмүүсийг анхааралдаа авна /тухайлбал, үндэсний цөөнхи эсхүл шилжин суурьшсан хүмүүс/. Нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үлэмж сөрөг нөлөөтэй төслүүдийн хувьд мэдээллийг ил тод болгох явдлыг байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессын эрт үе шатанд зохиох шаардлагатай.

14. Хэрэв байгаль орчны болон нийгмийн арга хэмжээний төлөвлөгөө /"БОНААТ"/-г тохирсон бол үйлчлүүлэгч А зэрэглэлийн төслийн БОНААТ-г өртсөн талуудад ил тод болгоно. Бусад бүх нөхцөлд үйлчлүүлэгч техникийн бус эмхэтгэлийг ил тод болгоно.

БОНААТ/эмхэтгэлийг 13-р зүйлийн дагуу ил тод болгох хийгээд байдаг бол мөн үйлчлүүлэгчийн веб хуудас дээр. Нэмэлт мэдээллийг төсөл урагшлах хирээр, төслийн шинж чанар эсхүл түүний нөлөөлөлд бодит өөрчлөлт орох, эсхүл шинэ бодит эрсдэл ба нөлөө үүсэх тохиолдолд, байнгын үндсэн дээр ил тод болгох шаардлагатай байж мэднэ. .

Утга учиртай зөвлөлдөөн

15. Сонирхогч этгээдийн тодорхойлолт, судалгаа болон төслийн нарийвчилсан дүрслэл дээр үндэслэн аливаа тодорхой зөвлөлдөөний хэрэгцээ болон шинж чанарыг ЕСБХБ-тай тохирох бөгөөд тэр нь ажилчид болон өртсөн нийгмийн бүлгүүдэд үзүүлэх одоогийн болон боломжит сөрөг нөлөөний шинж чанар болон хэмжээ хүрэнээс шалтгаална. Хэрэв ажилчид ба/эсхүл өртсөн нийгмийн бүлгүүд төслөөс үүсэх үлэмж эрсдэл эсхүл сөрөг нөлөөнд өртөх магадлалтай бол үйлчлүүлэгч утга учиртай зөвлөлдөөний процессын явцад өртсөн талууд төслийн эрсдэл, нөлөө болон саармагжуулах арга хэмжээний талаар өөрсдийн санал бодлыг илэрхийлэх, мөн тэгээд үйлчлүүлэгчид тэднийг авч үзэн, хариулах боломжийг олгох хэв барилаар явуулна. Утга учиртай зөвлөлдөөн

- Холбогдох ба хангалттай мэдээллийг ил тод болгох дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд үүний сацуу, хэрэв зохимжтой ба хамаатай байвал, шийдвэр гарахын өмнө, янз бүрийн хувилбар нээлттэй байсан үеийн баримт бичиг ба төлөвлөгөөний төслүүдийг багтаасан байвал зохино;
- Байгаль орчны болон нийгмийн үнэлгээний процессын эрт үе шатанд эхлэх ёстой;
- Нийгмийн болон байгаль орчны эрсдэл ба сөрөг нөлөөлөл, мөн санал болгосон арга хэмжээ болон ажил үйлсэд чиглэгдэх ёстой;
- Цаг хугацааны хамт аливаа асуудал, нөлөө болон боломжийн шинж чанар хувиран өөрчлөгддөг тул тогтмол үндсэн явуулж байна.

16. Зөвлөлдөөний процессыг өргөн оролцоотой ба соёлын зохимжтой арга хэлбэрээр явуулна. Үйлчлүүлэгч зөвлөлдөөний процессыг өртсөн талуудын хэлний сонголт, тэдний шийдвэр гаргах процесс болон ядуу эсхүл эмзэг бүлгүүдийн хэрэгцээтэй тохируулна. Зөвлөлдөөний процесс өртсөн бүлгүүдээс гадна бусад сонирхогч талууд гэж тодорхойлогдсон аливаа бүлэг ба хүмүүсийг багтаана. Зөвлөлдөөний процессыг олон нийтэд үйлчлүүлэгчээс өгсөн амлалт үүргийн нэг хэсэг болгон баримтжуулна. Үйлчлүүлэгч цаг алдалгүй нийтийн зөвлөлдөөнд оролцсон хүмүүст төслийн талаар гаргасан эцсийн шийдвэр, холбогдсон байгаль орчны болон нийгмийн сааруулах арга хэмжээ, орон нутгийн нийгмийн бүлгүүдэд төслөөс орох ашиг тус, шийдвэрийн үндэс болсон шалтгаан, бодол болон бэлэн байгаа зарга гомдлын механизм эсхүл процессын талаар мэдээлнэ.

А зэрэглэлийн төслүүдийн ил тод байдал болон зөвлөлдөөн

17. А зэрэглэлийн гэж ангилагдсан төслүүд шууд бэлхэн тогтоох, үнэлэх, сааруулах боломжгүй ирээдүйн үлэмж, элдэв, сөрөг байгаль орчны болон/эсхүл нийгмийн нөлөөг дагуулж болох тул албан ёсны хийгээд оролцооны үнэлгээний процесс шаардагдаж магадгүй. Ил тод байдлын болон зөвлөлдөөний шаардлага энэ процессын үе шат бүрт суулгагдсан юм. Үйлчлүүлэгч дээрхи 12 – 16-р зүйлсийн дагуу өртсөн талуудтай учир утгатай харилцан яриаг зохион байгуулж, шийдвэр гаргах процесст тэдний мэдээлэлтэй оролцоог дэмжих ёстой. Мэдээлэлтэй оролцоо нь үйлчлүүлэгчийн шийдвэр гаргах процесст өртсөн бүлгүүдэд шууд нөлөөлж байгаа санал болгосон саармагжуулалтын арга хэмжээ, хөгжлийн ашиг тус ба боломжийг хуваалцах болон хэрэгжүүлэлт мэтийн асуудлуудаар санал бодлыг тусгахад хүргэх зохион байгуулалттай болон давтагдах зөвлөлдөөнийг оролцуулдаг юм. Эмзэг хүмүүст тусгай нахаарал халамж тавих хэрэгтэй байж болох бөгөөд нөлөөг ойлгох болон өөрийн, утгатай хувь нэмрээ оруулахад хөрөнгө мөнгө шаардагдаж магадгүй.

18. БОНУ/ННУ –г оролцуулсан төслийн тохиолдолд үйлчлүүлэгч ил тод байдал болон зөвлөлдөөнийг 12 – 17-р зүйлсийн дагуу явуулах явдлыг хангах ёстой. Ил тод болгосон мэдээлэл нь Банкны шаардлагын ³ дагуу EIA/SIA-ы бүрэн тайланг оруулах ёстой. Үүнээс гадна, зөвлөлдөөний процесс нь Банкны Олон нийтийн мэдээллийн бодлогын 3.4.1-р зүйлд нарийвчлан заасан ЕСБХБ-ны ил тод болгохын цаг хугацааны шаардлага, мөн үндэсний БОНУ-ний хуулийн болон бусад хамаатай хуулийн холбогдох шаардлагуудыг хангах ёстой. БОНУ/ННУ төслийн ажиллагааны бүхий л хугацаанд нийтийн эзэмшилд байх ёстой боловч түүнийг үе үе нэмэлт мэдээллээр баяжуулж болно.

19. Уугуул хүмүүсийг эсхүл тэдний соёлын өвийг хөндсөн сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлтийг оролцуулсан төслийн тохиолдолд үйлчлүүлэгч ГШ 5, ГШ 7 ба ГШ 8-ын тусгай шаардлагуудыг хэрэглэнэ.

20. Хэрэв орон нутгийн нийгмийн бүлэг төслийн улмаас ноцтой хийгээд байнга сөрөг нөлөөнд автсан эсхүл автаж болзошгүй боловч түүнээс хангалттай ашиг тус олж авахгүй бол үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлгүүдтэй хамтран тэдэнд ашиг тус авчирч болзошгүй нийгмийн бүлгийн хөгжлийн хөтөлбөрийн хувилбаруудыг судлах утга учиртай арга замыг олно.

Төслийн хэрэгжилт ба гадны тайлагналтын үеийн оролцоо

21. Төслийн хэрэгжих хугацаанд тогтоосон сонирхогч этгээдүүдийг үйлчлүүлэгч төслийн шинж чанар, холбогдох байгаль орчны нөлөө болон нийтийн сонирхолтой дүйцэхуйц цаг тухайн мэдээллээр хангана. Энэ цаг тухайн оролцоо зохистой ажиллагааны процессын явцад тогтоосон холбоо харилцаа, оролцооны сувгууд дээр тулгуурлах ёстой. Энэ цаг тухайн оролцоо зохистой ажиллагааны процессын явцад тогтоосон холбоо харилцаа ба оролцооны сувгууд дээр тулгуурлах ёстой. Ялангуяа үйлчлүүлэгч мэдээлийг нээлттэй болгох хийгээд БОНАХТ-д туссан саармагжуулалтын арга хэмжээний хэрэгжүүлэлтийн үр ашгийн болон төсөлтэй холбоотой өнөөгийн сонирхол болон санаа зовнилтын талаар хариу мэдээлэл авахын тулд нийгмийн бүлгийн оролцооны зохистой практикийг ашиглах ёстой. Төслийн циклийн гол гол шатанд нэмэлт мэдээллийг ил тод болгох хэрэгцээ гарч мэднэ, жишээлбэл барилгын ажил эхлэхийн өмнө эсхүл үйлдвэрлэлийн ажиллагаа эхлэхэс өмнө.

22. Хэрэв өртсөн нийгмийн бүлгүүдийг төслийн бэлтгэлийн үед тогтоосон бол үйлчлүүлэгч тэднийг БОНАХТ-ний биелэлтийн явц, тэдэнд эрсдэл эсхүл нөлөө учруулах асуудлууд, мөн тэдгээр нийгмийн бүлгийн сэтгэл санааг зовоодог гэж зөвлөлдөөний процесс эсхүл зарга гомдлын механизмаар тогтоосон аливаа асуудлын талаар үе үеийн тайлангаар хангаж байна. Эдгээр тайлан нь өртсөн нийгмийн бүлгүүдэд ойлгогдох хэлбэрээр байх бөгөөд тэдний давтамж нь өртсөн нийгмийн бүлгүүдийн санаа зоволтод нийцсэн байх боловч жилд нэгээс доошгүй удаа байна. Хэрэв төсөлд бодит өөчлөлт орж, тэгснээр өртсөн нийгмийн бүлгүүдэд нэмэлт сөрөг нөлөө ба санаа зовоосон асуудлуудыг авчрах бол үйлчлүүлэгч тэдэнд тэдгээр нөлөө болон асуудлыг шинэчилсэн БОНАХТ-д

³ ЕХ-ны БОНУ-ний захирамжтай нийцэх БОНУ/ННУ-ий хэлбэрийг ЕСБХБ-наас авч болно.

хэрхэн шийдвэрлэснийг мэдээлнэ. Хэрэв өртсөн нийгмийн бүлгүүдэд учрах тэдгээр нэмэлт сөрөг нөлөө үлэмж бөгөөд янз бүрийн байх юм бол Банк 15 – 20-р зүйлсийн дагуу нэмэлт зөвлөлдөөнийг тохиодол тус бүрээр хийхийг шаардаж болно. Үйлчлүүлэгчийг тэр мэдээллийг өөрийн веб хуудас дээр бусад сонирхогч талд зориулан хэвлэхийг хөхүүлэн дэмжинэ.

23. Үүнээс гадна, үйлчлүүлэгчийг өөрийн байгаль орчны болон нийгмийн ажиллагааны талаар тогтмол тайланг гадны сонирхогч этгээдүүдэд зориулан хэвлэхийг хөхүүлэн дэмжинэ, жишээлбэл Жилийн тайлангийн эсхүл нийтэд тараах бусад баримтын нэг хэсэг болгон, эсхүл тусад нь хэвлэх, эсвэл веб хуудас дээрээ гаргаж болно.

Зарга гомдлын механизм

24. Үйлчлүүлэгч нь төсөлтэй холбоотой сонирхогч этгээдүүдийн санаа зовоосон асуудлуудыг мэдэж мэдрэн, цаг хугацаанд нь хариу өгч байх шаардлагатай. Энэ зорилгоор үйлчлүүлэгч нь түүний байгаль орчны болон нийгмийн ажиллагааны талаархи сонирхогч этгээдүүдийн санаа зоволт болон гомдлыг хүлээн авах, шийдвэрлэхэд дөхөм болох зарга гомдлын механизм, процесс эсхүл горим журмыг тогтооно. Зарга гомдлын механизмын далайцыг төслийн эрсдэл болон боломжит сөрөг нөлөөнд тохируулна.

25. Зарга гомдлын механизм, процесс эсхүл горим журам нь соёлын зохимжтой, өртсөн нийгмийн бүлгүүдийн бүх хэсэгт ойлгоход хялбар, ойлгомжтой болон ил тод процессыг ашиглан санаа зовоосон асуудлуудыг түргэн шуурхай болон үр дүнтэйгээр үнэгүй ба шийтгэлгүй шийдвэрлэж байх ёстой. Механизм, процесс эсхүл горим журам нь шүүх эсхүл засаг захиргаанд хандах явдалд саад тотгор учруулах ёсгүй. ГШ 5 эсхүл ГШ 7 хамаатай төслүүдийн хувьд үйлчлүүлэгч тэнд бие даасан, бодит зарга мэдүүлэх механизм байгааг хариуцна. Үйлчлүүлэгч өртсөн нийгмийн бүлгүүдэд зарга гомдлын механизмын тухай нийгмийн бүлгүүдийг татан оролцуулах ажиллагааны явцад мэдээлэх бөгөөд түүний биелэлтийг хүмүүсийн хувийн амьдралыг хамгаалан олон нийтэд тогтмол тайлагнаж байна.

26. Ажилчдад зориулсан зарга гомдлын механизм нийтийн зарга гомдлын механизмаас тустаа бөгөөд ГШ 2-ын дагуу байх ёстой.

Корпоратив санхүү

27. Олон талбайд үйл ажиллагаа явуулж байгаа үйлчлүүлэгч корпоратив ерөнхий санхүүжилт, ажлын капитал эсхүл үнэт цаасны санхүүжилтийг хүссэн үйлчлүүлэгч корпорацийн сонирхогч этгээдүүдийн тухай мэдээлэл болон дээрхи 22 – 25-р зүйлсийн дагуух зарга гомдлын механизмыг оруулсан холбоо харилцааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ. Сонирхогч этгээдүүдийн оролцооны хөтөлбөр нь компанийн бизнесийн шинж чанар ба түүнтэй холбогдох байгаль орчны болон нийгмийн нөлөө, түүнчилэн олон нийтийн сонирхолтой дүйцэхээр байна. Хөтөлбөрийг үйлдвэрлүүдэд цаг хугацаанд нь хүргэх ёстой. Энэ нь сонирхогч этгээдүүдийн хангалтга оролцоог үйлдвэрлэлийн түвшинд явагдах явдлыг хангах горим журам болон нөөц бололцоог багтаах бөгөөд үйлдвэрлэлд ойр сонирхогч этгээдүүд холбогдох үйлдвэрлэлийн байгаль орчны болон нийгмийн ажиллагааны тухай мэдээллийг хүлээн авах боломжоор хангана. Үйлчлүүлэгч нь наад зах нь жилд нэг удаа, тохирсон аливаа БОНМС/БОНАХТ –ий техникийн бус эмхэтгэл болон тохирсон үзүүлэлт ба зорилготой харьцуулан БОНМС/БОНАХТ–г хэрэгжүлснээр олсон амжилтыг оруулан наад зах нь жилд нэг удаа өөрийн байгаль орчны болон нийгмийн ажиллагааны тухай олон нийтэд зориулсан тайлаг гаргана. ЕСБХБ-ны Бодлогын дагуу А зэрэглэлд орох аливаа хөрөнгө оруулалтын төслийн хувьд үйлчлүүлэгч дээрхи 6- 20-р зүйлд тусгалаа олсон сонирхогч этгээдүүдийн оролцооны процессыг хэрэглэнэ.